



ХУУЛЬ САХИУЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2017 №4 (62) 15 дахь жилдээ



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

Доктор (Ph.D), профессор

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ

Доктор (Ph.D), профессор

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

Доктор (Ph.D), профессор

Бадам БАТЗОРИГ

Доктор (Ph.D), дэд профессор

Баатар БОЛДБААТАР

Доктор (Ph.D), профессор

Насанжаргал ГАНБАДРАЛ

Доктор (Ph.D), дэд профессор

Жамсран ДОЛГОРСҮРЭН

Доктор (Sc.D), профессор

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

Монгол Улсын гавьяат хуульч, доктор (Ph.D),
профессор

Авирмэд ЛХАГВА

Монгол Улсын гавьяат хуульч, доктор (Ph.D),
профессор

Ганбат ЭРДЭНЭБАТ

Улсын Ерөнхий Прокурорын орлогч, төрийн
хууль цаазын шадар зөвлөх

Батзэвэг ЭНХБОЛД

Доктор (Ph.D)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА

Доктор (Ph.D) дэд профессор

ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА

Доктор (Ph.D), дэд профессор

ЭХ БЭЛТГЭГЧ ДИЗАЙНЕР

Хүчитбаатар БАДНААЖОНОН



Гарчиг

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

“Зорчих эрхийг хязгаарлах ял ба хорих ялын төрөлд хийсэн Эдийн засгийн зардлын тооцоолол” судалгааны ажлын тойм	4
Эмнэлгийн эрх зүйн зөрчлийн судалгаа М.Цэрэнбат, Б.Тунгалагбайгаль, Б.Амарбаясгалан, Ж.Эрдэнэбулган, М.Еркебулан, Г.Эрдэнэбат, Г.Манилцэцэг, У.Цолмон, Б.Ариунжаргал	20
Шилжилтийн нийгэмд иргэдийн гэмт хэргээс айх айдас Ш.Чулуунбат,	26
Монгол Улс дахь зохион байгуулалттай гэмт хэргийн өнөөгийн байдал, түүнтэй тэмцэх арга зүйг боловсронгуй болгох нь А.Гансүх	39
Монгол улсын эдийн засгийн аюулгүй Байдалд хийсэн дүн шинжилгээ Ц.Батболд	50

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Эрүүгийн эрх зүй дэх халдашгүй байдлын тухай ойлголт, мөн чанар Г.Гантөмөр	56
Хорих ялыг дүйцүүлэн хасаж тооцоход математик статистикийн аргачлал хэрэглэсэн нь Б.Мөнхдорж	67
Эрүүгийн эрх зүйн эх сурвалжын уламжлалд хийсэн харьцуулсан судалгаа Б.Мөнхзаяа	74
Торгох ялын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал Ж.Баасанжав	81

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Цагдаагийн алба хаагчаас гав хэрэглэх аргачлал, анхаарах зарим асуудал Ш.Чулуун	85
Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэхийг судалсан судалгааны тойм Г.Бямбадорж	89
Монголын цагдаагийн байгууллагын гадаад харилцааны өнөөгийн байдал, чиг хандлага Ш.Тунгалаг	100

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Хүүхдийн өмчлөгч эрхийн баталгааг хангах нь Р.Батням	105
---	-----



КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

“ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ БА ХОРИХ ЯЛЫН ТӨРӨЛД ХИЙСЭН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ” СУДАЛГААНЫ ТОЙМ¹”

НЭГ. УДИРТГАЛ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Хууль тогтоомжийн үр нөлөөний судалгаа” гүйцэтгэх ажлын хүрээнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан ялын зарим төрлийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тоймлон тооцох буюу “хорих” болон “зорчих эрхийг хязгаарлах” ялын эдийн засгийн үр нөлөөг тооцох, түүн дотроо “хорих ял” болон “зорчих эрхийг хязгаарлах ял”-ын эдийн засгийн үр нөлөө, зардлыг урьдчилан тооцоолох шаардлага бий гэж үзсэний үндсэн дээр энэхүү судалгааг гүйцэтгэв.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжилттэй холбоотой маргаан дагуулж буй асуудал бол “хорих” болон шинээр бий болсон “зорчих эрхийг хязгаарлах” ялыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийгэм, эдийн засгийн нөхцөл бүрдсэн эсэхийг тодруулах явдал юм. Тухайлбал хорих ялын хугацааг тогтоохдоо “гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар /7 хоногоос 20 жил хүртэл²/, эсхүл 7 хоногоос бүх насаар нь хязгаарлах тухай заажээ³”. Мөн тус хуулийн 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хорих байгууллагыг нээлттэй, эсхүл хаалттай нөхцөлд, харуул хамгаалалтын 5 зэрэглэлтэй байхаар зохицуулсан байна.

Тус судалгааны зорилго нь дээр дурдсан 2 төрлийн ялыг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд гарах зардлыг тоймлон тооцох, улмаар эдийн засгийн хувьд төр, төрийн байгууллага хэр ачаалал хүлээх, нийгэмд үзүүлэх үр нөлөө ямар байх талаар судлах явдал бөгөөд эдгээрийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тойм байдлаар тооцож гаргах давхар зорилготой.

Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ зарим зүйл заалтад хийх эдийн засгийн үр нөлөөний судалгааг урьдчилан баталсан судалгааны ажлын удирдамжид

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгаа

² Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.6 дугаар зүйл. 3 дахь хэсэг.

³ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.6 дугаар зүйл. 1 дэх хэсэг.

тусгасан асуудлын хүрээнд баримт бичгийн судалгааны арга; задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх арга; харьцуулалтын арга; хууль зүйн техник, хууль тайлбарлах аргуудыг тус тус хэрэглэн хараат бус бие даасан, шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан судалгааны дүгнэлтэд хүрсэн бөгөөд энэ дүгнэлт нь зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэсэн болно.

Судалгааны багийн зөвлөхөөр Хууль зүйн судалгааны төвийн ЭНБД др.Х.Эрдэм-Ундрах ажиллаж судалгааны ажлын удирдамж, нарийвчилсан төлөвлөгөөг баталж, багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Бариаширсүрэн ахалж, Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Алтансүх, Б.Ундрах нар хамтран гүйцэтгэв.

Энэхүү судалгааг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомж хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэв.

Судалгааны ажлын үр дүнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.5 дахь зүйл “Зорчих эрхийг хязгаарлах ял” болон 5.6 дахь зүйл “Хорих ял”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах барилга байгууламж, хүний нөөц, тоног төхөөрөмж болон бусад холбогдох зардлын тооцоог ерөнхий байдлаар тооцож, холбогдох дүгнэлт гарсан байна.

Судалгааны ажлын хэрэгцээнд зориулан холбогдох тоо баримт, мэдээ, мэдээллээр судалгааны багийг дэмжиж ажилласан ШШГЕГ болон түүний харьяа Тогтоол гүйцэтгэх газарт талархал илэрхийлье.

ХОЁР. ХОРИХ АНГИ ШИНЭЭР БАРИХ ЗАРДАЛ

2002 оны Эрүүгийн хууль мөрдөгдөж эхэлснээс хойш жилд дунджаар 7-8 мянган хүн хорих ялыг биечлэн эдэлж, цаашид хорих ангид ял эдэлж байгаа хүний тоо буурах шинжгүй байгаа талаар судалгаануудад дурдах болсон. Улсын Их Хурлаас 2000, 2006, 2009 онуудад Өршөөл үзүүлэх тухай хуулийг тус тус батлан гаргаж, дунджаар 2500 орчим хүн суллагдаж, хорих ангид ял эдлэгсдийн тоо 4000 орчим болж буурдаг ч жилийн дотор эргээд хорих



ангийн дүүргэлт нэмэгддэг нь судалгаагаар тогтоогдсон. Хорих ял биечлэн эдлэгсдийн тоо өндөр байгаа нь хорих ангийн ачааллыг ихэсгэж, ялтан зарцуулах зардлын хэмжээ жил бүр нэмэгдэж, улсын төсөвт ачаалал үүсгэж байна.^[4]

Судалгаанаас үзэхэд 2012 оны байдлаар Монгол Улсад төвлөрсөн 25 хорих анги, баривчлах, цагдан хорих байр 26, баривчлах ял эдлүүлэх байр 13 байна.^[5] Эдгээр төвлөрсөн хорих ангид жилд нийтдээ 6911 ялтан ял эдэлж байгаа ба эдгээр ялтнуудад төрөөс нэг хүнд 10650 төгрөгийн урсгал зардал /хоол, хувцас, байрлаж буй байрны гэрэл, цахилгаан гэх мэт./ буюу нийт 6911 ялтан нэг өдөрт 73.602.150 төгрөг, жилд 26.864.784.750 зарцуулдаг байсан талаар судалгаа гарч байжээ.^[6] Энэ нь эдийн засгийн хувьд их хэмжээний зардал гарч байгаа буюу улсын төсөвт ихээхэн дарамт болж байгаа талаар судлаачид тэмдэглэжээ. Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан.

Уг хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу Эрүүгийн ял, албадлагын арга хэмжээг үр нөлөөтэй эдлүүлэх нөхцөл бололцоог хангах, хорих ялыг хувь хүний онцлогт тохируулан ялгамжтай эдлүүлэх, мөн хорих ял эдлэгсдийн тоог бууруулах, мөн хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны зардлыг бууруулахын тулд зорчих эрхийг хязгаарлах гэх шинэ төрлийн ялыг нэвтрүүлсэн. Мөн тус батлагдсан хуулийн дагуу хорих ялыг 7 хоногоос 20 жилийн хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих ангид эдлүүлэхээр тусгасан. Энэ нь ялын интервал уртсантай холбогдуулан хорих ангийн ачааллыг нэмэгдүүлж болзошгүй байдал үүсгэж байна. Жишээ болгон шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг түүвэрлэж үзэхэд долоо хоногоос 5 жил хүртэлх хугацаагаар ял оногдуулахаар төвлөрсөн 11 заалт байна.^[7]

Энэ нь хорих ангийн ачааллыг нэмэгдүүлж

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал.

⁵ Б.Нямгомбо, Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага, http://criminology.mn/print.php?id=160&lang=1#_ftn5.

⁶ Б.Нямгомбо, Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага, http://criminology.mn/print.php?id=160&lang=1#_ftn5.

⁷ Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 11.6, 11.7, 13.5, 16.7, 17.1, 17.5, 17.11, 20.15, 21.8, 24.6, 28.13 тус тус заалтуудад хорих ялыг 7 хоногоос 5 хүртэл жилийн хугацаагаар тогтоожээ.

болзошгүй бөгөөд ШШГЕГ-ын тайланд дурдсанаар шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх буюу хорих ялыг нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлэх, мөн нээлттэй, хаалттай хорих анги нь харуул хамгаалалтын “А”, “Б”, “В”, “Г”, “Д” зэрэглэлтэй байх шаардлагыг үндэслэн орон нутаг бүрт нээлттэй хорих анги байгуулах, хаалттай хорих ангийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай гэсэн эдийн засгийн тооцоолол гаргажээ.

2016 оны 9 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 5496 ял эдэлж буй сэжигтэн, яллагдагч, ялтан хоригдогдож байгаа бөгөөд үүнээс баривчлах ял эдэлж буй 119, цагдан хорих байранд 1000 сэжигтэн яллагдагч байна.^[8]

Өөрөөр хэлбэл шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6-д заасан ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй болон хаалттай хорих ангид ял эдлүүлэх талаар журамласан. ШШГЕГ-ын тайланд дурдсанаар “Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангахын тулд аймаг бүрт нээлттэй хорих анги байгуулах шаардлагатай. Мөн хорих ангиудыг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хэлтсийг бүсчлэн, бүсийн дунд 1-2 хаалттай хорих анги байгуулах шаардлагатай”^[9] гэсэн эдийн засгийн тооцоолол хийгдсэн байна. Энэхүү тайланд дурдсанаар нэг хорих ангид дунджаар 1 856 062 720 /нэг тэрбум найман зуун тавин зургаан сая жаран хоёр мянга долоон зуун хорин төгрөг/ шаардлагатай^[10] гэжээ.

Түүнчлэн уг тайланд дурдсанаар Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, Өмнөговь аймгийн Ханбогд сум, Ховд аймгийн Булган суманд Шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулах шаардлагатай гэсэн ба дээрх аймгуудад Шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад дараах хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэж үзжээ.

- Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад нийт 16 орон тоо, цалин, даатгалын зардалд 176,3

⁸ Тогтоол гүйцэтгэх газраас авсан статистик мэдээ. 2016.09.07

⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны урсгал төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний талаарх танилцуулга, 8.

¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нэг хэв маягийн “Нэг цэгийн үйлчилгээ бүхий контор, нээлттэй хорих байрны барилга угсралтын ажлын төсөв”.



сая төгрөг;

- Өмнөговь аймгийн Ханбогд суманд шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад нийт 21 орон тоо, цалин, даатгалын зардалд 231,3 сая төгрөг;

- Ховд аймгийн Булган суманд шийдвэр гүйцэтгэх хэлтэс байгуулахад нийт 21 орон тоо, цалин, даатгалын зардалд 231,3 сая төгрөг тус тус шаардлагатай талаар эдийн засгийн тооцоолол хийгджээ.

Мөн шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Шийдвэр гүйцэтгэлийн тойргийн тоог шинээр тогтоох шаардлагын улмаас Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГА-д шийдвэр гүйцэтгэлийн 1 тойрог шинээр нэмж тогтоох; Налайх дүүрэг дэх Шийдвэр гүйцэтгэх хэсэгт 2 тойрог шинээр тогтоох; Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд 6 тойрог, 1 ахлах гүйцэтгэгчийн орон тоо шинээр тогтоох явдал бий болж байна. Үүнд нийтдээ Шийдвэр гүйцэтгэлийн 10 орон тоо, цалингийн зардалд 110,2 сая төгрөг шаардлагатай гэж тооцоолжээ. Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээний төрөл болох торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял, татан буулгах ял нэмэгдэж тусгагдсантай холбогдуулан уг ялын бодлогыг хэрэгжүүлэхэд тойргийн системээр явуулах бөгөөд нийт 173 орон тоо, цалин, даатгалын зардалд 1905,8 сая төгрөг шаардлагатай гэсэн.

Ингээд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6-д заасан ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй болон хаалттай хорих ангид ял эдлүүлнэ гэсний дагуу нийт 74796,7 сая төгрөгийн өртөг бүхий шинээр баригдах хорих ангиудын зардлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тайланд үндэслэн хүснэгтээр дор үзүүлье.

Хорих анги шинээр байгуулахдаа нэг жилд хорих ангид ял эдэлж буй хоригдлын дундаж тоог 7500-гаар төсөөлөн, хорих ангийн өрөө тасалгаа, орчин нөхцөлд тавигдах олон улсын жишиг, дотоодын хууль тогтоомжид заасан стандартад нийцүүлэн боловруулсан байна.

Хүснэгт №1. Нийт шинээр барих хорих ангийн төсвийн тооцоолол⁽¹⁾

№	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил /Шинэ хорих анги барих зардал/	Хүчин чадал	Хэмжих нэгж	Объектийн төрөл	Объек-тын ангилал	Хугацаа		Төсөвт өртөг /сая төгрөг/
								Эхлэх он	Дууса он	
1	Баян-Өлгий	Өлгий	Нэг цонхны үйлчилгээтэй нэгдсэн контор, нээлттэй хорих байр барих /Баян-Өлгий, Өлгий/	260	хүн	контор, хорих байр	шинэ	2017	2017	1,856.1
2	Өвөрхангай	Арвайхээр	Нэг цонхны үйлчилгээ бүхий контор, цагдан хорих байр барих /Өвөрхангай, Арвайхээр/	120	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	1,856.1
3	Нийслэл	ШШГЕГ	Цахим хяналтын төвийн барилга барих /УБ хот ШШГЕГ/	150	хүн	контор	шинэ	2017	2017	1,841.7
4	Ховд	Ховд	Дэлхийн жишигний цүүлсэн нэгдсэн хорих ангийн байр барих /Ховд/	670	хүн	хорих анги	шинэ	2017	2018	4,475.4

¹⁾ Энэхүү зардалд хорих ангиудын тог, дулаан, цахилгаан гэх мэт урсгал зардлуудыг хамруулаагүй болно.



5	Нийслэл	Сонгино-хайрхан	Тусгай эмнэлэг / УБ, СХД, хорих 429-р анги/	25	хүн		шинэ	2017	2017	425.0
6	Хөвсгөл	Мөрөн	Албан контор, нээлттэй хорих байр барих / Хөвсгөл, Мөрөн/	210	хүн	контор, цагдан хорих	шинэ	2017	2017	1,611.6
7	Өмнөговь	Ханбогд	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Өмнөговь, Ханбогд/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
8	Завхан	Тосонцэнгэл	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Завхан, Тосонцэнгэл/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
9	Хэнтий	Бор-Өндөр	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Хэнтий, Бор-Өндөр/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
10	Төв	Зуунмод	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр барих /Төв, Зуунмод/	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2017	859.9
11	Өвөрхангай	Хархорин	Албан контор, хаалттай хорих байр, бүс тусгаалах хашаа барих / Өвөрхангай, Хархорин/	660	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2017	2018	4,421.5
13	Нийслэл	Нийслэл	Н а с а н д хүрээгүйчүүдийн хорих байр / Албан контор, ялтны байр, сургууль, спорт заал, соёлын төв/ /УБ хот Хорих 411 анги /	160	хүн	контор, хорих байр, сургууль	шинэ	2018	2019	2,676.9
14	Нийслэл	Сонгино-хайрхан	С ү р ь е э г и й н эмнэлэг /УБ, СХД, хорих 429-р анги/	150	хүн	Эмнэлэгийн байр	шинэ	2018	2018	1,183.3
15	Төв	Лүн	Албан контор, нээлттэй ялтны байр, тусгаарлах хашаа /Төв, Лүн-Авдрант/	260	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2018	1,886.1



16	Өмнөговь	Даланзадгад	Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор, цагдан хорих байр	60-80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2018	1,611.6
17	Нийслэл	Баянгол	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв/Албан контор, сургалтын төв, үйлдвэрлэл, дадлагын байр / УБ, БЗД/	80	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2019	1,844.7
18	Сэлэнгэ	Мандал	Нэг цэгийн үйлчилгээ бүхий албан контор, хаалттай хорих байр барих / Сэлэнгэ/	70	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2018	2019	1,430.1
19	Нийслэл	Баянзүрх	Албан контор, хаалттай хорих байр, тусгаарлах хашаа барих / УБ хот, Баянзүрх дүүрэг Хорих 407 анги/	150	хүн	контор, цагдан хорих байр	шинэ	2019	2019	1,712.7
20	Сүхбаатар	Баруун-Урт	Ялтны нээлттэй хорих байр барих / Сүхбаатар, Баруун-Урт/	45	хүн	нээлттэй хорих байр	шинэ	2019	2019	975.1
21	Хэнтий	Чингис хаан	Дэлхийн жишигт нийцүүлсэн нэгдсэн хорих ангийн байр барих /Хэнтий, Чингис хаан хот/	450	хүн	хорих анги	шинэ	2018	2019	4,475.4
1	Нийслэл	Баянзүрх	Дэлхийн жишигт нийцүүлсэн нэгдсэн хорих анги байгуулах - 1500 хүний багтаамжтай /УБ, БЗД 11-р хороо/	1500	хүн	хорих анги	шинэ	2013	2019	37,074.1
Нийт шаардлагатай хөрөнгө оруулалт								74.796.7		



ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид үндсэн цалингаас гадна, яллагдагч, шүүгдэгч, хоригдолтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн болон тусгай албаны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох ба нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно” гэж заасан. Мөн хуулийн 111.5 дахь хэсэгт “Хорих байгууллагын алба хаагч харуул хамгаалалт, жижүүрийн үүргийг 18, 6 цагаар дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” зэрэг хүний нөөцтэй холбоотой гарах зардалд шууд нөлөөлөх зохицуулалтууд байна. Үүнээс гадна алба хаагчдад үзүүлэх нэг удаагийн буцалтгүй тусламж, дүрэмт хувцас, хоол, унааны зардал, тусгай хэрэгсэл зэрэг бусад нийгэм, эдийн засгийн болон аюулгүй байдлын баталгааг хангахад чиглэсэн дүрэм, журам цөөнгүй байна.

Хүний нөөцийн зардлыг тооцоходоо нэг аймагт байрлах ШГА-нд хоригдож буй сэжигтэн, яллагдагч, ялтны дундаж тоог 30-50 байгааг харгалзан шинээр бий болгох хорих ангийг 100-аас доош хүний багтаамжтай хорих анги гэж үзэн тэнд ажиллах алба хаагчдын орон тоо болон бусад хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг төсөөлөл хэлбэрээр боловсруулав.

ШШГЕГ-аас гаргасан судалгаагаар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр улсын хэмжээнд нийт 1443 орон тоо шинээр бий болгох хэрэгцээтэйг тогтоожээ.

Хүснэгт №2

№	Үйл ажиллагаа явуулах чиглэл	Шинээр бий болох орон тоо
1.	Тогтоол гүйцэтгэх чиглэлээр	612
2.	Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх чирлэлээр	173
3.	Аюулгүй байдал тусгай ажиллагааны чиглэлээр	401
4.	Шийдвэр гүйцэтгэх чиглэлээр	78
5.	Санхүүгийн чиглэлээр	158
6.	Нийт	1443

Дээрхээс харахад ШШГЕГ-ын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтэд үлэмж хэмжээний өөрчлөлт орохоор харагдаж байна.

ШШГЕГ-т шинээр нэмж авах 1443 алба хаагч нь “Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ”-нд тусгасан албан тушаалын ТТ7-ТТ18 зэрэглэлээр цалинжиж, дүрэм журамд заасан нэмэгдэл, урамшуулал авах, нийгмийн баталгаагаа хангуулах эрх үүсэх юм.

Өнөөгийн байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих анги байгууллагуудад хоригдож буй сэжигтэн, яллагдагч, ялтны дундаж тоо жилд 7500 орчим ба үүнийг нийт хүн өдрөөр нь авч үзвэл 2675450 өдөр байдаг.

Хүснэгт №3

№	Хорих анги	сэжигтэн, ялтны тоо	№	Хорих анги	сэжигтэн, ялтны тоо
1.	хорих 401 анги	170	26.	Дорнод	40
2.	хорих 403 анги	150	27.	Дундговь	35
3.	хорих 405 анги	104	28.	Завхан	30
4.	хорих 407 анги	280	29.	Зүүнхараа	300
5.	хорих 409 анги	350	30.	Хархорин	432
6.	хорих 411 анги	34	31.	Ховд	200
7.	хорих 415 анги	450	32.	Хэнтий	392
8.	хорих 417 анги	173	33.	Хөвсгөл	121
9.	хорих 421 анги	250	34.	Өвөрхангай	30

10.	хорих 427 анги	400	35.	Өмнөговь	30
11.	хорих 429 анги	134	36.	Орхон	150
12.	баривчлах 431 анги	94	37.	Сүхбаатар	35
13.	хорих 433 анги	400	38.	Сэлэнгэ	30
14.	хорих 435 анги	300	39.	Төв	43
15.	хорих 439 анги	300	40.	Увс	39
16.	хорих 441 анги	11	41.	Тосонцэнгэл	10
17.	ЦХ 461 анги	800	42.	Налайх	10
18.	Архангай	50	43.	Хөтөл	10
19.	Баян-Өлгий	35	44.	Багануур	20
20.	Баянхонгор	39	45.	баривчлах	100
21.	Булган	35	46.	ДӨ анги	71
22.	Говь-Алтай	17	47.	МСҮТ	60
23.	Говьсүмбэр	250	48.	СМДӨАЭАХХГ	98
24.	Дархан-Уул	250	49.	Хэрэмт цамхаг УТҮГ	44
25.	Дорноговь	35	50.	ОСБХ	56
			51.	ТГГ	5
				НИЙТ	7500

Дээрх хүснэгтээс харахад хөдөө орон нутагт байрлах хорих ангийн ачаалал бага, дунджаар 30-50 сэжигтэн, яллагдагч, ялантай байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Гэсэн хэдий ч шинэ хуулиудын хэрэгжилтийг хангахын тулд аймаг тус бүрд нэг бие даасан хорих анги байгуулах тохиолдолд зайлшгүй шаардлагатай байгаа тухай ШШГЕГ-аас гаргасан судалгаанд дурдсан бөгөөд үүнийг богино хугацаатай ялын төрөл, тоо хэмжээ өссөнтэй болон бусад хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болох юм. Тухайлбал хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 хоногийн дотор аймаг, нийслэл дэх жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэх ялтныг шууд, хүргэнэ.” гэж заасан бөгөөд энэ нь 7 хоногийн хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн хувьд хүндрэлтэй, хүний эрх зөрчигдөх магадлалтай асуудал болж байна.

Өргөн удам нутагт хүн ам нь сийрэг суурьшдаг онцлогтой манай орны хувьд хүн амын





нягтаршил, хамрах тойргийн хэмжээнээс хамааран харилцан адилгүй бүтэцтэй хорих ангиудыг аймаг бүрт байгуулах хэрэгцээ байх боломжтой юм. Иймд ШШГЕГ-аас дараах байршилд хорих анги байгуулах хэрэгцээ байгааг тодорхойлжээ. Үүнд:

Иймд жишээ болгон Говь-Алтай аймаг дахь ШГА-д буюу харуул хамгаалалтын "А", "Б" зэрэглэлийн нээлттэй хорих ангид ажиллах хүний нөөцийг авч үзье.

Хүснэгт №4

№	Албан тушаал	Орон тоо
1	Дотоод ажлын хэлтсийн дарга	1
2	Цагдан хорих байрны дарга	1
3	Төлөөлөгч	2
4	Нийгмийн ажилтан	1
5	Сэтгэлзүйч	1
6	Ерөнхий жижүүр	4
7	Ээлжийн дарга	4
8	Хянагч	20
9	Их эмч	1
10	Холбоочин	4
11	Телекамерийн операторчин	4
12	Сувилагч	4
13	Хүний тоо бүртгэлийн байцаагч	1
14	Тоо бүртгэлийн туслах	1
	Нийт	49

Дээрх хүснэгтээс харахад энэ хорих ангид зөвхөн хорих ял эдлүүлэхэд шаардлагатай харуул хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой 49 алба хаагчийн хэрэгцээ байгааг харуулж байна. Тус хүний нөөцийн тооцоонд үйлчилгээний алба хаагчдыг оруулаагүй болно.

Үүнээс гадна тус аймагт байрлах ШГА нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх, аюулгүй байдал тусгай ажиллагааны, шийдвэр гүйцэтгэх чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулах ба эдгээр үйл ажиллагаанд дараах хүний нөөцийн хэрэгцээ байна. Үүнд:

Хүснэгт №5

№	Албан тушаал	Орон тоо
Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр		
2	Тасгийн дарга бөгөөд ахлах тогтоол гүйцэтгэгч	1
3	Тогтоол гүйцэтгэгч	2
4	Инженер, техникийн ажилтан	1
Аюулгүй байдал тусгай ажиллагааны чиглэлээр		
7	Аюулгүй байдлын ахлах мэргэжилтэн	1
8	Аюулгүй байдлын ажилтан	1
9	Шуурхай бүлгийн офицер	2
10	Шуурхай бүлгийн ажлан	3
Шийдвэр гүйцэтгэх чиглэлээр		
13	Бүртгэл, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	1
14	Жолооч	1
Санхүүгийн чиглэлээр		
	Тооцооны нягтлан бодогч	1
	Нийт	14

Өмнөх мэдээллээс харахад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дундаж хүний нөөцийн хэрэгцээ 63 байх төлөвтэй байна.

Алба хаагчид төрөөс олгох цалин ба түүнтэй төсөөтэй зардал



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын 2015 оны цалингийн дундаж хэмжээнд түшиглэн төрийн зүгээс нэг алба хаагчид зориулан гаргах зардлын хэмжээг дараах байдлаар тоймлон гаргав.

Цалингийн дундаж хэмжээг тогтооходоо цалин урамшуулал, нэмэгдэл зэргийг хувь хэмжээг дундажлан гаргасан тул доорх хүснэгтэд тусгасан сарын дундаж цалингийн хэмжээнээс албан тушаалын зэрэглэл, цол, ажилласан жил зэргээс хамааран өөр өөр дүн гарах нь дамжиггүй юм.

Энэ тооцооллод тоо хэмжээг нь тодорхойлох боломжгүй нэг удаагийн тусламж, нэмэлт, дүрэмт хувцасны хангамж, тэтгэмж болон алба хаагчийн хоол, унааны зардал, томилолтын зардал зэрэг бусад зардлыг оруулаагүй тул эдгээр зардлыг нэг алба хаагчийн цалин болох 1750628 /нэг сая долоон зуун тавин мянга зургаан зуун хорин найм/ төгрөг дээр нэмж бодох шаардлагатай.

Хүснэгт^[12] №6

№	Зардлын төрөл /дунджаар/	Хэмжээ/ Дундаж/	Давтамж0	Нийт	Тохиолд-лын тоо /хүн/	Нийт
1.	Үндсэн цалин ¹	917800	12	11013600	49	539666400
2.	НДШ 20%	183560	12	2202720	49	107933280
3.	ЭМДШ 2%	18356	12	220272	49	10793328
4.	Алба хаасан хугацааны нэмэгдэл	133081	12	1596972	49	78251628
5.	Хоригдолтой ажилласны нэмэгдэл	71,588	12	859056	49	42093744
6.	Гүйцэтгэх ажилтанд гүйцэтгэх ажил эрхэлсэн хугацаанд олгох тусгай албаны нэмэгдэл	100958	12	1211496	49	59363304
7.	Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл	137670	12	1652040	49	80949960
8.	Цолны нэмэгдэл	160615	12	1927380	49	94441620
9.	Гэнэтийн ослын даатгал	27000	1	27000	49	1323000
	Нийт	1750628		20710536		1014816264

Хорих ангид сэжигтэн, яллагдагч, ялтныг байрлуулахад зайлшгүй шаардлагатай харуул хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаанд 49 алба хаагчийн хэрэгцээ байгааг дээр дурдсан бөгөөд эдгээр алба хаагчдын нэг жилийн цалин хөлсөнд **1014816264** /нэг тэрбум арван дөрвөн сая найман зуун арван зургаан мянга хоёр зуун жаран дөрвөн/ төгрөг зарцуулах тооцоо гарч байна.

Ийнхүү төрийн зүгээс шүүхийн тогтоол биелүүлэх чиглэлээр хорих ангид ажиллах хүний нөөцийн зардлын нэг алба хаагчид оногдох хувь хэмжээг тогтоосноор Эрүүгийн хуулийн холбогдох заалтууд хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх байгууллагад шаардлагатай байгаа 1443 алба хаагчийн цалингийн зардлыг ойролцоогоор тооцож болох юм.

Алба хаагчдын ажлын цаг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/84 тушаалын хавсралтаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д албан хаагчдын ажлын цагийн тухай тусгасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуульд^[13] заасан

¹² Хавсралт №1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹³ Хөдөлмөрийн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.2 дах заалт. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/>



ажлын цагтай адил буюу 7 хоногийн 40 цаг, 1 өдрийн 8 цаг байх ба ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралтын хугацаа 12 цаг байхаар зохицуулжээ. Энэ заалт нь хүчлэн хамгаалах болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед хамаардаггүй. Амралтын өдрүүд /Бямба, ням гараг/ болон бүх нийтээр амрахаар заасан амралтын өдрүүдэд ажиллахгүй.

ХЗДХ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2008 оны 205/94 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “ШШГЕГ-ын алба хаагчдын ажлын ачааллын жишиг норматив” –ын хүрээнд нэг алба хаагчид ногдох сэжигтэн, ялагдагч, ялтны тоо, зайлшгүй байх шаардлагатай албан тушаалыг заасан байх боловч бодит нөхцөлд хүний нөөцийн хомсдол үүсч алба хаагчдын ажлын ачаалал хэт өндөр, зарим орон тоонд хүн ажиллахгүй байх зэрэг олон шалтгааны улмаас илүү цагаар ажиллах, норм хэтрүүлэх нь энгийн үзэгдэл болсон байна.

Иймд энэ судалгааны хүрээнд хуулийн төслийн эдийн засгийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу “хүн/цаг” хэмжигдэхүүнээр хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тогтоохоос зайлсхийлээ.

Төрийн зүгээс нэг хоригдолд гаргах зардал

Шүүхээс хорих ялаар шийтгүүлж хүчин тогтоолын дагуу хорих ангид ял эдэлж буй нэг хоригдолд гарах зардал нь шууд болон шууд бус гэсэн хоёр хэлбэрээр илэрдэг.

Шууд зардал /хүснэгтийн 14,15,16 дахь мөр/ нь хорих ангид ял эдэлж буй хоригдлын тооны өсөлт, бууралттай шууд хамааралтайгаар өсч, буурч байдаг бол шууд бус зардал нь үүнээс хамааралгүй тогтмол шинжтэй байдаг.

Хүснэгт №7. Нэг хоригдолд гаргах зардал

№	Зардлын зүйл	Хэрэгцээ		Улсын төсвөөс олгож буй санхүүжилт
		Нэг хоригдолд ногдох /төгрөгөөр/		Нэг хоригдолд ногдох /төгрөгөөр/
		Хоногт	Жилд	Жилд
1.				
2.	Цалин, хөлс, нэмэгдэл	11517	4203797	3311452
3.	ЭМД, НДШ	108	39422	21575,3
4.	Бичиг хэрэг	25	9067	6045
5.	Гэрэл цахилгаан	501	183034	152528,1
6.	Түлш халаалт	500	182417	165833,8
7.	Тээвэр, шатахуун	411	149853	115271,9
8.	Шуудан холбоо	49	18040	11275,1
9.	Цэвэр, бохир ус	80	29366	22588,9
10.	Дотоод албан томилолт	44	15964	12279,8
11.	Гадаад томилолт	11	4083	2551,6
12.	Ном, хэвлэл авах	8	2816	1564,4
13.	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	100	36645	15932,6
14.	Тавилга, БҮТЭЭ	92	33682	28068
15.	Нормын хувцас, зөөлөн эдлэл	970	353983	141593,1
16.	Хоол	3749	1368437	977454,7
17.	Эм	380	138791	92527,3
18.	Урсгал засвар	414	150932	100621,2
19.	Нэг удаагийн тэтгэмж	74	27003	19287,7
20.	Газрын төлбөр	34	12371	8247,3
21.	Бараа үйлчилгээний бусад зардал	347	126785	84523,1



22.	Харуул хамгаалалтын зардал	78	28478	18985,4
	Дүн	19493	7114964	5310206

Хүснэгт дэх мэдээллээс харахад нэг хоригдолд гаргах зардал өдөрт 19493 / арван есөн мянга дөрвөн зуун ерэн гурван/ төгрөг, жилд 7114964 /долоон сая нэг зуун арван дөрвөн мянга есөн зуун жаран дөрвөн/ төгрөг байна.

Хорих ял эдлүүлэх зардал нь улсын төсвөөс санхүүждэг бөгөөд нэг хоригдолд оногдох зардлын 70 гаруй хувийг улсын төсвөөс санхүүжүүлж үлдсэн хэсгийг хорих ангийн үйл ажиллагаанаас буюу хорих ял эдэлж буй ялтнуудаар гүйцэтгүүлсэн ажлын орлогоос нөхөн санхүүлжүүлдэг.

Улсын хэмжээнд жилд дунджаар 7500 ялтан хорих ял эдэлдэг гэж үзвэл нэг жилд 53362230000 /тавин гурван тэрбум гурван зуун жаран хоёр сая хоёр зуун гучин мянган/ төгрөгийг хорих ялыг хэрэгжүүлэхэд зарцуулдаг бөгөөд үүнээс 3982654500 / гучин есөн тэрбум найман зуун хорин зургаан сая таван зуун дөчин таван мянган/ төгрөг буюу 40 орчим тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг байна.

ДӨРӨВ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан ял, албадлагын арга хэмжээний төрөлд торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял, татан буулгах ял нэмэгдэж тусгагдсан.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын тусгай ангийн 21 бүлгийн 437 заалтаас 170 заалтад хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах боломжтой байхаар тусгасан байна.^[14] ШШГЕГ-аас гүйцэтгэсэн судалгаанд зорчих эрхийг хязгаарлах заалтыг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн тусгай ангитай харьцуулж үзжээ. Ингэхэд нийт 170 заалтад заасан 60 баривчлах, 48 хорих болон 62 баривчлах, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах буюу хорих ялыг сонгож, хэрэглэхээр өөрчлөн тусгасан.^[15]

Улсын Дээд шүүхийн статистик мэдээнд улсын хэмжээнд анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж баривчлах ялаар 499, 1-5 жилийн хугацаатай хорих ялаар 970 этгээд

ял шийтгүүлсэн байна.^[16] Улмаар нэг жилд дунджаар 1500 орчим этгээдэд “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг оногдуулах боломжтой гэж ШШГЕГ тогтоосон байна.^[17]

Тус байгууллагаас боловсруулсан “Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах” төсөлд тусгасан тоо баримт, мэдээллийг зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэг удаагийн хөрөнгө оруулалтын зардал, урсгал зардал, хүний нөөцийн тооцоо зэрэг зардлыг тооцоход ашигласан болно.

Хүний нөөцийн зардал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтцэд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар байгуулахаар заасан. ШШГЕГ нь ялын бодлогыг тойргийн системээр хэрэгжүүлдэг учраас зорчих эрхийг хязгаарлах ял болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хүний нөөцийг нэгдсэн байдлаар тооцдог байна. Иймд тус байгууллагаас хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэмэх шаардлагатай нэгдсэн байдлаар тооцоолсон орон тоог дор авч үзлээ.

Хүснэгт№8. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр шинээр нэмэгдэх орон тоо^[18]

¹⁴ Электрон гав бүхий цахим хяналтын систем байгуулах ажлын танилцуулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ Мөн тэнд.



Одоо ажиллаж байгаа	Нэмэх шаардлагатай	Нийт
Улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр 34 хүн ажиллаж байна.	Зорчих эрхийг хязгаарлах ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 173 хүн нэмэх шаардлагатай. Үүнд: - Цахим хяналтын төв – 14 - Ахлах тогтоол гүйцэтгэгч – 32 - Тогтоол гүйцэтгэгч – 80 - Инженер, техникийн ажилтан – 38 - Харуул хамгаалалтын ажилтан - 7	207 алба хаагч


Дээрх ялын бодлогыг тойргийн системээр хэрэгжүүлэх бөгөөд нийт 173 орон тооны цалин, даатгалын зардалд 1905,8 сая төгрөг орчим шаардлагатай.^[19] Энэхүү тооцоог гаргахдаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх алба хаагчийн нэг сарын цалингийн дундаж хэмжээг 918000 төгрөгөөр тооцоолж, шинээр бий болох 173 орон тоогоор үржүүлсэн бөгөөд үүнийг улсын төсвөөс жилийн түвшинд гарах зардлаар тооцоолсон болно.

Шинэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын буюу материаллаг зардал

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах 3 үе шат бүхий үйл ажиллагааг гүйцэтгэхээр байна.^[20] Үүнд:

- 1.Цахим хяналт, удирдлагын төв, салбар төвийн барилга барих, дэд бүтцийг сайжруулах;
- 2.Програм хангамж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, мэдээллийн технологийг боловсронгуй болгох;
- 3.ШШГЕГ-ын ажилтнуудыг програм хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд суралцах, дадлагажуулах сургалтад хамруулах хамаарна.

Цахим хяналт тавих үндсэн хяналтын төвийг Улаанбаатар хотод, дэд төвийг НШГА, Дархан, Эрдэнэт хотод барихаар тооцоолсон.



Зураг 1.

Технологийн схем^[21]

Удирдлагын төв, дэд төв: Цахим хяналт, удирдлагын төвийн барилгыг "...4-5 давхар /400 кв-аас багагүй/ нөөц цахилгаан тэжээлийн найдвартай эх үүсвэртэй, галын болон агааржуулалт, хяналтын системтэй, 30-50 ажилтан ажиллах орчин нөхцөл бүрдсэн, олон улсын шаардлага хангасан техникийн өрөөтэй, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон..." байхаар "Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах" төсөлд тооцоолсон байна.^[22] Дэд төвийн барилгыг "...2 давхар /100 кв-аас багагүй/ нөөц цахилгаан тэжээлийн найдвартай эх үүсвэртэй, галын болон агааржуулалт, хяналтын системтэй 10-20 ажилтан ажиллах орчин

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Мөн тэнд.

²¹ Электрон гав бүхий цахим хяналтын систем байгуулах ажлын танилцуулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

²² "Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах" төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.



нөхцөл бүрдсэн, олон улсын шаардлага хангасан техникийн өрөөтэй, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон...” байхаар тооцоог гаргасан.^[23]

Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд^[24]

- Шилэн кабелиар холбох
- Сервер
- Нөөц хадгалах систем
- Компьютер
- Програм хангамж /албан ёсны эрхтэй/
- Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж
- Сүлжээний төхөөрөмж
- Тог тогтворжуулагч, баригч
- Бусад шаардлагатай тоног төхөөрөмж

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох электрон гавын үнийг судалж хэд хэдэн боломжит хувилбарыг судалсан бөгөөд ШШГЕГ-аас хийсэн судалгааны хүрээнд дараах харьцуулалтыг гаргасан байна.

Хүснэгт№9. Харьцуулсан электрон гавны үнэ^[25]

Д/д	Судалсан улс орон	Хэрэгжүүлэх боломжтой эсэх	Нэг ширхэг электрон гавны үнэ /ам.доллар/	Тайлбар
1	АНУ, Израйль, Франц	Боломжгүй	2500-6000	Програм хангамж болон серверийг тухайн орон худалдахгүй бөгөөд хяналт, засвар үйлчилгээг тус улс хэрэгжүүлнэ. Үнэ өндөр
2	БНХАУ	Боломжгүй	300-500	Үнэ хямд боловч техникийн шаардлага хангахгүй.
3	ОХУ	Боломжтой	1800	Програм хангамжийг серверийн хамт худалдаалдаг. Шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх боломжтой.
4	БНСУ	Боломжтой	1800	

Мөн электрон гавыг хянах, түүний ашиглалтад шаардлагатай систем, техник хэрэгслийн судалгааг гүйцэтгэж дараах үнийн саналыг гаргасан байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмж	НИЙТ /ам.доллар/
1	Электрон гав, сервер, сүлжээний тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	3,637,151
2	Цахим хяналтын програм хангамжийн систем	3,869,519
3	“Хяналтын төв”-ийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	449,250
4	“Нэгдсэн хяналтын төв”-ийн барилга	438,180
5	Төслийн менежмент, Сургалт	995,700
6	Магадлашгүй ажил	110,200
	НИЙТ	9,500,000

Урьдчилсан зардлын тооцоо /1500 ширхэг электрон гав/

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд нэн түрүүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал **23,4 тэрбум төгрөг** болох төлөвтэй байгаа бөгөөд үүнд тус ялыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 21,2 тэрбум төгрөг орчим, бусад урьдчилан тооцоолох боломжгүй нэмэгдэл зардалд 2.2 тэрбум төгрөгийн зардал гаргахаар тооцоолсон.

Нэг удаагийн хөрөнгө оруулалтын зардал болох 9.5 сая ам.доллар буюу 21.2 тэрбум төгрөг орчмыг БНСУ-ын EDCF-ийн зээлээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үндсэндээ материаллаг зардлыг тооцоход томоохон хэмжээний зардал бүхий барилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсийн тооцоог багцаалан оруулсан болно. Иймд бага хэмжээний хөрөнгө оруулалт

²³ “Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах” төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2016.

²⁴ Мөн тэнд.

²⁵ Мөн тэнд.



шаардах материаллаг зардлыг оруулаагүй.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх тогтолцооны урсгал зардал нэг жилд 277,5 сая төгрөг орчим байх магадлалтай. Энэ зардалд урьдчилан тооцоолох боломжгүй цахилгаан, цэвэр бохир ус, халаалт зэрэг бусад зардал ороогүй болно. Эдгээр зардлыг тооцох нь цаг хугацаа, хүний нөөц шаардсан ажил юм. Түүнчлэн цахим гавны ашиглалтын буюу элэгдэл хорогдлын хугацаа нь 3 жил орчим учраас 3 жил тутам 5.4 тэрбум төгрөг орчим буюу жилд 1.8 тэрбум төгрөг орчим хөрөнгө оруулах шаардлагатай байна.

Гурван жил тутам электрон гавыг шинэчлэхэд шаардлагатай зардал	Нэг жилд ногдох электрон гавыг шинэчлэхэд шаардлагатай зардал
1500 /ялтны тоо/ * 3.6 сая орчим /нэг ширхэг гавны өтрөг/= 5.4 тэрбум төгрөг орчим	5.4 тэрбум : 3 жил = 1.8 тэрбум орчим төгрөг

Зорчих эрхээ хязгаарлуулсан ялтанд үүсэх зардлыг дараах байдлаар тооцох боломжтой. Үүнд

Хүснэгт №10.

№	Төрөл	Төлбөр /хоногоор/
1	Үүрэн холбооны гар утасны сүлжээний урсгал зардал	1900 төгрөг
2	Сансрын холбооны сүлжээний урсгал зардал	4500 төгрөг

Хууль санаачлагчлын зүгээс зорчих эрхээ хязгаарлуулсан ялтнаас сүлжээний зардлыг нь гаргуулахаар тооцож байгаа боловч төлбөрийн чадваргүй ялтны тухайд эдгээр зардлыг төр хариуцах юм.

Үүнээс харахад нэг ялтны электрон гавны сүлжээ ашигласны жилийн урсгал зардал болох 684,000 төгрөг улсын төсөвт нэмэгдэх магадлалтай. Харин төлбөрийн чадвартай, хөдөлмөр эрхэлдэг этгээдээс сүлжээний урсгал зардлаас гадна хяналтын зардлыг гаргуулан төсвийн зардлыг хэмнэх боломжтой хэдий ч энэ нь ялтны эдийн засгийн байдлаас хамааран адил тэгш байх зарчмыг алдагдуулах эрсдэлтэй юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмж тусгагдсан ялын төрөл болох зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд зөвхөн эхний жилд 23.4 тэрбум орчим төгрөг шаардлагатай байгаа боловч, анхны хөрөнгө оруулалт хийгдсэний дараа зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн нэг ялтанд ногдох зардал нь огцом буурах төлөвтэй байна.

Хүснэгт № 11

№	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн нэг ялтанд гаргах зардал	
1	хүний нөөцийн зардал	1.9 тэрбум
2	сүлжээний зардал	277.5 сая
3	Нэг жилд ногдох электрон гавыг шинэчлэхэд шаардлагатай зардал	1.8 тэрбум
	Нийт 1500 ялтанд ногдох зардал	3977500000
	Нэг ялтанд ногдох зардал	2651666 төгрөг

Дээрх нийлбэр дүнгээс харахад нэг жилд нэг ялтанд 2651666 /хоёр сая зургаан зуун тавин нэгэн мянга зургаан зуун жаран зургаа/ орчим төгрөгийн зардал гарахаар төсөөлж болохоор байна. Гэвч судалгааны багын зүгээс урьдчилан тооцох боломжгүй байсан урсгал зардал буюу цахилгаан, дулаан, ус, бусад засвар үйлчилгээний зэрэг зардлын тооцоог дээрх зардал дээр нэмж тооцох шаардлагатай.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх зардлыг бууруулах үүднээс электрон гавыг / гавны үнэ 3.6 сая төгрөг орчим/ аливаа байдлаар гэмтээсэн этгээдээр нөхөн төлүүлэх, ажилтай, орлоготой этгээдээс хяналт тогтоосны болон техник хэрэгсэл ашигласны зардлын тодорхой хувийг гаргуулан авах зэрэг асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай.

ТАВ. ДҮГНЭЛТ

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын ялын төрлүүдээс шинэ төрлийн ял болох



“Зорчих эрхийг хязгаарлах ял”, ял эдлүүлэх хугацааны хувьд багагүй өөрчлөлт орсон “Хорих ял”-ыг сонгон авч, эдгээр ялыг хэрэгжүүлэхэд төрд үүсэх эдийн засгийн ачааллыг тооцож зорилго бүхий судалгааны ажлын үр дүнд судалгааны баг дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

Хорих анги байгуулах зардлын тухайд

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад ялын төрөл, хэмжээнд орсон өөрчлөлтийн үр дүнд өмнө нь хорих ялгүй байсан зарим гэмт үйлдэлд хорих ял оноодог болох, мөн ялтай байдал, давтан үйлдсэн зэрэг ял хүндрүүлэх байдлыг халснаар зарим гэмт үйлдлийн ялын хэмжээ буурах зэрэг өөрчлөлт орсноор хорих ял биеялэн эдлэх ялтны тоонд өөрчлөл орох магадлал өндөр байна.

Үүнээс гадна хорих ангийг нээлттэй, хаалттай гэсэн 2 төрөлтэй, харуул хамгаалалтын 5 зэрэглэлтэй байхаар хуульчилсан нь хорих ял эдлүүлэх чиг үүрэг бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих ангиудын байршил, багтаамж, харуул хамгаалалтын систем, үйл ажиллагааны хэлбэр, бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах хэрэгцээг шууд тодорхойлж байна.

2016 оны байдлаар Монгол Улсад нийт 51 байршилд²⁶ сэжигтэн, яллагдагч, ялтныг хорьж байгаа бөгөөд эдгээр нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын “хорих” ялыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээлтэй байна. Тухайлбал эдгээр хорих байрыг нээлттэй, хаалттай хэлбэрт шилжүүлэх, харуул хамгаалалтын зэрэглэлд өөрчлөлт оруулах ажлын нөхцөл бололцоондоо нийцүүлэн өөрчлөх боломжтой хэдий ч зарим алслагдсан бүс нутагт шинэ хорих байр барихгүйгээр богино хугацаатай ялыг хэрэгжүүлэх боломжгүй байх магадлалтай байна.

Хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан ШШГЕГ-аас аймаг тус бүрт шинээр хорих анги/байр барих хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдаг.

Хорих анги байгуулах тооцоог гаргахдаа ялтны тоог олон жилийн дундаж үзүүлэлт болох 7500 ялтнаар тооцож, хорих байранд тавигдах шаардлагыг олон улсын жишиг болон дотоодын хууль тогтоомжид заасан стандартад /тухайлбал 1 ялтан 2,5 м2 талбайд байх/ нийцүүлэн боловсруулсан байна.

²⁶ Үүнд хорих анги, баривчлах, цагдан хорих байр баривчлах ял эдлүүлэх байр орно.

Судалгааны үр дүнгээс харахад хорих анги байгуулах зардалд улсын төсвөөс 74,796.700,000 /далан дөрвөн тэрбум долоон зуун ерэн зургаан сая долоон зуун мянган/ төгрөг зарцуулах шаардлага үүсэж байна.

Хүний нөөцийн зардлын тухайд

Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад орсон өөрчлөлтийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын орон тоог нэмэх хэрэгцээ үүсэж байна. Энэ нь нэгдүгээрт шинэ хорих анги байгуулагдахтай, хоёрдугаарт шинэ төрлийн ял бий болсонтой холбоотой.

ШШГЕГ-аас гаргасан тооцоо судалгаагаар шинээр нэмж 1443 орон тоо бий болгох хэрэгцээ байгааг тогтоосон байна. Судалгааны ажлын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй алба хаагчдын үндсэн цалингийн дундаж хэмжээг 917800 төгрөг байхаар авч үзсэн.

Төрийн тусгай алба хашиж буй алба хаагчид нь үндсэн цалингийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний алба хаасан хугацааны, цолны, онцгой нөхцөлийн, хоригдолтой ажилласны, хоол, унааны гэх зэрэг нэмэгдэл, нэг удаагийн тусламж, урамшуулал, дүрэмт хувцас болон бусад хангамж авахаас гадна ажлын онцлогоос хамааран зарим төрлийн даатгалд хамрагддаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид зориулан төрийн зүгээс гаргах зардлыг дээр дурдсан цалин, урамшуулал, нэмэгдлийн дундаж хэмжээг чиглэл болгон тооцсон бөгөөд нэг алба хаагчид ногдох цалингийн хэмжээ нэг сард 1750628 /нэг сая долоон зуун тавин мянга зургаан зуун хорин найм/ төгрөг байхаар тооцов. Энэ цалинд судалгааны ажлын явцад нарийвчлан тогтоох боломжгүй байсан хоол, унааны зардал, нэг удаагийн тусламж зэрэг зарим зардлыг тооцож оруулаагүй тул нарийвчилсан судалгаа хийж ТТ1-ТТ18 зэрэглэл тус бүрээр нь тооцож гаргах, мөн тус байгууллагад ажиллаж буй төрийн үйлчилгээний ангилалд багтах ажилтны цалинг тусад нь нэмж гаргаснаар төсөвт үүсэх ачааллыг улам тодорхой болгоход дөхөм болохоор байна.

2015 онд баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлснээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад



шинээр нэмэх шаардлагатай 1443 орон тоо нь улсын төсөвт нэг сард дунджаар 2526156204 /хоёр тэрбум таван зуун хорин зургаан сая нэг зуун тавин зургаан мянга хоёр зуун дөрвөн/ төгрөгийн ачаалал үүсгэх магадлалтай байна.

Зорчих эрх хязгаарлах ялын тухайд

Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ тусгай ангийн 170 заалтад хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах боломжтой байхаар тусгасан ба Монгол Улсын хэмжээнд нэг жилд дунджаар 1500 хүнд энэ төрлийн ял оногдуулах магадлалтай байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь эрүүгийн хууль болон ялын бодлогын шинэчлэлийн хүрээнд манай улсад анх удаа хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ялын шинэ төрөл юм. Тус ялыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл болох электрон гав болон түүнийг хянах тогтолцоог шинээр бий болгохын тулд эхний ээлжинд төрийн зүгээс их хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай.

ШШГЕГ-аас зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх арга зам, нийгэм, эдийн засгийн хувьд манай улсад хэрэгжүүлж болох хэд хэдэн хувилбарыг “Цахим хяналт, удирдлагын төв систем байгуулах” төслийн хүрээнд судалж үзсэн байна.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал нь 1/ Цахим хяналт, удирдлагын төв, салбар төвийн барилга барих, дэд бүтцийг сайжруулах; 2/ Програм хангамж, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, мэдээллийн технологийг боловсронгуй болгох; 3/ ШШГЕГ-ын ажилтнуудыг програм хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд суралцах, дадлагажуулах сургалтад хамруулах зардлаас бүрдэнэ. Эдгээр хөрөнгө оруулалтад эхний ээлжинд 9,500,000 ам.доллар буюу 23,4 тэрбум төгрөг шаардагдахаар байна.

Дээрх зардалд 1800 ам.доллар буюу 3,6 сая төгрөгийн өртөг бүхий 1500 ширхэг электрон гавны зардал болох 5,4 тэрбум төгрөг багтсан байна. Гэвч тус гавны ашиглалтын хугацаа дунджаар 3 байх ба ашиглалтын хугацаанаас хамааран жилд 1,8 тэрбум төгрөг орчим зардлыг гав шинэчлэх, засварлах зэрэгт зарцуулах хэрэгцээ үүсэх магадлалтай байна.

Зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан аль төрлийн сүлжээ ашиглаж байгаагаас хамааран өдөр тутам 1900 – 4500 төгрөгийн сүлжээ ашигласны төлбөрийг барагдуулах шаардлагатай. Үүнээс харахад нэг сард /30 хоног/ 57000- 135000 төгрөгийн төлбөр төлөх санхүүгийн чадвартай хүнд энэ төрлийн ял оногдуулах нь төрд ашигтай байна. Гэтэл энэ ялаар шийтгүүлэх магадлалтай сэжигтний 40 гаруй хувь нь төлбөрийн чадваргүй, үлдсэн 50 гаруй хувь нь төлбөрийн чадвартай гэсэн судалгаа байна.

Энэ судалгааны ажлын хүрээнд зөвхөн эхний ээлжинд нэн даруй хөрөнгө оруулах шаардлагатай зардлыг тооцох оролдлого хийсэн бөгөөд сүүлд гарах барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой урсгал зардал болон бусад зардлыг тооцох боломжгүй байлаа.

Эцэст нь нэгтгэн дүгнэхэд Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ Тавдугаар бүлгийн 5.5 дугаар зүйл “Зорчих эрхийг хязгаарлах ял” болон 5.6 дугаар зүйл “Хорих ял”-ыг хэрэгжүүлэхэд төрийн зүгээс юуны түрүүнд 128,2 тэрбум төгрөгийн зардал гарах төлөвтэй байна.

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Хорих анги байгуулах нэг удаагийн зардал	74,8 тэрбум
2	Нэмэх шаардлагатай хүний нөөцийн нэг жилийн зардал	30 тэрбум
3	Цахим гав болон түүний хяналтын тогтолцоог бий болгох зардал	23,4 тэрбум
	Нийт	128,2 тэрбум

Дээрхи зардалд хорих анги болон алба хаагчдыг ажил, үйлчилгээнд шаардлагатай машин, техник тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл болон харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилго бүхий хэрэгслийг оруулаагүй болно.

Эрүүгийн эрх зүй, ялын бодлогын шинэчлэл нь удаан хугацаанд үргэлжилдэг, төрийн зүгээс их хэмжээний хөрөнгө оруулалт, санхүүжилт шаарддаг асуудал юм. Иймд ялын бодлого, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэлбэр, орчин нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэх, хүний эрхийг хангах, ялтнуудын эрүүл аюулгүй орчныг бий болгох, хорихоос өөр төрлийн ял хэрэглэх замаар анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс таслах, шоронжуулахаас сэргийлэх зэрэг зорилготой уялдуулан шийдвэрлэх шаардлагатай юм.

ЭМНЭЛГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА

М.Цэрэнбат¹, Б.Тунгалагбайгаль¹,
Б.Амарбаясгалан², Ж.Эрдэнэбулган²,
М.Еркебулан¹, Г.Эрдэнэбат³, Г.Манилцэцэг²,
У.Цолмон², Б.Ариунжаргал²,
¹АШУУИС, ²МУИС-ийн ХЗС, ³ЗУЕПГ

Abstract

Background. Medical crime statistic is increasing year by year in last few years in Mongolia. This research is focused on exploring the reason of medical malpractice, crime and breach of duty. Medical malpractice is professional negligence by act or omission by a health care provider in which the treatment provided falls below the accepted standard of practice in the medical community and causes injury or death to the patient, with most cases involving medical error. Standards and regulations for medical malpractice needed to be updated to associate with the new criminal law of Mongolia.

Purpose. To investigate the reason of medical errors using forensic medical experts database in 2001-2017.

Objectives:

- 1.The classification of all registered medical errors in 2001-2017
- 2.Causation of medical crimes and also it's criminal code clauses
- 3.To classify all registered errors by the level of medical service
- 4.Statistical calculation on the result research

Material and methods. Digital documenting analysis method was used in this study. The qualitative and quantitative data were collected from the National institute of forensic science, Mongolian Prosecutor's central criminal archive and Supreme court's research institute.

Түлхүүр үг:

Эмнэлгийн эрх зүй, эмнэлгийн эрх зүйн зөрчил, эмнэлгийн гэмт хэрэг, эмчийн алдаа, золгүй тохиолдол.

Судалгааны ажлын үндэслэл

Эмнэлгийн эрх зүй нь эмнэлэгтэй холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад чиглэгдсэн үндсэн хуулийн, захиргааны, иргэний, эрүүгийн, хөдөлмөрийн зэрэг салбар эрх зүйн хэм хэмжээнээс бүрдсэн эрх зүйн судлагдахуун юм^[27].

Харин эмнэлгийн эрх зүйн зөрчил нь эмнэлгийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн

²⁷ С.Нарангэрэл. Эрх зүйн тайлбар толь. 2011:216,650.

аливаа үйлийг тэмдэглэсэн төрлийн шинжтэй ухагдахуун. Эмчлэх, сувилах, эм барих, эх барих, сэргээн засах зөвшөөрөлтэй тусгай эрх зүйн чадамж бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн гэрээ, хэлцлээр хүлээсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зохих ёсоор биелүүлээгүй санаатай эсхүл болгоомжгүй гэм буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, амь нас хохирсон байхыг ойлгоно^[28].

Монгол улсын “Эрх зүйн эх толь бичиг” -т анх 2008 оноос хойш “Эмнэлгийн эрх зүй” хэмээх нэр томъёог бичигдэж түүнээс хойш эмнэлгийн эрх зүйн зөрчлийн тухай ойлголт яригдаж байгаа билээ.

Манай Улсад сүүлийн жилүүдэд эмнэлгийн эрх зүйн зөрчлийн талаар дорвитой судалгааны ажил хараахан хийгдээгүй байгаа юм. Тиймээс эмнэлгийн эрх зүйн зөрчил хэмээн хуулийн байгууллагаар шийдвэрлэгдсэн асуудлыг судлах хэрэгтэй байгаа бөгөөд судалгааны үр дүнд эмнэлгийн эрх зүйн шалтгаан мөн чанарыг тогтоож улмаар үйлчлүүлэгчийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

Судалгааны зорилго

Монгол Улсын хуулийн байгууллагуудад бүртгэгдсэн эмнэлгийн эрх зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл, эрх зүйн төлөв байдлыг судлах.

Судалгааны зорилт

1.Монгол Улсын хуулийн байгууллагуудад 2001-2017 онуудад бүртгэгдсэн эмнэлгийн эрх зүйн зөрчлийг судлах

2.Шинжээчийн дүгнэлтүүдийг судалж, улмаар эмнэлгийн эрх зүйн зөрчлүүдийн шалтгааныг тодорхойлох

3.Эмнэлгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шийдвэрлэгдсэн эрүүгийн хуулийн зүйл ангиар харьцуулан судлах, эрүүгийн эрх зүйн харьцуулсан судалгаа явуулах

4.Судалгааны үр дүнд боловсруулалт хийж, статистик үнэн магадлалыг тодорхойлох

- Sampson, R., Jeffrey Morenoff, and Felton Earls. (1999). "Beyond Social Capital: Spatial Dynamics of Collective Efficacy for Children." *American Sociological Review*, 64: 633-660.
- Shaw, C.R., and McKay, H. D. (1942). *Juvenile Delinquency and Urban Areas*. University of Chicago Press.
- Shaw, M. (2002). "Crime, Police and Public in Transitional Societies." *Transformation: Critical Perspectives on Southern Africa*, 49: 1-24.
- Skogan, W. G. (1990). "Disorder and Decline: Crime and the Spiral of Decay in American Neighborhoods." Berkeley and Los Angeles: *University of California Press*.
- Skogan, W. G., and Maxfield, M.G. (1981). "Coping with Crime: Individual and Neighborhood Reactions." *Sage: Beverly Hills, CA*.
- Smith, S. J., (1987). "Fear of Crime: Beyond Geography of Deviance." *Progress in Human Geography*, 11: 1-23.
- Sookram, S., Saridakis, G., and Mohammed, A. (2011). "Do Victims of Crime Fear Crime More? Empirical Evidence from the Survey of Living Conditions (2005) of Trinidad and Tobago." *Social and Economic Studies*, 60(2): 127-144.
- Stafford, M. C., and Galle, O. R. (1984). "Victimization Rates, Exposure to Risk, and Fear of Crime." *Criminology*, 22: 173-185.
- Taylor, R. B., and Hale, M. (1986). "Testing Alternative Models of Fear of Crime." *Criminology*, 77(1): 151-189.
- Vanderveen, G. (2006). "Interpreting Fear, Crime, Risk and Unsafety." *Den Haag: BJU*.
- Vandeviver, C. (2011). "Fear of Crime in the EU-15 and Hungary, Assessing the Impact of the Vulnerability, Victimization and Incivilities Model of the Fear of Crime in a European Cross National Context." *Master Thesis, Hogeschool-Universiteit Brussel*.
- Zarafonitou, C. (2009). "Criminal Victimization in Greece and the Fear of Crime: A 'Paradox' for Interpretation." *International Review of Victimology*, 16: 277-300.
- Zedner, L. (1997). "Victims." In Maguire, M., Morgan, R. and Reiner, R. (eds). *The Oxford Handbook of Criminology*, Second Edition. Oxford: Clarendon Press, pp. 577-612.



<Table 2> Correlation between Variables: N=631

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1. Fear at home	1												
2. Fear on the street	.649**	1											
3. Age	.058	.045	1										
4. Income	-.081*	-.067	-.111**	1									
5. Education	-.018	-.036	.097*	.105**	1								
6. Victimization - property crime	.048	.032	-.092*	-.022	.017	1							
7. Victimization - violent crime	.073	.016	-.085*	-.064	-.027	.438**	1						
8. Incivility - physical	.204**	.295**	.127**	-.028	-.019	.122**	.028	1					
9. Incivility - social	.181**	.262**	.142**	-.002	.024	.158**	.092*	.491**	1				
10. Crime trend in neighborhood	.199**	.198**	.059	.033	-.001	.112**	.051	.198**	.228**	1			
11. Community cohesion	-.058	-.132**	.060	-.018	-.018	-.093*	.002	-.032	-.093*	-.041	1		
12. Collective efficacy	-.126**	-.180**	.122**	.025	-.055	-.097*	-.023	-.063	-.122**	-.111**	.525**	1	
13. Confidence in the police	-.089*	-.099*	.012	-.020	-.146**	-.095*	-.037	-.027	-.094*	-.110**	.291**	.431**	1

* P < .05; ** P < .01

<Table 3> Fear of Crime among Native Mongolians: At Home (OLS Regression Results)

Independent Variables	Model 1 (N=666)		Model 2 (N=604)		Model 3 (N=675)		Model 4 (N=593)		Model 5 (N=675)	
	β	t	β	t	β	t	β	t	β	t
Demographic										
Age	.068	1.522					.006	.126		
Gender (Female)	.221	5.797***					.245	6.250***	.231	6.251***
Marital Status (Married)	.030	.664					.033	.709		
Income	-.045	-1.166					-.032	-.825		
Education	-.072	-1.868†					-.050	-1.257	-.069	-1.873†
Facilitators										
Victimization_Property			-.015	-.332			-.010	-.223		
Victimization_Violent			.064	1.454			.076	1.747†	.076	2.065*
Indirect Victimization			-.060	-1.399			-.055	-1.311		
Perceived Incivility_Physical			.123	2.692**			.106	2.393*	.124	2.948**
Perceived Incivility_Social			.096	2.067*			.104	2.271*	.092	2.149*
Perceived Crime Trend			.160	3.937***			.137	3.410***	.136	3.601***



Inhibitors										
Community Co-hesion					.040	.879		-.019	-.404	
Collective Efficacy					-.139	-2.982**		-.085	-1.738†	-.102
Confidence in the Police					-.025	-.609		-.037	-.863	
Home Ownership					-.041	-1.066		-.017	-.431	
R Square	.061	.078	.020	.154	.143					
Adjusted R Square	.054	.069	.014	.132	.134					
F	8.601***	8.438***	3.424**	7.006***	15.497***					

† p <.10 * p<.05 ** p<.01 *** p<.001

Dependent Variable: Fear of Crime at Home

<Table 4> Fear of Crime among Native Mongolians: On the Street (OLS Regression Results)

Independent Variables	Model 1 (N=666)		Model 2 (N=604)		Model 3 (N=675)		Model 4 (N=593)		Model 5 (N=675)	
	β	t	β	t	β	t	β	t	β	t
<i>Demographic</i>										
Age	.065	1.468					-.001	-.003		
Gender (Female)	.215	5.631***					.243	6.470***	.228	6.513***
Marital Status (Married)	.004	.090					.033			
Income	-.039	-1.017					-.016	-.428		
Education	-.069	-1.770†					-.053	-1.388	-.072	-2.077*
<i>Facilitators</i>										



МОНГОЛ УЛС ДАХЬ ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗҮЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

А.Гансүх

Хууль сахиулахын их сургуулийн докторант

Нэг. Удиртгал

Зохион байгуулалттай гэмт хэргийн нийгмийн хор аюул нь нэг улс үндэстэн төдийгүй дэлхий улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжил, соёл иргэншилд нөлөөлсөөр ирлээ.

Даяаршлын улмаас улс гүрнүүд бие биенээсээ улам бүр харилцан хамааралтай болж, ямар ч хүчирхэг эдийн засагтай байсан өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангах бололцоогүй болсон, зах зээлийн харилцаанаас шалтгаалан ажиллах хүч, бараа, бүтээгдэхүүн, хөрөнгө санхүүгийн хил хязгааргүй шилжилт хөдөлгөөний урсгал явагдаж, харилцан хамаарал гүнзгийрч байна.

Хөгжиж буй улс орнууд олон улсын банк, санхүүгийн байгууллага, их гүрнүүдийн тусламж, дэмжлэг, нөлөө ивээлд орох нь тэдгээр орнуудын хөгжлийн асуудал, үндэсний аюулгүй байдал хамаарах гол хүчин зүйл болсон ба мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засгийн шинжлэх ухааны тухай хуучин ойлголт үндсээрээ шинэчлэгдсэн, ялангуяа кибер орон зайд үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлага цоо шинээр бий боллоо.

Аливаа улсын оршин тогтнох эх үүсвэр болсон тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй, бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллага болон эдийн засаг, байгаль экологийн тэнцвэрт байдлаас үл хамаарч зохион байгуулалттай гэмт явдал ургамлын үндэс лугаа адил улам бүр тархсаар байна.

Байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлт, халдварт өвчин, хүн амын өсөлт, хүнс тэжээлийн хомсдол, өлсгөлөн, ядуурал, шашны харгис урсгалын нөлөө, олон улсын терроризм, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, салан тусгаарлах

ажиллагаа нь тухайн улс, үндэстэн төдийгүй дэлхий нийтийн улс төр, эдийн засгийн хөгжилд ноцтой хор уршиг тарих болсон,

Геополитекийн хувьд хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, буурай хөгжилтэй орон байсан бол эдүгээ хамгийн хурдацтай хөгжиж буй бүс нутаг болж, газрын доорхи баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж хэмжээний нөөц нь илэрснээр дэлхийн өндөр хөгжилтэй их гүрнүүд болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, гео-эдийн засгийн ашиг, сонирхлыг татаж байгаа нь шинэ боломж, нөгөө талаасаа шинэ эрсдлийг дагуулж байна.

Өнөөдөр Монгол Улсад үүсээд буй төр, засгийн тогтворгүй байдал, эдийн засаг, инфляцийн түвшний бууралт, улс төрийн намуудын сонгуулийн амлалт, хэт туйлширсан халамжийн бодлого, байгалийн баялагийн хуваарилалт, ард иргэдийн ядуурал, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр нийгмийн сөрөг үзэгдэл болсон терроризм, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, галт зэвсэг болон хүн худалдаалах, мөнгө угаах, мэдээллийн аюулгүй байдал, олон улсын чанартай үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэх боломж мөн өндөр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”^[36], Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4-д “Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах”^[37], 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.4.3-т “Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр”^[38]-ийг тус тус хэрэгжүүлж, улс төр, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, гадаад, дотоод хүчин зүйлд анхаарлаа хандуулан, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага урган гарч байна.

Хоёр. Монгол Улсад зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх эрх

³⁶ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Улсын Их Хурлын тогтоол, УБ хот.

³⁷ Мөн тэнд.

³⁸ Мөн тэнд.



зүйн орчин, өнөөгийн байдал, төрөл, чиг хандлага

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисой холбоотой гэмт хэргийн талаар: Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ”^[39] гэж заасан.

Монгол Улс Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцид 2001 онд тус тус нэгдэн орсон бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээдэг.

Олон Улсын нэгдэн орсон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор 2002 онд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”^[40].

³⁹ Мөн тэнд.

⁴⁰ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Монгол Улсын хууль, УБ хот.

ийг баталж, “Эрүүгийн хууль”-даа дээрх төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог хуульчилж, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”^[41]-ийг батлан 2017-2021 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны 2011 оны тайланд Америк болон баруун европын улс онуудад каннабисийн, алс болон ойрхи дорнод, зүүн өмнөд азийн улс орнуудад амфетамин, синтетик төрлийн хар тамхины хэрэглээ, үйлдвэрлэл харьцангуй нэмэгдэж, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг үндэстэн дамнасан зохион байгуулалтай бүлэглэлүүд хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад мансууруулах бодисын

⁴¹ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Засгийн газрын тогтоол, УБ хот.



үйлдвэрлэлээ шилжүүлэн байрлуулж байгаа талаар дурьдсан байна.

Мөн албанаас 2012 онд гаргасан тайланд дурдсанаар дэлхийн хэмжээнд 15-64 насны 230 сая хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж байгаагаас 27 сая орчим нь тогтмол хэрэглэдэг. Үүнээс 200 орчим сая хүн каннабис, 15 орчим сая хүн амфетамин, 15,9 сая хүн опиум /героин/, 13,7 сая хүн кокаин хэрэглэдэг гэсэн судалгаа гарсан байна.^[42]

⁴² НҮБ-ын “Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх

Дэлхийд хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн сүлжээ үүсгэн идэвхтэй ажиллаж байгаа “Алтан гурвалжин” буюу /Тайланд, Лаос, Мьянмарын хилийн бүс/, “Алтан хавирган сар” буюу /Афганистан, Пакистан, Ираны хилийн бүс/, “Мөнгөн гурвалжин” буюу /Колумб, Болив, Перу, Мексикийн хилийн бүс нутаг/, “Хар гурвалжин” буюу /Нигер, Гана, Кени, Судан, Өмнөд африк/ гэгдэх Африкийн

алба”-ы 2011, 2012 оны тайлан.



орнуудын гэмт бүлэглэлүүд Төв болон Зүүн өмнөд Азийн орнуудын иргэдийг хар тамхины хууль бус наймаанд элсүүлэх, татан оролцуулах, тээвэрлүүлэх явдал газар авч байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт гол төлөв Зүүн өмнөд Азийн орнуудад сурч буй манай улсын оюутан залуус, биеэ үнэлэгчид, хулгай хийх зорилгоор маршрутаар зорчигч иргэд тээвэрлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэй холбоотой гэмт хэрэгт монголчуудын амьжиргааны түвшин доогуур, энэ талын мэдлэг, мэдээлэл дутмаг, амар хялбар аргаар мөнгө олох хүсэл, сонирхолтой байдгаас гадна Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих давуу тал байдаг нь гол хүчин зүйл болж байна.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд урд, хойд хоёр хөршөөс болон зүүн өмнөд азийн орнуудаас амфетамин, метамфетаминь төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо өсч байна. Ялангуяа БНХАУ-аас ихэвчлэн амфетамин, метамфетаминь төрлийн мөс (ICE) болон мансууруулах ургамлын гаралтай шавар (Hashish), ОХУ-аас сэтгэцэд нөлөөт анданте зэрэг эм хууль бусаар нийлүүлэгдэж байна.^[43]

Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн мэдээллээр сүүлийн 11 жилийн байдлаар манай улсын 94 иргэн БНХАУ-д, тус тус 5 иргэн Малайз, ОХУ-д, тус бүр 3 иргэн Унгар, Бангладеш, Казакстанд, тус бүр 1 иргэн Герман, Грек, Болгар, Славакад, нийт 10 улсад 117 иргэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 109 иргэн шүүхээр /Үүнд: тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хууль бусаар хил нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан 1 иргэн/ ял шийтгэгджээ.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэлд дурьдснаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэж, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, улсын хилээр нэвтрүүлэх” гэмт хэрэг 388 бүртгэгдэж, 1112 хүнийг холбогдуулан шалгасан байна.^[44]

Энэ төрлийн бодисын хэрэглээг 2010 хүртэл манай оронд ургадаг мансууруулах

⁴³ Цагдаагийн байгууллагын тайлан, 2016 он, УБ хот.

⁴⁴ “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал-2016” 216-226 дахь тал, 2017 он, УБ хот.

үйлчилгээтэй зэрлэг олсны ургамал / каннабис/-ын төрлийн бодис эзэлдэг байсан бол 2010 оноос хойш химийн аргаар боловсруулсан сэтгэцэд нөлөөт бодис болох /ICE/ амфетамин, метамфетамин агуулсан мөс эзэлж, нийгмийн бүхий л давхаргын хүмүүсийг хамарч байна.

Сүүлийн жилүүдэд гэмт этгээдүүд хар тамхи, мансууруулах бодисыг олон улсын шуудан илгээмжээр болон цахилгаан бараа, ахуйн болон хүнсний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнд нуух, бусдад дайж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх хандлагатай байгаа ба борлуулахдаа товлосон газарт нууж үлдээх, төлбөр тооцоогоо урьдчилан бусдын дансаар шилжүүлэн авах зэргээр үйлдэж байна.

Энэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэргийн гүйцэтгэгч нь /тээвэрлэгч, борлуулагч/ урьд өмнө хулгай, дээрэм, танхай, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл эдэлж байсан этгээдүүд байна.

Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодис болон химийн урвалд оруулсан нийлэгжүүлсэн бодисын хамаарал бүхий хэрэглэгчдийг эмчлэх стандарт, энэ төрлийн эмгэгтэй этгээдүүдийг эмчлэх эмнэлэггүй байгаа нь хуульд заасан эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээг авах, албадан эмчилгээнд хамруулах боломжгүй байдалд хүргэж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь дээрх бодисыг хэрэглэдэг хамаарал бүхий этгээдүүдийн хүсэлтийг үндэслэн хүлээн авч, хордлого тайлах үйлчилгээ үзүүлэхээс хэтрэхгүй байгаагаас хэрэглэгчдийн тоо буурахгүй байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар: Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4.2-д “Хүүхэд, эмэгтэйчүүд иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ” гэж заасан.

Монгол Улс НҮБ-ын 1979 оны “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцид 1981 онд, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2008 онд батлан гаргасан “Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох,



шийтгэх тухай протокол^[45]”-д тус тус нэгдэн орсон.

УИХ-аас анх удаа 2000 онд “Хүний биеийг үнэлүүлж, ашиг олохоор хууран мэхэлж, гадаадад гаргасан бол ял шийтгэх” заалтыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлд шинээр оруулж, 2012 онд “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг, Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 148 дугаар тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус баталсан явдал нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Өнөөдөр хүн худалдаалах гэмт хэрэг нь хүн төрөлхтний өмнө тулгарч буй сэтгэл түгшээсэн асуудал болж, хүрээгээ тэлсээр байгаа нь дэлхийн улс орнууд, тэдгээрийн төр, засгийн анхаарлын төвд зүй ёсоор орох боллоо. НҮБ-ын мэдээгээр жилд дунджаар 1 сая орчим хүүхэд, эмэгтэйчүүд болон эрчүүд бэлгийн болон бусад төрлийн мөлжлөг, хүний эд эрхтэн наймаалах зорилгоор худалдаалагдаж байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс олж буй хууль бус ашиг орлого 31.6 тэрбум ам долларт хүрч байна гэсэн судалгаа байна. Үүний 49 хувь нь аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орнуудад, 30.6 хувь нь Ази, Номхон далайн орнуудад, 4.1 хувь нь Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад, 5 хувь нь Африкийн Сахарын орнууд, 4.7 хувь нь Ойрхи Дорнод болон Хойд Африкийн бүс нутгуудад явагдаж байна^[46].

Хүн худалдаалах гэмт хэрэгт ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд, боолын худалдаанд эрэгтэйчүүд өртөж байна. АНУ-ын ТТГ-ын мэдээнд “Европт нийт худалдаалагдсан хүмүүсийн 2 хувийг эрчүүд эзэлдэг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын ойролцоогоор 80-90 хувь нь бэлгийн мөлжлөгийн золиос болж” байгаа талаар дурьджээ.

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт ихэвчлэн охид, залуу эмэгтэйчүүд өртдөг байна. Судалгаанаас үзвэл 30 хувь нь 18-21 насны, 20 хувь нь 21-26 насны, 11 хувь нь насанд хүрээгүй эмэгтэйчүүд байна^[47]. “Гадаадад

⁴⁵ Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 55/22 тоот тогтоол.

⁴⁶ Human trafficking, change, org сайт.

⁴⁷ Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн /2009/ Хүн худалдаалах гэмт хэргийн шийвэрлэлт судалгааны тайлан, 12 тал,

өндөр цалинтай ажиллуулна, тэтгэлэгт сургалтад хамруулна” гэх мэт хуурамч зар сурталчилгаа явуулж, хохирогчдын эмзэг байдлыг далимдуулан хууран мэхлэх, хүч хэрэглэх замаар охид, эмэгтэйчүүдийг аргагүй байдалд оруулан Хятад, Малайз, Макао, Хонг Конг болон Европийн зарим оронд хүчээр биеийг нь үнэлүүлж, ашиг олох замаар худалдаалдаг. 2003 онд 1, 2004 онд 4, 2005 онд 3, 2006 онд 11, 2007 онд 42, 2008 онд 27, 2009 онд 51 буюу нийт 139 охид, эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж, туслалцаа, дэмжлэг авсан талаар Хүйсийн тэгш эрхийн төвөөс мэдээлжээ.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоо бүхэлдээ эрс өөрчлөгдөн, зах зээлийн харилцаанд шилжсэн, эдийн засгийн хөгжлийн түвшин буурай, иргэдийн нийгэм, эрх зүйн мэдлэг дутмаг, нийгмийн сөрөг үзэгдэл болсон ажилгүйдэл, ядуурал буурахгүй байгаа, эмэгтэйчүүд биеэ үнэлэх явдал газар авсан^[48], иргэдээс гадаад оронд ажиллах сонирхол нэмэгдэж гадагшаа чиглэсэн ажиллах хүчний урсгал бий болж, түүнийг дагаад виз, паспортын хууль бус ажиллагаа идэвхижсэн, эмэгтэйчүүд гадаадын иргэнтэй гэр бүл болох нь ихэссэн, эрх зүйн орчин боловсронгуй бус байгаа зэрэг нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болж байна.

Дэлхийн хөгжингүй улс гүрнүүдэд ялангуяа манай өмнөд хөрш /БНХАУ/-д хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эрчимтэй хөгжиж байгаа нь хүний эд, эрхтний томоохон эрэлт бүхий зах зээлийг бий болгож болзошгүй байна.

Мэдээллийн технологи харьцангуй хурдтай хөгжиж байгаатай уялдан гэмт этгээдүүдээс олон нийтийн сүлжээ сошиал медиа “Facebook” болон интернет сайт, блог ашиглан хохирогчдын талаар мэдээлэл цуглуулж, үйлдлийн аргаа өөрчилж байна.

Монгол Улсад “Гэр бүл зуучлал”-ын нэрийдлээр охид эмэгтэйчүүдийг гадаадын иргэдтэй тодорхой төлбөртэйгээр гэрлүүлэх явдал нэлээд дэлгэрээд байна. 2003-2007 оны хооронд гадаадын иргэнтэй гэрлэсэн монголчуудын тоо 446 хүнээр буюу 54.1 хувиар өссөнөөс 95 орчим хувь нь эмэгтэйчүүд байгаагаас 70 хувь БНСУ-ын

2009 он, УБ хот.

⁴⁸ Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Үндэсний статистикийн хорооноос 2010 онд хийсэн судалгааны тайлан. 19 дэх тал, 2010 он, УБ хот.



иргэдтэй гэр бүл болсон байна.^[49]

Манай улсын хувьд хүн худалдаалах гэмт хэрэг нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор БНХАУ болон зүүн өмнөд Ази руу чиглэсэн урсгал, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор Европ, Ази тив рүү чиглэсэн урсгал тогтох хандлагатай байна.

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор саун, массаж нэршилтэйгээр газруудад охид бүсгүйчүүдийг биеийг үнэлүүлж ашиг, орлого олох нь түгээмэл болжээ. Анх 2000 оны үеэс саун, массажны газрууд нь “бүтэн биеийн массаж” тусгай үйлчилгээ нэршилтэйгээр бэлгийн үйлчилгээ үзүүлж эхэлж байсан бол сүүлийн жилүүдэд “тосон.., сүүн.., гулгаа.., кантра массаж” гэх нэршлээр ямар нэгэн гаднаа нэр хаяггүй гаруудад, охид, бүсгүйчүүдийн биеийг үнэлүүлж, тэдэнд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглүүлж, тусгай харуул, хамгаалалтан доор зохион байгуулалттайгаар явуулдаг болсон байна.^[50]

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлд сүүлийн 7 жилд (2010-оны 11 сар хүртэл) хүн худалдаалах 43 гэмт хэрэг, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 113 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

№	ЭХТА-ийн зүйл	Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Бүгд
1	113	Хэрэг	1	6	9	10	8	6	3	43
		Хохирогч	3	4	2	13	15	10	5	52
		Холбогдогч	1	4	7	18	12	9	6	57
2	124	Хэрэг	10	15	14	13	17	28	16	113
		Хохирогч	6	7	11	7	10	15	8	64
		Холбогдогч	11	15	16	8	13	30	18	111

Дээрхи тоон үзүүлэлтээс харахад хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг тогтвортой буурахгүй байна. Энэ нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал, зохион байгуулалттайгаар үйлдэгддэг, хохирогчийн зүгээс өөрийн нэр төр, алдар хүндтэй холбоотойгоор тэр бүр хуулийн байгууллагад гомдол гаргадаггүй байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд биеэ үнэлэлт, түүнийг зуучлах зохион байгуулах гэмт явдал нууц далд хэлбэрт шилжиж зохион байгуулалтанд орох, насанд хүрээгүй хүнийг садар самууны сурталчилгаанд ашиглах, татан оруулах, бэлгийн мөлжлөгт ашиглах, гэмт хэрэгт татан оруулах зэрэг хууль бус үйлдэл нэмэгдэх хандлагатай байна.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг гэмт этгээдүүдэд нь хохирогчид шууд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх бус, харин гадаадад хөдөлмөр, эрхлэх, суралцахад зуучлах зорилгоор хуурч мэхлэх, залилан авч явж байгаа нь тогтоогдож байна.^[51] Тухайлбал: гэмт хэргийн золиос болгож элсүүлэх, тээвэрлэх, хил нэвтрүүлэх ажиллагааны 90 гаруй хувь нь залилах, хууран мэхлэх замаар үйлдэгдэж байгаа бол, хүлээн авагч оронд очсоны дараа хохирогчид хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх аргыг хэрэглэдэг байна.

Одоогоор ял шийтгэгдсэн этгээдийн дийлэнх нь Монгол Улсын иргэн байгаа боловч, гадаадын харъяат /Хятад, Солонгос, Англи/ иргэдтэй хамтарч хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн тохиолдол цөөнгүй байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн хэргийн өнгөөр нь авч үзвэл зөвхөн бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн байна. Харин хөдөлмөрийн мөлжлөг болон хүний эд эрхтэн худалдаалсан хэрэг шүүхээр огт шийдвэрлэгдээгүй байна.

Хүн худалдаалах хэргийн хэлбэр нь хөдөлмөрийн мөлжлөг бөгөөд бусдыг албадан

⁴⁹ Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, /2008/ Хүн худалдаалах гэмт хэргийн шийвэрлэлт судалгааны тайлан, Гадаадын иргэнтэй гэр бүл болж байгаа талаарх судалгаа. 2008 он, УБ хот.

⁵⁰ Цагдаагийн байгууллагын нөхцөл байдлын танилцууллага, 2017 он, УБ хот.

⁵¹ www.leu.gov.mn/content/ Б.Мөнхдорж, “Хүн худалдаалах гэмт хэрэг үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлж болзошгүй”, 2017.11.22, УБ хот.



хөдөлмөрлүүлэх, боолын хөдөлмөр эрхлүүлэх, зарцлах, өрийн барьцаанд байлгах, хүүхэд, эхнэрийг барьцаалж мөнгө нэхэмжлэх, гуйлга гуйлгуулах зэргээр илэрдэг бол хүний эд эрхтэнг авах болон “бие эрхтний мөлжлөг” нь мансууруулах бодисын шууданч болгох, албадан гэрлүүлэх, хүүхэд тээлгэх хэлбэрээр үйлдэгддэг.

Түүнчлэн хөдөлмөрийн гэрээ зөрчих гэдгийг гурван “D” буюу Dangerous-амь насанд аюултай, Difficult-хүнд хүчир, Dirty-бохир заваан нөхцөлд ажиллахыг шаардахыг ойлгож болно.

Мөнгө угаах гэмт хэргийн талаар: Монгол Улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг 2000 оны Палермогийн Конвенц, Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай 1999 оны Конвенц, Авлигалын эсрэг 2003 оны Меридагийн Конвенц, Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АРО)-ийн гишүүнээр тус тус элсэж, нэгдэн орсон.

Улсын Их Хурлаас 2013 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийг шинэчилсэн найруулж, Засгийн газраас мөн оны 348 дугаар тогтоолоор “Террорист этгээдийн жагсаалтанд оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байгаа явдал билээ.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.6-д “Гадаад, дотоод томоохон төлбөр, тооцоо, зээл, аккредитивийн хөдөлгөөнд хяналт тавих, эдийн засаг, санхүүгийн салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлнэ.” гэж заасан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах, бодлого боловсруулах чиг үүрэг бүхий дотоод хамтын ажиллагааны механизм болох “Хамтын ажиллагааны зөвлөл” нь Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд 2006 оноос хойш одоог хүртэл ажиллаж байна.

Тус зөвлөлд Монголбанк, Санхүүгийн

зохицуулах хороо, Сангийн яам, Хууль, зүй дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл багтдаг.

Мөнгө угаах хэмээх нэр томъёо 1930-аад оны үед анх Чикагогийн Сицили гаралтай мафийн толгойлогч Аль Капоне өөрийн мэдэлд байсан хими цэвэрлэгээний газруудын санхүүгийн тайланд өөрсдийн орлогоо хэд дахин ихэсгэж бичээд түүн дотроо бохир мөнгөө шингээж хууль ёсны мэт харагдуулдаг байснаас үүдэлтэй ажээ.^[52]

НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенцид “мөнгө угаах”-ыг гэмт хэргийн үндсэн шинжийг

-Гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг нуух, далдлах, эсхүл хууль бус үйл ажиллагаа явуулсан этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх, шилжүүлэх,

-Гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмших буюу бусад эрхийг нуух, далдлах,

- Гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийг авах, эзэмших, ашиглах гэж тодорхойлсон байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь үндсэн 3 үе шатаар явагддаг. Үүнд:

Placement буюу байршуулах эхний үе, шат: Энэ үед хууль бусаар олсон мөнгө, эд зүйлсээ хаа нэгтэй байршуулдаг. Тухайлбал: Бусдын нэр дээр банкинд хадгаламж болон харилцах данс нээлгэх, үнэт цаас, чех худалдан авах, алт үнэт зүйлс хадгалуулах гэх мэт.

Layering буюу нуун далдлах хоёрдахь үе, шат: Байршуулсан мөнгө, эд зүйлсээ хөрөнгө оруулалт, хандив тусламж, хүүтэй зээл, бусдын нэр дээр объект, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, асрамжын болон бучны байгууллага, сан, компани, банк байгуулах, тэдгээрийг даатгуулах зэрэг үйлдэл хийгддэг.

Integration буюу эргэлтэд оруулах үе: Сүүлийн шатанд гарал үүслийг нь нуусан

⁵² www.masd.mn/wp-content/uploads/ “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн тухай ойлголт”, Б.Төмөрбат, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, 2017 он, УБ хот.



мөнгийг хууль ёсны эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг ойлгодог. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хийсэн газраас зарах, түрээслэх замаар ашиг олох, зээлсэн мөнгөнийхөө хүүг авах, компани, сангийн тодорхой хувь зэмшигч болох, үүсгэн байгуулсан банкаа санаатай дампууруулж даатгалын байгууллагаас их хэмжээний нөхөн төлбөр авах^[53] гэх мэт.

Судлаачдын тооцоолсноор дэлхий дээр өдөр бүр банкны цахим дансаар 500.000 гаруй удаагийн мөнгөн гуйвуулга хийгддэг ба энэ нь дунджаар 1 их наяд ам. долларгай тэнцдэг байна. ОУВС, Дэлхийн банк болон АНУ-ын Төрийн департаментын гаргасан тооцоогоор дэлхий дээр угаагдаж буй мөнгөний хэмжээ дэлхийн улс орнуудын ДНБ-ий 2-4 хувьтэй тэнцдэг, мөнгөн дүн нь 590 тэрбумаас 1 их хаяд 500 тэрбум ам. долларт хүрсэн гэсэн тооцоог гаргажээ. Энэхүү 590 тэрбум ам.доллар гэдэг нь Испанийн ДНБ-ий хэмжээтэй тэнцэж байна.

Сүүлийн үеийн мэдээнээс үзвэл ОХУ-д мөнгө угаах чиглэлээр байгуулагдсан 3000 гаруй байгууллага байдаг гэх бөгөөд үүний 1500 гаруй нь хувийн банк ажээ. Мөн дээрх хэлбэрээр байгуулагдаагүй ч мөнгө угаах, дамжуулахад тусалж, тэдний хяналтанд ажилладаг төрийн болон төрийн бус 40000 гаруй байгууллага бий гэсэн мэдээ байна. 2003 онд их хэмжээний мөнгө угаасан явдалд Их Британийн нэртэй банк болох Int'l Bank of Credit & Commerce холбогдож багагүй шуугиан тарьсан билээ.

ХБНГУ-ын судлаач П.Бернаскон мөнгө угаах гэмт хэрэгт холбоотой улс орныг «үндсэн улс», «туслах улс» гэж хоёр ангилсан байна. «Үндсэн» гэдэг нь үндсэн мөнгө угаах гэмт ажиллагаа явагддаг улс, харин «туслах» гэдэг нь мөнгө угаах зорилгоор бохир мөнгөө шилжүүлсэн тэр улсыг хэлнэ гэж тодорхойлсон ажээ.

Санхүүгийн байгууллагуудаар дамжуулан бохир мөнгөө өөр улсад үйл ажиллагаа эрхэлдэг өөрийн аль нэг байгууллагад гуйвуулахдаа хэд, хэдэн банк юм уу, нэг банкны хэд, хэдэн данс ашиглаж мөнгөө хэд, хэдэн удаа хуваан шилжүүлдэг байна. Тухайлбал хүлээн авч буй нөгөө улсад нь мөн хэд, хэдэн данснаас хүлээн авч байх жишээтэй. Учир нь АНУ, ОХУ, Австрали, ХБНГУ зэрэг улсад банкаар гуйвуулж буй мөнгөний болон хуулийн этгээдүүдийн хооронд байгуулж буй гэрээ, хэлцлийн

мөнгөний хэмжээг хуулиар тогтоосон тодорхой хэмжээнд хүрсэн тохиолдолд төрийн зохих байгууллагаас хяналт шалгалт хийдэг. Тухайлбал энэ хэмжээг АНУ-д 10.000 доллар, ОХУ-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг иргэд хооронд 2.000 дахин, хуулийн этгээд хооронд 20.000 дахин ихэсгэсэнтэй тэнцүү хэмжээгээр байдаг бол Монгол Улсад 20.000.000 төгрөгнөөс дээш гүйлгээг шалгахар тус тус тогтоосон байна.^[54]

Дээрх, ойлголт, тодорхойлолтоос харвал Монгол Улсад “туслах улс”-ын үндсэн шинжүүд байна гэж үзэхээр байна. Тухайлбал: Хадгаламж авдаггүй, зээл олгодоггүй хэрнээ үйл ажиллагаа явуулж буй гадны хөрөнгө оруулалттай гэх зарим банк ихээхэн анхаарал татаж байна. Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх арга, механизм боловсронгуй болоогүй байгаа нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж, бүртгэгдээгүй гэх ойлголтын үндсийг бүрдүүлж байна.

2011-2016 оны жилийн эцсийн байдлаар Цагдаагийн байгууллага Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дугаар зүйлд заасан мөнгө угаах зүйл, заалтаар эрүүгийн хэрэг үүсгэсэн 28 гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас ажиллагаанд шалгагдаж байгаа 6, хууль заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 4, мөрдөн байцаалт болон прокурорын шатанд хэрэгсэхгүй болсон 15, шүүхэд шилжсэн 3 хэрэг байна.^[55]

Мөн тухайн үед Засгийн газрын 80 дугаар тогтоолоор төрийн өмчийн “Сэргээн босголт” банкыг хувийн өмчийн “Голомт” банкттай нэгтгээд, дараа нь дампууруулж, дундаас нь их хэмжээний мөнгө завшсан гэх сэжиг гарч байсан. Түүнчлэн Транс банкны эргэн тойронд болж буй шуугиан ч анхаарал татсаар байна.

Терроризмийн талаар: Улсын Их Хурлаас 2004 онд “Терроризмтой тэмцэх тухай”, 2013 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх”^[56] хуулиудыг тус тус батлаж, “Эрүүгийн” болон “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай”

⁵⁴ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, /7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт/, УБ хот.

⁵⁵ “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал-2016” 218-220 дахь тал, 2017 он, УБ хот.

⁵⁶ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Монгол Улсын хууль, УБ хот

⁵³ Мөн тэнд...



хуулийн холбогдох зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан нь терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдүүлэхэд чухал алхам болсон. Дээрх хууль эрх зүйн актуудын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 348 дугаар тогтоолоороо “Террористуудын жагсаалтад оруулах, тэдгээрийн хөрөнгийг зогсоох, хянах журам”^[57]-ыг баталж хэрэгжүүлж байна.

Терроризмтой тэмцэх тухай хуульд зааснаар Монгол Улсын Засгийн газар нь терроризмоос сэргийлэх ажлыг удирдах үндсэн субъект бөгөөд хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны захирамжаар “Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл” хүлээдэг бөгөөд зохицуулах зөвлөлийг Тагнуулийн ерөнхий газрын дарга тэргүүлж, 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Энэ чиг үүргийн дагуу цагдаагийн байгууллагын салбар зөвлөлөөс терроризмоос сэргийлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах, олон улсын терроризмын нөхцөл байдалд тогтмол дүн шинжилгээ хийж, терроризмын шинэ, арга хэлбэрийг судлах, холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, терроризмтой тэмцэх чадавхи, үндэсний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, зөвлөлд төлөөлөлтэй байгууллагын холбогдох албан хаагчдыг гадаадад урт болон богино хугацааны сургалтад хамруулах, тусгай хүчний бэлтгэлжилт, ур чадварыг нэмэгдүүлэх нэгдсэн болон бүсийн сургалт, цугларалтыг тогтмол зохион байгуулан ажилладаг байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.4.1-д “Иргэдийн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулна”^[58] гэж заасан.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс Терроризмын эсрэг Олон улсын 13 конвенц, протоколд нэгдэн орсноор дэлхийн улс орны өмнө олон талт үүрэг хүлээсэн.

⁵⁷ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Засгийн газрын тогтоол, УБ хот.

⁵⁸ www.legalinfo.mn/law/ сайт, Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем, Улсын Их Хурлын тогтоол, УБ хот.

Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/ нь “Их найм” гэгддэг орнуудын Сангийн сайд нарын 1989 онд байгуулсан засгийн газар хоорондын байгууллага юм. 2012 оны байдлаар ФАТФ-т дэлхийн хөгжилтэй гэх 36 орон гишүүнээр элссэн бөгөөд түүнд одоогоор НҮБ, ОУВС, Дэлхийн банк, АХБ, Интерпол зэрэг 27 ажиглагч олон улсын байгууллага хамтран ажиллаж байна.

ФАТФ-ын зорилго бол мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон олон улсын санхүүгийн найдвартай, тогтвортой байдалд заналхийлэгч бусад хүчин зүйлстэй тэмцэхэд үр дүнтэй хууль эрх зүй, зохицуулалт, хяналт шалгалт болон үйл ажиллагааны арга хэмжээг дэмжих, тэдгээрийн стандартыг тогтооход оршдог. Тиймээс, ФАТФ бол энэ салбарт улс орнуудын үндэсний эрх зүй болон зохицуулалтын шинэчлэлийг бий болгоход шаардлагатай улс төрийн хүсэл зоригийг төрүүлэхийн тулд ажилладаг “бодлого боловсруулагч байгууллага”^[59] юм.

ФАТФ энэ зорилгоор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор нь хөнөөх зэвсгийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт гэж дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн 40 Зөвлөмж /40 FATF Recommendations/-ийг боловсруулж гаргасан.

АНУ-ын Төрийн департамент 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Терроризмын асуудлаарх улс орнуудын тайлан-2015”-даа дэлхийн улс орнуудад 50 орчим террорист байгууллагууд олон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа талаар дурьджээ.



Терроризмын гэмт хэргийн давтамж сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх боллоо. «Global Terrorism Database»-ийн гаргасан судалгаагаар 2000-2014 оны хооронд буюу 15 жилийн дотор 61 мянган террорист халдлага болж, 140 мянган хүн амь үрэгдсэн.^[60] талаар дурьдсан байна.

⁵⁹ www.fatf-gafi.org сайт.

⁶⁰ www.view.mn/news/ Ц.Гэрэлтуяа, “Орчин үеийн дэлхий дахины даяар асуудал болох Терроризм гэж юу



Эдийн засаг, эрх чөлөөний институтийн гаргасан судалгаагаар террорист халдлагын улмаас 2013 онд 18111 хүн амиа алдаж байсан бол 2014 онд 80 хувиар өсөж 32658 болсон байна. 2014 онд амиа алдсан хүмүүсийн ихэнх нь Ирак, Нигери улсад, 51 хувийг Исламын улс, Боко Харам террорист бүлэглэлээс үйлджээ.^[61]

Террорист ажиллагаа явуулдаг бүлэглэлүүд өөр, өөрийн гэсэн арга, тактикаар халдлага үйлддэг. Тухайлбал: Бока харам бүлэглэл автоматаар зэвсэглэн халдлага үйлддэг бол, Исламын улс бүлэглэл ихэвчлэн амиа золиослох хүмүүсийг барьцаалж олон нийтийн газарт халдлага үйлдэгдгээр онцлог байна.

2014 онд үйлдэгдсэн хамгийн томоохон халдлагын талаар:



“Ирак Левантын Исламын улс” бүлэглэл нь Ирак, Сири, Ливаны нутагт үйл ажиллагаагаа явуулдаг төв нь Сирийн Раккад байдаг лалын террорист байгууллага бөгөөд анх 2006 оны 10 дугаар сарын 15-д Иракт алан хядагч “Аль-Кайда”-ын удирдлага доор 11 бүлэглэл нэгдсэнээр байгуулагдсан байна.

Тус бүлэглэл нь 2011 оноос үйл ажиллагаагаа эрчимжүүлж эхэлснээс хойш 25 мянган хүн элсэж, нийт 90 орчим мянган гишүүнтэй бөгөөд 2015 оны эхний зургаан сарын байдлаар 7 мянган гишүүн бүлэглэлээс гарчээ. “Ирак Левантын Исламын улс” бүлэглэл нь Ирак, Сири, Ливаны нутаг дэвсгэрт лалын сунит урсгалын халифатын нэгдсэн улс байгуулах зорилгоор 2013 оноос эхлэн Засгийн газрын эсрэг хүчинтэй нэгдэж, Башар Асадын дэглэмийг эсэргүүцэн тэмцэж, өөрийн ажиллагааг эсэргүүцсэн улс орнуудад халдлага үйлдэж, заналхийлсээр байгаа бөгөөд удирдагч Абу-Бакр Аль Багдади өөрийгөө бүх мусульманы ертөнцийн халиф гэж зарласан юм.^[62]

2017 оны 11 дүгээр сарын 24-ний баасан бэ.” Нийтлэл, 2017.04.24, УБ хот.

⁶¹ www.itoim.mn/index.php Б.Сувд-Эрдэнэ, Эдийн засаг, эрх чөлөөний институт, 2014 онд дэлхийн 160 улсад хийсэн судалгааны үндсэн дээр гаргасан “эрх чөлөө, терроризмийн индекс” 2017.11.24, УБ хот.


⁶² <http://www.zaluu.com/read/> П.Булган, Синайн хойгийн аллага ба Исламын терроризмын түүх, 2017.11.27, УБ хот.

гаригт Синайн хойг дахь Египетийн Бир эл-Абед хотын Исламын нэгэн сүмд лалын хэт даврагчид халдлага үйлдэж, 305 хүний амийг хөнөөж 128 хүнийг шархдуулсан байна. Амиа алдагсдын дунд 27 хүүхэд байжээ. Энэ цуст халдлагыг Египетийн ерөнхий прокурор мэдэгдэл гаргаж халдлага үйлдэгч «Исламын улс»-ын далбаа барьж байсан талаар дурьджээ. Армийн дүрэмт хувцастай, баг зүүсэн 25-30 алан хядагч, 5 ланд круйзер машинаар ирж, сүмийн бүх гарцыг хааж, дотор нь тэсрэх бөмбөг тавьж, мөргөлчдийг дэлбэлж, тэсрэх бөмбөгөнд өртөөгүй хүмүүсийг автомат буугаар шүршсэн тухай тэнд байсан гэрчүүд мэдээлжээ.^[63]

Нигерийн хэт даврагч “Бока харам” бүлэглэл нь сүүлийн үед улам хүчирхэгжиж, алсын тусгалтай пуужин ашиглаж Нигерийн 18 хот, тосгодыг эзэлж, ноёрхолоо тогтоогоод байгаа билээ.^[64]

Монгол Улсад одоогоор террорист ажиллагаа бүртгэгдээгүй, 2014 оны байдлаар дэлхийн 160 орноос терроризмын индексээр 124 дүгээрт бичигдсэн байна.^[65]

Монгол Улс олон улсын терроризмын аюул нүүрлээгүй дэлхийн цөөн улсын нэг бөгөөд энэ талаар АНУ-ын Дипломат аюулгүй байдлын товчооны “Монгол Улсын гэмт хэрэг ба аюулгүй байдлын тайлан-2015”-д дурдсан байна. Одоогоор терроризмын аюул нүүрлээгүй байгаа хэдий ч энэ аюулаас урьдчилан сэргийлэх, болгоомжлох, аюулгүй байдлаа хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж, дэлхийн болон бүс нутгийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэн оролцох нь зайлшгүй билээ.



Гурав. Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх талаар хийж хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаар

Шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн шинэ эрин үед дэлхийн улс орнууд

⁶³ <http://www.zaluu.com/read/> М.Баяр, Египет дэх аймшигт террорист хядлагаар 305 хүн амиа алдсан хэрэг, 2017.11.27, УБ хот.

⁶⁴ <http://www.itoim.mn/index.php> Б.Сувд-Эрдэнэ, Эдийн засаг, эрх чөлөөний институт, 2014 онд дэлхийн 160 улсад хийсэн судалгааны үндсэн дээр гаргасан “эрх чөлөө, терроризмийн индекс” 2017.11.24, УБ хот.

⁶⁵ Мөн тэнд...



зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх стратегийг өөрийн орны хүн ам, нийгэм эдийн засаг, улс төрийн онцлогийг харгалзан тодорхой төрлийн зохион байгуулалттай гэмт явдлын криминал шинжид үндэслэн харилцан адилгүй байдлаар тодорхойлж байгаа хэдий ч нийтлэг нэг зарчимд суурилсан стратегийг боловсруулж байна. Үүнд:

- Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхийн тулд гэмт бүлэг, байгууллага, сүлжээний гишүүд, оролцогчдын хойноос ангуучлан цаг, хүн хүчээ барж тэмцэх бус харин тэдний үйл ажиллагааг байнгын хяналтад авч, хамгийн эрсдэл багатай, ашиггүй нөхцөл байдал үүсгэхийг хууль сахиулагчид чухалчлах болжээ. Өөрөөр хэлбэл тэдний хууль бусаар их хэмжээний ашиг олох үйл ажиллагаа руу татан оруулж байгаа тэр нийгмийн харилцаа, эрх зүйн орчны хийдэл, сул орон зайг арилгах, бүдгэрүүлэх нь хамгийн чухал ач холбогдолтой стратеги гэж үзэх болсон. Сүүлийн үед дэлхийн хөгжингүй орны хууль сахиулах байгууллагууд энэ стратегийг амжилттай хэрэгжүүлж техник, технологийн хөгжил дэвшил, гүйцэтгэх ажлын арга, хүч хэрэглийг ашиглан гэмт бүлэглэлүүдийн төлөвлөгөөг урьдчилан мэдэж, улмаар мансууруулах бодис тарьж ургуулах, боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх бүхий л шатыг хяналтандаа авснаар гэмт үйл ажиллагааг таслан зогсоож, тэдний үйл ажиллагааг эрсдэлтэй, ашиггүй болгон улс орноосоо дайжуулах зорилтыг амжилттай хэрэгжүүлж байна.

-Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх бас нэг чухал стратеги нь хууль сахиулах байгууллагаас төрийн болон төрийн бус иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах хамтын ажиллагаа юм. Энэ нь дан ганц хууль сахиулах байгууллага зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх биш нийгмийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг татан ороцуулах, тэдний хамтын ажиллагааг боловсронгуй болгох стратеги юм. Үүний нэг жишээ нь: Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа нь гарцаагүй баримтлах шаардлагатай зарчим болдог.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 77 дугаар

тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжилтийг хангуулах ажиллагааг зохион байгуулан явуулж байна.

Монгол Улсын хувьд анх 1993 онд Эрүүгийн цагдаагийн газарт Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тасагт хар тамхи хариуцсан 2 орон тоог бий болгож байсан бол ЦЕГ-ын даргын 2012 оны тушаалаар Эрүүгийн цагдаагийн газрын бүтцэд “Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх хэлтэс”-ийг, 2017 онд Эрүүгийн цагдаагийн албаны бүтцэд “Хар тамхитай тэмцэх газар”-ыг тус тус байгуулж мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал алхам болсон билээ.

Дүгнэлт

Олон улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн чиг хандлагаас харахад дэлхийн аль ч өнцөг буланд байгаа хил хязгаараас үл хамааран төрийн байгууллагын үйл ажиллагаа суларсан, эрх зүйн орчин хийдэлтэй, хөгжиж байгаа болон хөгжингүй улс орнуудад гэмт үйл ажиллагаа явуулах, нэгдмэл эрх ашиг сонирхолтой байгаа нь ажиглагдаж байна.

Аливаа улс орны эдийн засаг, нийгмийн өсөлт, гадаад, дотоодын хүчин зүйл, хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын хөгжил нь сөрөг талаараа нийгмийн үзэгдэл болох эрүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлэн, зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж болзошгүй байна.

Дэлхийн улс орнуудын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэж байгаа тэргүүн туршлагыг өөрийн орны эрх зүйн орчинд хуулбарлах биш харин улс төр, эд засгийн өнөөгийн нөхцөл байдал, дэд бүтэц, хөрш зэргэлдээ орнуудын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа стратегитэй уялдуулан, монгол хөрсөнд буулгах нь чухал юм.

Түүнчлэн төр, түүний хууль сахиулах байгууллагын гэмт хэрэгтэй тэмцдэг тогтолцоог үндсээр нь өөрчилж, гэмт хэргийн араас биш өмнөөс явдаг, илрүүлэхээр хөөцөлддөг биш урьдчилан сэргийлдэг, тэдний үйлдлийг бүртгэдэг биш урьдаас мэддэг, нотлох баримттайгаар таслан зогсоодог үндэсний хэмжээний цогц стратеги боловсруулах нэн тэргүүний шаардлага бий болоод байна.



Тийм ч учраас эрх зүйн шинэчлэл хийж байгаа нь чухал биш хийсэн шинэчлэл нь үр дүнгээ өгөх нь чухал шаардлага юм. Ялангуяа гэмт хэрэгтэй гардан тэмцдэг, хууль сахиулах, яллах чиг үүрэгтэй прокурор, гэм буруутай эсэсхийг нь нотлох баримтаар тогтоодог шүүхийн байгууллагуудын шинэчлэлийн уялдаа холбоо, алсын хараатай явуулах чухал бөгөөд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцдэг үндэсний стратегийг боловсруулж, төрийн цогц бодлогын доор явуулах нь миний ард түмний амар амгалан амьдрах амьдралын эх сурвалж болно буй заа хэмээн судлаач миний бие эргэлзэлгүй итгэж байна.

Санал

- Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэж байгаа дэлхийн улс орнуудын тэргүүн туршлагыг судлан, олон улсын хамтын ажиллагаанд түшиглэн, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэмтэн мэргэдийн туслалцааг авч, хууль сахиулах, прокурор, шүүхийн байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцдэг үндэсний стратеги бүхий төрийн цогц бодлого боловсруулах.

- Монгол Улсын нэгдэн орсон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн Эрх зүйн орчны шинэчлэл, эрүүгийн болон бусад хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр баталгаажуулах, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа дэлхийн хөгжингүй улс орнуудын туршлагыг судлах, хамтын ажиллагааг уялдуулан, харилцан ашигтайгаар ажиллах.

- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах, мэдээллийн нэгдсэн бааз, сүлжээг бий болгож энэ талаар эрх зүйн орчныг бүрэлдүүлэх.

- Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага "Интерпол"-ын 24/7 сүлжээг ашиглан мэдээлэл авч, сэжигтэй этгээдийн гадаад төрх байдлаар нь адилтгал хийдэг "Face finder" программ хангамжийг нэвтрүүлэх.

- Шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилтад тулгууралсан дэвшилтэт

технологууд бүтээгдсэн, өндөр мэдрэмж бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ашиглах. Нотлох баримт цуглуулах ажиллагааны явцад нийгмийн төрөл бүрийн салбарт ашиглагдаж байгаа лобартори, багаж тоног төхөөрөмжийг ашиглах боломж нөхцлийг бүрдүүлэх.

- Хууль сахиулах байгууллагын бүтцэд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх дагнасан албыг байгуулж, дадлага туршлагатай мэргэшсэн алба хаагчаар нөхөн хангах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар үр дүнтэй ажиллаж байгаа гадаад улсын эрх зүйн хэм хэмжээ, практикийг судлуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх зорилгоор суралцуулах зэрэг болно.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ц.Батболд

Улаанбаатар хот дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч, Хууль сахиулахын их сургуулийн магистрант

Өнөөгийн байдлаар Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хүрэлцээтэй нөхцөл бүрэлдэн тогтож чадаагүй. Тухайлбал эдийн засгийн бие даасан байдал, Монгол хүний амгалан амьдралыг цогцлох, экологийн тэнцвэртэй нөхцөлийг бүрдүүлэх замаар тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь үндэсний аюулгүй байдлын гол тулгуур, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангах суурь нь хэмээн үзсэн.

Монгол Улсын эдийн засаг хэт өрөөсгөл, эмзэг бүтэц хадаглагдсан хэвээр байна. Эдийн засгийн бүтцийг авч үзвэл газрын тос, хүнс, өргөн хэрэглээний бараа импортоос хамааралтай, уул уурхайн түүхий эд голлосон экспортой, байгалийн баялаг, тэдгээр нөөцөд тавих хяналт алдагдсан, үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөөц доройтсон, үнийн өсөлтөд өртөмтгий, гадаад худалдаа хөрш хоёр улсаас хамааралтай, гуравдагч хөрштэй чөлөөтэй худалдаа хийх боломжгүй, түгжигдмэл хэвээр байна.


Ийнхүү Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох, дэд бүтцийн салбарын хөгжлийг түргэтгэх, гадаад худалдаа, интеграцид нэгдэхэд үндэсний эрх ашгийг чухалчлан үзэх нь тэргүүний ач холбогдолтой юм.

1. ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН ТУЛГУУРТ БҮТЭЦ БҮРЭЛДЭЭГҮЙ, ЦӨН ХЭДЭН САЛБАРААС ХАМААРЛАЙТ ӨРӨӨСГӨЛ БҮТЭЦТЭЙ ХЭВЭЭ

Эдийн засгийн олон тулгуурт бүтэц (economic diversification) нь ихэнхдээ эдийн засгийн гарц буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төрөл өсөхийг ойлгодог. Мөн түүнчлэн экспортын баримжаатай улсад орлогын эх үүсвэрийн олон төрөл байдлыг ойлгох нь бий. Байгалийн баялаг арвин, хөгжиж буй улс орнуудын хувьд эдийн засгийн тогтвортой байдлыг хангахдаа олон тулгуурт бүтцийг бий болгохыг чухалчлах болсон. Учир нь нэгдүгээрт, байгалийн баялгийн экспорт давамгайлснаар эдийн засаг нь тухайн бүтээгдэхүүний үнийн

хэлбэлзлээс хамааралтай болж, эдийн засгийн бусад секторын үр ашгийг бууруулдаг. Хоёрдугаарт, олборлох салбар нь хөрөнгө оруулалт их зарцуулдаг, ДНБ-ийг хурдтай өсгөдөг хэдий ч ажиллах хүч харьцангуй бага оролцдог тул хүн амын амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл төдий чинээ бага гэж тооцогддог байна.^[66]


Экспортод эрдэст бүтээгдэхүүний эзлэх хувь



Эх сурвалж: YCX.www.1212.mn.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн бүтээгдэхүүн давамгайлж, чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргаж байна. Мөн дээрх экспортын бүтээгдэхүүний гол зах зээл дан ганц БНХАУ гэдгийг тооцвол эдүгээг хүртэл Монголын эдийн засаг олон тулгуурт болоогүй байгаа нь харагдана. Ийнхүү өрөөсгөл бүтэцтэй байгаагаас шалтгаалан гадаад зах зээлээс их хараат, эмзэг байдалтай болсон.

БНХАУ-д экспортолсон барааны 80 хувь эрдэст бүтээгдэхүүн эзэлдээг.



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын мэдээ Иймд Монгол Улсын хувьд, эдийн засгаа олон тулгуурт болгохын тулд хийх ёстой хамгийн чухал алхам бол дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй.

⁶⁶ Дэлхийн банк "Economic Diversification and Nonextractive Growth" http://ieg.worldbank.org/Data/reports/chapters/ccpe-synthesis_ch4.pdf



2. Дэд бүтцийн салбарын сул хөгжил эдийн засгийн үр ашгийг бууруулж зах зээл тэлэх боломжид сөргөөр нөлөөлж байна

Дэд бүтцийн салбар улс орнуудын хөгжлийн үндсэн суурь нь болж өгдөг бөгөөд дэлхийн өрсөлдөх чадварын тайланд улс орнуудын өрсөлдөх чадварыг 4 үндсэн хэсгээр хэмждэгийн нэг нь дэд бүтэц билээ. Монгол Улс энэхүү тайланд хамрагдсан 144 орноос 112-р байр эзэлжээ. Үүнд тээврийн дэд бүтцийн үзүүлэлтээр 126 дугаарт жагссан нь манай улсын дэд бүтцээ хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа зорилт, арга хэмжээний үр дүн ахицтай нэмэгдэж чадахгүйн илэрхийлэл юм^[67].

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, уул уурхайн түүхий эдэд суурилсан эдийн засагтай манай орны хувьд тээврийн зардал нь экспортын зардлын 18 хувь, импортын 11 хувийг тус тус бүрдүүлдэг тул эдийн засгийн үр ашгийг бууруулдаг. Иймд гадаад худалдааны нөхцөлөө сайжруулах, тэвэр ложистикийг оновчтой хөгжүүлэх, транзит тээврийн хэлэлцээр хийх зэрэг хүчин чармайлт гаргаснаар гадаад худалдаанаас олох үр ашгийг нэмэгдүүлэхийг зорьдог.

ДНБ дэх ложистикийн зардлын хувь хэмжээ нь өндөр хөгжилтэй орнуудын хувьд 8-9.5% байна. Манай орны хувьд тээврийн зардал нь экспортын зардлын 18 хувь, импортын 11 хувийг тус тус бүрдүүлж байгаа тул эдийн засгийн үр ашгийг бууруулах гол нөхөл болдог. Ийнхүү ложистикийн зардал өндөр тул эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын дэд бүтэц, ялангуяа гадаад худалдаа, транзит тээврийн дэд бүтцийг сайжруулах шаардлагатай байна.

Монгол улсын тарнзит тээврийн гурван коридор төлөвлөгдөөд байна.


3. Засгийн газрын гадаад болон дотоод өр төсөвт дарамт учруулж эдийн засгийг хямрааж төр засагт итгэх итгэл буурсаар

Эдүгээ гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөтэйгөөр төсвийн орлого татарч, гаднаас авсан өр төлбөрөө төлж хүчрэхгүй, дотоодын эдийн засгийн тогтвортой өсөлтөө хангаж чадахгүй болсон нь Монгол Улсын эдийн засагт ойрын хугацаанд тулгамдаж буй томоохон сорилт юм.



Гадаад хүчин зүйлс: Зээл, санхүүгийн зах зээлд үүсээд буй өнөөгийн нөхцөл байдалд гадаад хүчин зүйлс ихээхэн нөлөөлсөн. Тухайлбал гадаадын шууд хөрөнгө оруулалт жил тутам буурч дотогшоо чиглэсэн валютын урсгал ихээхэн хэмжээгээр хумигдсан. Олон улсын зах зээл дээр эрдэст

бүтээгдэхүүний үнийн тогтворгүй байдал. Үүнд манай улсын гол экспортын бүтээгдэхүүний үнэ (нүүрс, зэс, газрын тос) унасан зэрэг шалтгаан юм.



⁶⁷ Олон улсын өрсөлдөх чадварын тайлан (Global Competitiveness Report)-ийн дэд бүтэц хэмээх хоёрдугаар багц хувьсагчийн үнэлгээгээр манай улс 2007-2008 онд нийт 133 орноос 126-д, 2008-2009 онд 133-т, 2009-2010 онд 133-т 2014-2015 онд 119-д тус тус орж байсан.



Дотоод хүчин зүйлс: Түүхий эдийн үнийн өсөлттэй үед нөөц бүрдүүлэх, эдийн засгаа төрөлжүүлэхэд анхаарч, бууралттай үед нөөцөө хэрэглэх зэргээр мөчлөг сөрсөн бодлого явуулах шаардлагатай байдаг ч хэт мөчлөгөө дагаж, уул уурхайгаас орж ирсэн баялгаа хяналтгүй үрсэн. Мөн төрийн бодлогын залгамж чанар хадгалагддаггүй, нэг төсөл хөтөлбөрийг дараагийн Засгийн газар өөрчлөх, гацаах зэргээр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдсан явдал удаа дараа гаргаж байсны дээр дотоодын популизм ч үүнд багагүй нөлөөлсөн.



4. Дан ганц уул уурхайн салбарын хөгжлөөс Монгол Улсын эдийн засгийн хамаарал нэмэгдсээр

Монгол Улсын эдийн засаг гадаад өр, төсвийн алдагдал, ДНБ-ий өсөлтийн удаашрал, төгрөгийн ханшийн уналт зэрэг томоохон сорилтуудтай тулгарч буй өнөөгийн нөхцөлд экспортын орлогыг голлон бүрдүүлэгч уул уурхайн үйлдвэрлэлийн үр ашгийг өсгөж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь чухал юм. Уул уурхайн үйлдвэрлэл 2016 оны жилийн эцсийн байдлаар ДНБ-ий 20 хувь, экспортын 86,3 хувийг эзэлж Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур салбар болж байна. Сүүлийн 7 жилийн хугацаанд буюу 2010-2016 онд уул уурхайн салбарын үйлдвэрлэл болон ДНБ-ий хоорондын корреляцын хамаарлын индекс 0.915 буюу маш хүчтэй хамааралтай байгаа нь үүнийг нотолно. Нийт мөнгөн дүнгээр Монгол Улсын эрдэс бүтээгдэхүүний экспортын 37 хувь буюу 1,9 тэрбум ам.долларыг нүүрс, 31 хувь буюу 1.6 тэрбум ам.долларыг зэс, 14,5 хувь буюу 758 сая ам.долларыг алтны экспорт эзэлжээ.

Нөгөө талаар уул уурхайн салбарын хөгжилд хувийн хэвшлийн санаачилга, оролцоо нэмэгдсэн нь дараах жишээнээс харагдаж байна.


Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн Төмрийн хүдрийн соронзон баяжуулах үйлдвэр, Ган бөмбөлгийн үйлдвэр, Ухаа худагийн нүүрс баяжуулах үйлдвэр, Эрдэнэтийн УБҮ-ийг түшиглэн Катодын зэсийн үйлдвэр, Сүхбаатар аймагт Цайрын уулын баяжуулах үйлдвэр байгуулагдсан зэрэг жишээ нь нэмүү өртөг шингэсэн уул уурхайн үйлдвэрлэлд томоохон хувь нэмэр оруулж, орон нутагт хэдэн мянган ажлын байрыг шинээр бий болгосон. Харин Засгийн газрын үүрэг, оролцоогоор байгуулагдах ёстой Тавантолгойн цахилгаан станц, Оюутолгойг цахилгаанаар хангах, төмөр зам, авто зам, усан хангамжийн байгууламж, газрын тос боловсруулах үйлдвэр, Оюутолгойг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрснээс нийлэг байгалийн хий гарган авах үйлдвэр зэрэг мега төслүүд хэрэгжээгүй болон удаашралтай байгаа нь гол салбарыг тэргүүлэх хэмжээнд авч



дэмжиж чадахгүй байна.

Монгол Улсын төсвийн нийт орлого, алтны дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарал багатай нь корреляцийн шинжилгээгээр харагдлаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, нэг унц алтны зах зээлийн үнийн өсөлт




Алт, нүүрс зэрэг бусад металлын өсөлтийн хувьтай харьцуулахад Монгол Улсын төсвийн нийт орлого, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс ихээхэн хамааралтай нь корреляцийн шинжилгээгээр харагдлаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, нэг тонн зэсийн зах зээлийн үнийн өсөлт



Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ 2005, 2007, 2009, 2012 онуудад буюу хоёр жилийн давтамжтайгаар буурсан нь сонирхол татаж байна. Олон жилийн дундажаар 2004, 2006, 2010 онуудад зэсийн үнэ өссөн. 2010-2016 онд дунджаар 47 хувиар өссөн үнийн өсөлт цаашид ч өсөх хандлагатай.



Төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн үнэ 2003-2005 онд дунджаар 36.6 хувиар өссөн ч 2006 онд өмнөх оноос ердөө дөрвөн хувиар өсч, 2007 онд 2006 оноос 76 хувиар огцом өссөн нь үнийн хэлбэлзэл өндөр байгааг харуулж байна. 2009, 2013 оны бууралтай байгаа бөгөөд 2016 онд өсөж 2017 онд үнэ тогтвортой байх хандлага ажиглагдаж байна.



1997, 2004, 2008 оны нүүрсний дэлхийн зах зээлийн үнийн өсөлт Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын өсөлттэй давхцаж байна. 2005, 2006 оны үнийн огцом бууралтын үед нэгдсэн төсвийн орлого өндөр өсөлттэй байгаа нь зэс, алт зэрэг бусад металлын дэлхийн зах зээлийн үнийн өсөлттэй холбоотой. Олон жилийн дунджаар 2002, 2005, 2010 онуудад нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ буурснаас дүгнэхэд 2012 оноос эхэлсэн үнийн огцом бууралт зогсож 2015-2016 онд буурхаар байна.

Дүгнэлт, санал:

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдлыг ерөнхийд нь дүгнэвэл дараах байдалтай байна.

- Макро эдийн засгийн үндсэн тэнцлүүд

алдагдалтай хэвээр байгаа бөгөөд энэ нь цааш үргэлжлэх хандлагатай байна. Эдийн засагт бүтцийн шинэчлэлийг хийж чадаагүй зөвхөн уул уурхайн цөөн төрлийн бүтээгдэхүүний үнийн хамааралтай экспорт хэвээр байгаа тул бүтээмж нэмэгдэх боломжгүй, гадаад худалдаа агшсан, төлбөрийн тэнцэл алдагдалтай, валютын нөөц хомсдож улам даамжрах төлөвтэй. Эдийн засгийн зорилтот хөтөлбөрүүд өнөөг хүртэл зогсонг байгаа нь асуудал, бэрхшээлүүд хуримтлагдаж өнөөгийн хямралд хүргэх нэг үндэс болжээ.

- Төсвийн сахилга, төсвийн менежмент сул, эдийн засгийн бодлогыг хэт улс төрийн баримжаатай байгаа нь төсөв данхайх, хөрөнгө оруулалтын үр өгөөж муутай байх



шалтгаан болж байна. Мөнгөний ханшийн уналт, инфляци үүн дээр нэрмээс болж байна.

- Засгийн газрын өрийн хэмжээ огцом өсч цаашид энэ өрийн дарамт ихсэх төлөвтэй байна. Тооцоо судалгаагүй улс төрийн амлалтууд засгийн газрын өр нэмэгдэх үндсэн шалтгаан болж санхүүгийн хүндрэлийг бий болгожээ.

- Гадаадын хөрөнгө оруулалтаас орж ирэх орлогоос төсвийг хэт хамааралтайгаар төлөвлөж байгаа нь ч эрсдлийг өсгөх нэг гол хүчин болж байна.

Ийм учраас өнөөгийн үүсээд буй хүндрэлийг гэтлэж эдийн засгийг тогтворжуулахад дараах зөвлөмжийг санал болгож байна.

- Төсвийн төлөвлөлтийг хянах хөндлөнгийн, хараат бус механизм дутмагаас салбарын эрх ашиг, байгууллагын эрх ашигт хөтлөгдсөн, урсгалаар нь төлөвлөх хандлага зонхилж, зардлын өсөлт нь орлогын өсөлтөөс илүүгээр өсч байна.

- Төсвийн гүйцэтгэлийг хянаж, сайжруулах, үр ашгийн мониторинг хийх механизм үгүйлэгдэж байна.

- Гаднаас авсан зээлийн ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулах шаардлагатай байна. Засгийн газрын авсан зээлийн зарцуулалт, ашиглалтад хатуу хяналт тогтоож, шаардлагатай бол тухай бүрт нь хариуцлага тооцох, нэн даруй арга хэмжээ авдаг байх шаардлагатай.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР, ТӨРӨЛ

Г.Гантөмөр

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэмтэн
нарийн бичгийн дарга,
доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа

Оршил

Сүүлийн жилүүдэд сонин хэвлэл болон цахим орчинд УИХ-ын гишүүд болон төрийн бусад өндөр албан тушаалтнууд гэмт хэрэг үйлдсэн гэх мэдээлэл цөөнгүй гарч байгаа хэдий ч тэднийг эрүүгийн хариуцлагад татсан, хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байхгүй, үүнтэй холбоотойгоор иргэд хууль дээдлэх ёс, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдсан, хууль алагчлан үйлчилдэг, ял завшиж байгаа талаар иргэд ярьж бичих болсон, нийгмийн бухимдал үүсч, нийгмийн сэтгэл зүйд таагүй нөлөө үзүүлж байгаа билээ. Энэ нь ч нийгмийн шударга ёстой холбоотой гарч буй зүй ёсны үйлдэл мөн.

Үнэхээр төрийн өндөр албан тушаалтнуудын үйлдсэн зарим хэргүүд улс төрийн болон бусад шалтгаанаар замхрах, шалгаж шийдвэрлэхгүй байх, хэрэгсэхгүй болгож байгаа нь нийгэмд байгаа бодитой зүйл, нийгмийн анхаарал татсан асуудал болоод байгаа ба үүнд зарим талаар нөлөөлж байгаа хууль зүйн хүчин зүйл байдаг, хууль зүйн учир шалтгаантай гэдгийг тэр бүр мэддэггүй.

Энэ нь бидний судалж буй ЭЭЗүй дэх халдашгүй байдлын асуудалтай холбогдоно. ЭЭЗүйд гэмт хэрэг үйлдсэн төрийн өндөр албан тушаалтнууд Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид заасны дагуу халдашгүй дархан эрх эдэлдэг, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульд заасан онцгой журам /процедур/-ын дагуу шийдвэрлэдэг нь тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг зарим талаар хүндрүүлдэг, энэ шалтгаанаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, ял зэмгүй өнгөрөх боломжтой байдаг.

Гэтэл манай улсад ЭЭЗүйн чиглэлээр гарсан бүтээлүүдэд энэ талаар нарийвчлан судлаагүй, уг асуудлыг зөвхөн дипломат

халдашгүй эрхийн тухай ойлголтоор хязгаарлан, эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээдийн тухай авч үзэхдээ өнгөц хөндсөн нь судлаач миний биеийг энэ асуудлыг тусгайлан судлахад хүргэлээ.

Энэ нь ЭЭЗүй дэх халдашгүй байдлын ойлголтыг энгийн буюу хууль хэрэглээний ба онолын сэтгэлгээний түвшинд нарийвчлан судлах, нийгэмд үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэх, түүнд хандах нийгмийн хандлага, сэтгэл зүй, иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсарт эерэг нөлөө үзүүлэх зорилготой.

Үндсэн хэсэг

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын тухай ойлголт, мөн чанар

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын тухай асуудлыг авч үзэхийн өмнө хэл зүйн үүднээс уг нэр томъёог тайлбарлах нь зүйтэй. Халдашгүй байдал /иммунитет/ нь "immunitas" гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд хөрвүүлбэл үг зүйн хувьд "халдашгүй, халдварлашгүй" гэсэн утгыг илэрхийлнэ^[68].

Эрх зүйд уг ойлголтыг "халдашгүй байдал" гэж тодорхойлдог ба Монгол улсын Үндсэн хуульд ч халдашгүй байдал гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг.

Хууль зүйн утгаар нь авч үзвэл "халдашгүй байдал" нь Академич С.Нарангэрэлийн тайлбарласнаар "...эрх зүйн хэм хэмжээний үйлчлэлээс тодорхой субъектыг чөлөөлөх..." гэсэн утгатай^[69]. Гадаадын эрх зүйн зарим толь бичигт "...Хувь хүн, бүлэг хүмүүсийг тэдний эрх зүйн тусгай статусаас хамааран эрх зүйн зүйн үр дагавараас, түүний дотор эрүүгийн хариуцлага, ял хүлээх үүргээс чөлөөлөх нөхцөл..." гэж тайлбарласан нь бий^[70].

ОХУ-ын Эрх зүйн тольд "...Эрх зүй нь хуульд заасан тодорхой нөхцөлд төр, олон улсын байгууллага, нийгэмд онцгой байр суурь эзэлдэг хувь хүмүүст үйлчлэхгүй байх боломжтой бөгөөд үүнийг иммунитет буюу халдашгүй байдал гэнэ..."^[71] хэмээн тодорхойлжээ.

⁶⁸ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ.2008. 214 дэх тал
⁶⁹ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Анхны хэвлэл. УБ.2007 он. 229 дэх тал

⁷⁰ Encyclopedia Americana. — Danbury. 1987. — Vol 14. — p 811, The New Encyclopedia Britanica. — Chigago. 1989. — Vol 6. p 269

⁷¹ Л.В.Тихомиров, М.Ю.Тихомиров. Юридическая энциклопедия. М.1997 г. стр 177



Халдашгүй байдлын ойлголтыг эрх зүйн ерөнхий онолд тодорхойлоогүй боловч үндэсний болон олон улсын эрх зүйн цөөнгүй салбарт уг ойлголтыг авч үзэж судалдаг. Тухайлбал: Олон улсын эрх зүйд дипломат ажилтны болон олон улсын байгууллагын халдашгүй байдлын тухай, Үндсэн хуулийн эрх зүйд төрийн тэргүүний, УИХ-ын гишүүний /депутатын/, Үндсэн хуулийн Цэцийн гишүүний болон шүүгчийн халдашгүй байдлын тухай ойлголтыг тодорхойлдог.

Материаллаг эрх зүй болох ЭЭЗүйд саяхныг болтол халдашгүй байдлын тухай тусгайлан авч үздэггүй, зөвхөн дээр дурьдсанчлан эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээдийн тухай асуудлын хүрээнд дипломат халдашгүй байдлын тухай ойлголтыг л судалдаг байв.^[72]

Монгол улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн, тус улсын шүүхэд эрүүгийн хэргийн харьяалалгүй, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмын дагуу дипломат халдашгүй дархан эрх, ямба эдэлдэг хүмүүсийн үйлдсэн хэрэгт эрүүгийн хууль хамаарч үйлчлэхгүй, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэх тухай зохицуулалт өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд байсан, 2015 оны шинэчилэн найруулсан, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуульд ч байна.

Процессын эрх зүйд ч уг асуудал нарийн зохицуулалтгүй явж ирсэн, ийм байдал ч шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд ч хадгалагдан үлдсэнд шүүмжлэлтэй хандах ёстой. Харин УИХ-ын тухай, Ерөнхийлөгчийн тухай, Үндсэн хуулийн Цэцийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хууль тогтоомжуудад зарим нэг зохицуулалт байдаг ч төдийлөн тодорхой, төгөлдөр бус.

Сүүлийн жилүүдэд ОХУ-ын ЭЭЗүйд уг асуудалд анхаарал хандуулан, түүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болгон авч үзэх хандлага бий болоод байна. Тухайлбал: ОХУ-ын нэрт эрдэмтэн А.В.Наумов ЭЭЗүй дэх халдашгүй байдлыг "...эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг журмаас ангид, уг журам үйлчлэхгүй

байх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх нөхцөл."^[73] гэж үзсэн бол профессор И.И.Лукашук "...эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөл юм..."^[74] гэж тодорхойлжээ. Харин уг асуудлыг тусгайлан судалсан ОХУ-ын доктор А.Г.Кибальник "...халдашгүй байдал эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг журам үйлчлэхгүй тодорхой эрх зүйн байдал бүхий хүмүүст хамаарах, хуульд тусгайлан заасан онцгой нөхцөл, журам юм..."^[75] гэж үзсэн ба үүнтэй санал нийлж болохоор байна. Учир нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх бүрэн үндэслэлтэй тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Эрүүгийн хуульд заасан эрүүгийн эрх зүйн үр дагавараас /эрүүгийн хариуцлага/ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шатанд эрх бүхий байгууллагын шийдвэрээр чөлөөлөх үйл ажиллагаа байдаг бол халдашгүй байдал нь эрүүгийн хууль хамаарч үйлчлэхгүй, эрүүгийн хариуцлага огт хүлээлгэж болохгүй буюу тусгай журмаар /процедураар/ хүлээлгэх Эрүүгийн хууль болон бусад хуульд заасан онцгой нөхцөл байдал юм.

Халдашгүй байдлын асуудал эрх зүйн олон салбарын судлагдхуун болдог. ЭЭЗүй дэх халдашгүй байдлын ойлголт, төрөл, нөхцөл, журам нь бусад эрх зүй дэх ойлголтоос ялгагдана. Үүнийг ЭЭЗүйн мөн чанар, зорилго, түүний зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай холбон тайлбарлах ёстой.

Олон улсын эрх зүйд олон улсын гэрээ, конвенцийн дагуу тусгаар тогтносон улс орны халдашгүй байдал, олон улсын байгууллагын, далайн болон агаарын хөлгийн халдашгүй байдал, олон улсын хамгаалалтанд байдаг, дипломат халдашгүй дархан эрх ямба эдэлдэг хүмүүс /төрийн тэргүүн, дипломат корпусын ажилтнууд/-ийн халдашгүй байдал зэрэг түүний олон төрлийг тодорхойлон, түүнийг хангах олон улсын механизм, арга замыг тодорхойлдог нь уг ойлголтын ЭЭЗүйн агуулгаас өргөн хүрээтэй, зарим талаар түүнийг судлах суурь нь болно.

Харин олон улсын нийтийн эрх зүйн нэг салбар болох Олон улсын ЭЭЗүйд

⁷³ А.В.Наумов. Имунитеты в уголовном праве // ж. Уголовное право. 1998. № 2. стр 23

⁷⁴ И.И.Лукашук. Имунитеты в отношении уголовной юрисдикции // ж. Российская юстиция. 1998. № 4. стр 21

⁷⁵ А.Г.Кибальник. Имунитеты в уголовном праве. Ставрополь. 1999. стр 8

⁷² Шинжлэх ухааны доктор С.Жанцан уг асуудлыг илүү дэлгэрэнгүй судалсан байна. С.Жанцан Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол. Тэргүүн боть. Гэмт хэргийн сургааль УБ.2009 он. 160-163 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү



хүн төрөлхтний энх тайван, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, цэргийн болон түрэмгийллийн гэмт хэрэг үйлдсэн бол Олон улсын эрүүгийн шүүхэд төрийн тэргүүний болон депутатын халдашгүй байдал үйлчилдэггүй онцлогтой. Энэ тухай Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн /статутын/ 27-р зүйлд заасан байдаг^[76].

Үндсэн хуулийн эрх зүйд халдашгүй эрх эдэлдэг хүмүүс болох төрийн тэргүүн, депутат, шүүгч болон бусад төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын эрх зүйн үндсийг хуульчилдаг ба бусад хууль тогтоомж, түүний дотор УИХ-ын тухай, Үндсэн хуулийн цэцийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудад цаашдын хөгжлийг олж, эрх зүйн зохицуулалт нь илүү нарийвчлан хуульчигалдсан байна.

Дээрх эрх зүйн зохицуулалт нь ЭЭЗүйд төдийгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд халдашгүй эрх эдэлдэг хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, эсвэл тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэхэд эрх зүйн үндэс, баримтлах зарчим, журам нь болдгоороо ач холбогдолтой юм.

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын, түүний дотор төрийн тэргүүний халдашгүй байдлын асуудал нь эртний уламжлалтай. Эртний болон дундад зууны үед төрийн эрх мэдэл нэг хүний гарт төвлөрсөн, хэмжээгүй эрхт хаант засаглалтай байсан үед төрийн тэргүүн хаан, ван, гүнгүүд, төрийн дээд албан тушаалтнууд ямар ч гэмт хэрэг, зөрчил гаргасан эрүүгийн хариуцлага хүлээдэггүй байсан, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь хааны хүсэл зоригоос хамаарч байсныг бид түүхээс мэднэ.

Манай улсын түүхэнд халдашгүй байдлын ойлголт байсан, түүнийг хувь хүнд тусгайлан олгож байсныг *"Монголын нууц товчоо"*-ноос харж болно. Тухайлбал: эсгий туургатныг нэгтгэн энхжүүлж, Их Монгол улсыг түвшитгэн 2006 оны барс жил Онон мөрний хөвөөнд Чингис хаан цол өргөмжлөгдөхдөө Тэмүүжин төр улсыг байгуулалцсан гавъяатнуудыг хөхүүлэн ван, түмт, мянганы ноёдыг тохоон томилсны дотор Боорчи, Мухулай, Наяа, Хорчи, Зэлмэ, Зэв, Сүбээдэй, Борохул, Сорхон Шарыг "ёсөн удаа эндэхүй дор эрүүд бүү оруултугай" хэмээн дархалжээ.^[77]

76 Олон улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм. УБ хот. 2002 он. 32 дахь тал
77 Монголын Нууц Товчоо. Сонгомол эх. Монсудар хэвлэлийн газар. УБ. 2009 он. 137,140, 141,

ЭЭЗүйд халдашгүй байдалтай холбоотойгоор зайлшгүй авч үзэх асуудал нь түүний ЭЭЗүйн зарчимтай хэрхэн холбогдох тухай юм. Уг асуудал нь юуны өмнө ЭЭЗүйн шударга ёсны зарчим, түүний илрэл болсон хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх асуудалтай холбоотой.

Шинэ Эрүүгийн хуулийн 1.3-р зүйлийн 2 дахь хэсэгт "...гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй..." гэж заасан байна.

Үүнтэй холбогдон төрийн тодорхой өндөр албан тушаалтнууд халдашгүй байдал гэсэн хамгаалалтын доор эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх нь шударга ёсны зарчимд нийцэх үү? хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчим нь абсалют буюу үнэмлэхүй утгаар хэрэгжих үү? гэсэн асуудал зүй ёсоор гарна.

Халдашгүй байдлыг төрийн өндөр албан тушаалтны, тухайлбал: төрийн тэргүүн, УИХ-ын гишүүн, Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, бүх шатны шүүгчийн бүрэнэрхийг хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа болох үүднээс Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасан нь тэдгээр албан тушаалтны бүрэн эрхэнд халдах, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс дураар оролцох, саад учруулах, зохих зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар эрүүгийн болон захиргааны журмаар баривчлах, саатуулах, мөрдөн мөшгихөөс урьдчилан сэргийлэх зорилготой.

Иймээс ЭЭЗүй дэх халдашгүй байдлын тухай асуудал нь Үндсэн хуулийн болон Эрүүгийн хуулийн дээрх зарчимтай зөрчилдөхгүй, "...хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй..." гэсэн харьцангуй утгаар ойлгох нь зүйтэй.

Доктор Б.Чимид агсан ийнхүү халдашгүй байдлыг хуульчилах замаар дархлаа тогтоож байгаа нь хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хөсөрдүүлж байгаа хэрэг огтхон ч биш гэжээ.^[78]

Мөн нөгөө талаар халдашгүй эрх эдэлдэг албан тушаалтны бүрэн эрхийг хуульд заасан журмаар түдгэлзүүлж, халдашгүй байдал, эрх ямбыг эвдэж жирийн иргэдтэй

147,151, 152, 154 дахь тал

78 Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ.2008. 215 дахь тал



адил нийтлэг журмаар хэргийг шалгаж байгаа нь хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй гэсэн Үндсэн хуулийн үзэл санаа, зарчмыг хэрэгжүүлж байгаагийн нэг баталгаа гэж судлаачийн хувьд үзэж байна.

Түүнчлэн ЭЭЗүй дэх халдашгүй байдлыг төрийн өндөр албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд огт эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэж ойлгож болохгүй. Хуульд заасан үндэслэлээр тэдгээрийн халдашгүй эрхийг нь түдгэлзүүлсэн, эрхээ хасуулсан, эсвэл халдашгүй эрх эдлэх хуульд заасан хугацаа өнгөрсөн бөгөөд хэрэв хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол тэдэнд нийтлэг журмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой, тийм зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид хийсэн байдаг.

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын мөн чанар, агуулга нь дараах байдлаар илэрнэ. Энэ нь:

1-рт: олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, гэрээ, конвенци, үндэсний хууль тогтоомжид заасан халдашгүй эрх эдэлдэг хүмүүсийг гэмт халдлагаас хамгаалах,

2-рт: уг этгээдүүд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эсвэл хүлээлгэхгүй байх тусгай нөхцөл, журмыг хуульчлах явдал болно.

ЭЭЗүй нь хамгаалах чиг үүрэгтэй эрх зүйн хувьд дипломат халдашгүй дархан эрх ямба эдэлдэг хүмүүс, олон улсын байгууллага, үндэсний хууль тогтоомжоор халдашгүй эрх эдэлдэг төрийн тэргүүн, УИХ-ын гишүүн, шүүгч болон бусад төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалж, тэдний амь нас, эрүүл мэнд, халдашгүй эрхэд халдсан үйлдлийг гэмт хэрэгт тооцон, хүлээлгэх эрүүгийн хариуцлага, ялын төрөл, хэмжээг тогтоожээ. Тухайлбал: 2015 оны Эрүүгийн хуулийн 19.3-р зүйлд төрийн өндөр албан тушаалтны амьд биед халдаж эрүүл мэндэд нь санаатай хүнд гэмтэл учруулах, амь насыг хохироох гэмт хэргийг, 21.6-р зүйлд шүүгчийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлэх, эсхүл ятгах замаар **хууль бусаар нөлөөлөх гэмт хэргийг, 29.7-р зүйлд** дайн өдөөх, улс хоорондын харилцааг хурцатгах зорилгоор гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын ажилтан, дипломат элч, гадаад улсаас Монгол Улсад албан

ёсны, ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл, Монгол Улсад өөрийн улсын төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий хүн, олон улсын байгууллагын ажилтан, тэдний албан өрөө, орон байр, тээврийн хэрэгсэлд халдах үйлдлийг хуульчилсан нь үүний баталгаа юм.

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын хоёрдахь агуулга болох халдашгүй эрх бүхий этгээдүүд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тусгай нөхцөл, журмыг хуульчлах асуудал нь одоо үйлчилж буй Эрүүгийн хуульд шаардлагатай хэмжээнд хуульчилагдаж чадаагүй, дээр өгүүлсэнчлэн эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээдийн асуудлын хүрээнд дипломат халдашгүй дархан эрх эдэлдэг хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай нийтлэг хэм хэмжээнээс хэтрэхгүй байна.

Харин процессын эрх зүй болох ЭБШЭЗүйд дипломат болон халдашгүй эрх эдэлдэг бусад хүмүүсийн үйлдсэн хэргийг шалган шийдвэрлэх, тухайлбал: мөрдөн шалгах ажиллагааг хэрхэн явуулах, нотлох баримтыг хэрхэн цуглуулах, шүүхээр хэлэлцэн шийдвэрлэх зэрэг процессын үйл ажиллагааны журмыг тусгайлан хуульчилсан байх ёстой, үүгээр ЭЭЗүй ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уялдаа холбоо илрэх ёстой.

Гэтэл зөвхөн дипломат халдашгүй эрх эдэлдэг хүмүүсийн үйлдсэн хэргийн тухайд 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2-р зүйлийн 5-д "... Гадаад улсын, олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнийг яллагдагчар татаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Улсын ерөнхий прокурор Монгол Улсын гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улс, олон улсын байгууллагаас хүснэ..." гэж зааснаас өөр зохицуулалт алга байна.

Мөн уг хуульд халдашгүй эрх эдэлдэг бусад хүмүүсийн /төрийн тэргүүн, УИХ-ын гишүүн, Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, шүүгчийн/ үйлдсэн хэргийг мөрдөн шалгах, шүүхээр шийдвэрлэх тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй. Иймээс дипломат ажилтнууд болон халдашгүй эрх эдэлдэг бусад хүмүүсийн үйлдсэн хэргийг мөрдөн

шалгах ажиллагааг тусгай ажиллагааны журмаар шийдвэрлэх асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчлан хуульчлах шаардлагатай.

Дээрхээс үндэслэн ЭЭЗүй дэх халдашгүй байдлыг гэдэг нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмын дагуу болон үндэсний хууль тогтоомжид зааснаар халдашгүй дархан эрх ямба эдэлдэг дипломат ажилтнууд, төрийн өндөр албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хамаарах эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг журам үйлчлэхгүй байх, тусгай журмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн онцгой байдлыг хэлнэ гэж судлаачийн зувьд томъёолж байна.

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын ангилал, төрөл

ЭЭЗүй дэх халдашгүй байдлын зайлшгүй авч үзэх зүйл бол түүний ангилал, төрлийг тодорхойлох явдал мөн. Үүнээс түүний мөн чанар, хууль зүйн учир холбогдлыг илүү харж болно.

ЭЭЗүйн онолд халдашгүй байдлыг ийм эрхийг эдлэх субъект, болон халдашгүй байдлын үргэлжлэх хугацаа, үйлчлэх онцлогоос хамаарч дараахь төрлүүдэд ангилсан байдаг. Үүнд:

1. ЭЭЗүй дэх халдашгүй байдлын ангилах үндэслэл нь түүнийг эдлэх субъект бөгөөд субъектээр нь:

- а/. Дипломат ажилтнуудын халдашгүй эрх
- б/. Төрийн тэргүүний /Ерөнхийлөгчийн/ халдашгүй эрх
- в/. Депутатын /УИХ-ын гишүүний/ халдашгүй эрх
- г/. Шүүгчийн халдашгүй эрх
- д/. Бусад албан тушаалтны халдашгүй эрх гэж ангилна.

Дипломат ажилтны халдашгүй эрх:

Дипломат ажилтны халдашгүй эрх гэсэн нэгдсэн ойлголтоор томъёолсон хэдий ч хэд хэдэн халдашгүй байдлыг өөртөө багтаана. Үүнд: Дипломат /консулын/ ажилтны, олон улсын байгууллагын ажилтны, олон улсын хамгаалалтанд байдаг хүмүүсийн халдашгүй байдал хамаарна.

2015 оны Монгол улсын Эрүүгийн хуулийн 1.5-р зүйлийн 3 дахь хэсэгт "...гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээд болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу Монгол улсын шүүхэд Эрүүгийн хэргийн талаар харъяалагдахгүй бусад этгээд Монгол улсын нутагт дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл түүнд

эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Монгол улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ..." гэж заажээ.

Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлдэг хүмүүсийн эрх зүйн байдлыг "Дипломат хариуцлагын тухай" 1961 оны Венийн конвенц, түүнчлэн "Олон улсын хамгаалалтад байх хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шүүн цээрлүүлэх тухай" 1973 оны Конвенцийн заалтуудаар тодорхойлдог.

Халдашгүй эрх ямба эдэлдэг дипломат төлөөлөгчид гэдэгт гадаад улсын дипломат төлөөлөгчдийн тэргүүн /элчин сайд, итгэмжлэгдсэн төлөөлөгч, элчин сайдын үргийг түр хамаарагч/, консулын болон төлөөлөгчдийн газрын тэргүүн, ажилтнууд, элчин зөвлөхүүд, цэргийн болон эдийн засаг, соёлын атташе, худалдааны төлөөлөгч, тэдгээрийн туслах, элчин сайдын яамны нэг, хоёр, гуравдугаар нарийн бичгийн дарга нар, бичиг хэрэг-архивын эрхлэгч, түүнчлэн дээр дурдсан хүмүүстэй хамтын амьдралтай бөгөөд Монгол улсын иргэн бус гадаадын дипломат төлөөлөгчдийн тэргүүн, гишүүдийн гэр бүлийн гишүүд хамаарна.

Олон улсын хамгаалалтад байх хүмүүс гэдэгт өөр оронд төрийн болон албан ёсны айлчлал хийж байгаа эсвэл гадаад улсад болж байгаа олон улсын арга хэмжээнд оролцож буй гадаад улсын төрийн тэргүүн, хууль ёсоор түүний үүргийг гүйцэтгэж байгаа хүмүүс, ерөнхий сайд, гадаад хэргийн сайд, тэдгээрийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд, тусгай даалгавар бүхий дипломат элч, түүнчлэн олон улсын олон талт болон хоёр талын гэрээгээр дипломат халдашгүй эрх эдлүүлэхээр заасан төрийн байгууллагын албан тушаалтан, гадаад улсын төлөөлөгч нар, тэдгээрийн гэр бүлийн гишүүд нэгэн адил хамаарна.^[79]

Эдгээр дипломат халдашгүй эрхтэй хүмүүсийг өөрийнх нь болон төлөөлж буй улсын зөвшөөрөлгүйгээр гэмт хэрэгт холбогдуулан баривчлах, цагдан хорих, мөрдөн шалгах зэргээр байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй.

Төрийн тэргүүний халдашгүй эрх:

Төрийн тэргүүний халдашгүй эрх гэдэг нь Үндсэн хууль, бусад хуульд заасан төрийн тэргүүний үүргийг хуулийн дагуу хашиж байхдаа хуулийн хариуцлага хүлээхгүй

⁷⁹ Д.Мөнхтуяа. Олон улсын эрх зүйн зарим асуудал. УБ., 2000. 180-181 дэх тал



байх, тухайлбал эрүү, иргэний, захиргааны хэрэгт шалгагдахгүй байх, баривчлагдаж саатуулагдахгүй байх эрх юм^[80].

Төрийн тэргүүний халдашгүй эрхийг гадаадын зарим орнуудад харилцан адилгүй хуульчилсан байх ба тэдгээрийг судлан үзэхэд дараахь загвар, жишиг байна. Энэ нь:

1-рт: Дэлхийн ихэнх орнуудад төрийн тэргүүн гэмт хэргийн ангилал хамаарахгүйгээр гэмт хэрэг үйлдсэн бол уг албан тушаалыг хашиж байхдаа эрүүгийн хариуцлагад татагдахгүй, зөвхөн Үндсэн хуульд заасан онцгой журмаар Ерөнхийлөгчид үл итгэх буюу импичмент зарлаж бүрэн эрхийг нь Парламентаар түдгэлзүүлэх эсвэл албан тушаалаас нь огцруулсны дараа нийтлэг журмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим үйлчилдэг. Ийм жишигтэй орнуудад АНУ, Египет, Бразил, Венесуэла зэрэг орнуудыг нэрлэж болно.

2-рт: Зарим оронд Ерөнхийлөгч үйлдсэн эрүүгийн бүх гэмт хэргийн төлөө бус, зөвхөн зарим төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээдэг. Жишээ нь: Францын Үндсэн хуулийн 68-р зүйлд зааснаар Ерөнхийлөгчид зөвхөн төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол Парламентын шийдвэрээр бүрэн эрхийг /халдашгүй байдлыг/ нь түдгэлзүүлэн, тусгай шүүхэд шилжүүлж эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг^[81]. ОХУ-ын Үндсэн хуулийн 93-р зүйлд Ерөнхийлөгч эх орноосоо урвах, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд түүний үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэж үзсэн ОХУ-ын Дээд Шүүхийн дүгнэлт болон түүнийг Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх нь үндэслэлтэй гэж үзсэн Үндсэн хуулийн Шүүхийн дүгнэлтийг үндэслэн гаргасан Төрийн Думын Ерөнхийлөгчийг огцруулах тогтоолыг Холбооны Зөвлөл хэлэлцэн түүнийг албан тушаалаас нь огцруулах зохицуулалтыг хуульчилсан байна^[82]. Өөрөөр хэлбэл ОХУ-ын Ерөнхийлөгч хөнгөн, хүндэтгэр гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээхгүй, халдашгүй эрхтэй гэсэн үг юм.

3-рт: Цөөн улс оронд, тухайлбал: Чех улсын Үндсэн хуулийн 65-р зүйлд Ерөнхийлөгч үйлдсэн ямар ч хэргийн төлөө албан тушаалаа хашиж байхдаа болон

Большой юридический словарь.- М.Инфра. М.А.Я.Сухарева, В.Е.Крутских. 2003.С.346.

81 Конституции зарубежных стран. Сборник. Составитель В.Н.Дубровин. М.2006. стр 61

82 Конституция Российской Федерации. М. Изд Проспект. 1993 год

бүрэн эрхээ хэрэгжүүлж дууссаны дараа ч эрүүгийн хариуцлага хүлээхгүй онцгой халдашгүй эрхийг эдлэхээр хуульчилсан нь онцлог юм.^[83]

Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт "... түүний бие, нэр төр, ордон, өргөө, унаа халдашгүй дархан байна...", 5 дахь хэсэгт "...түүний амь бие, ордон, өргөө, холбоо, уналгын хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авна гэж Ерөнхийлөгчийн халдашгүй байдлыг баталгаажуулсан байна.

Харин ЭЭЗүй дэхь Ерөнхийлөгчийн халдашгүй байдлыг хуульчилахдаа манай улс олон улсын загвар, жишгийн эхний хувилбарыг сонгон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд хуульчилжээ.

Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7-р зүйлийн 2 дахь хэсэгт "...Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ..." гэж заасан нь гэмт хэрэг үйлдсэн явдалд хамаарах ба ийнхүү огцруулсан тохиолдолд л бүрэн эрх /халдашгүй байдал/ нь хуульд заасан хугацаанаас өмнө дуусгавар болж, түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болно.

Ерөнхийлөгчийн бүрэн эрх дээр авч үзсэнээр хугацааны өмнө бус, харин хууль тогтоомжид заасны дагуу түүний бүрэн эрхийн хугацаа дууссан бол Ерөнхийлөгчийн албан тушаал хашиж байхдаа үйлдсэн хэргийн төлөө хэрэв хэргийн хөөн хэлэлцэх өнгөрөөгүй тохиолдолд нийтлэг журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээдэг.

Депутатын /УИХ-ын гишүүний/ халдашгүй байдал:

Парламент нь төлөөллын ардчилалын сонгодог хэлбэр бөгөөд парламентын гишүүн нь төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн.

УИХ-ын гишүүн ард түмнийхээ элч, тэдний эрх ашгийг илэрхийлэгчийн хувьд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль,

83 И.В.Калинина.Правовой статус Президента Чешской Республики.Диссертация на соискание ученой степени кандидата юридических наук...М. 2000. стр 94



бусад хуульд заасан тодорхой эрхүүдийг эдлэх ба тэдгээр нь түүний бүрэн эрх гэсэн ойлголтыг бий болгодог, УИХ-ын гишүүний халдашгүй байдлаар баталгааждаг.

УИХ-ын халдашгүй эрх нь гишүүний албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэхэд зориулагдсан онцгой эрх дарх мөн.^[84]

ЭЭЗүй дэх УИХ-ын гишүүний халдашгүй байдал нь түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд хуульд заасан журмын дагуу УИХ-ын зөвшөөрөлгүйгээр баривчлах, саатуулах, эрхийг хязгаарлах, эрүүгийн хариуцлагад татах, эрүүгийн хариуцлага хүлээлгэж ял оногдуулж болохгүй байх явдлаар илэрнэ. Ийм жишиг ихэнх орнуудын парламентад байдаг, парламентат ёсны хөгжлийн явцад олон зуун жилийн туршид бий болсон юм.

УИХ-ын гишүүний халдашгүй байдал нь Үндсэн хууль, УИХ-ын тухай хуульд илрэлээ олсон байдаг. Үндсэн хуулийн 29-р зүйлийн 2 дахь хэсэгт "... Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална...". мөн зүйлийн 3 дахь хэсэгт "...Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эргүүлэн татна..." гэж заажээ.

УИХ-ын тухай хуулийн 6-р зүйлийн 6.9-р хэсгийн 6.9.1-т "...УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан бол Улсын ерөнхий прокурор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулах бөгөөд Улсын Их Хурал гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ..." гэж заасан төдийгүй, уг асуудлыг шийдвэрлэх процедурыг хуульчилсан байна.

Эрх бүхий хуулийн байгууллага УИХ-ын гишүүнийг УИХ-ын тухай хуулийн 6.9.1-д заасны дагуу баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 3 цагийн дотор нэн даруй мэдэгдэх ёстой. /6-р зүйлийн 6.10-р хэсэг/

Улсын Их Хурал чуулганы үеэр УИХ-ын тухай хуулийн 6.9.1-д зааснаар санал хүлээн авсан бол ажлын 2 өдрийн дотор

гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. /6-р зүйлийн 6.11-р хэсэг/

Харин чуулганы чөлөөт цагт дээрх саналыг хүлээн авсан бол 24 цагийн дотор ээлжит бус чуулган зарлаж, чуулганы хуралдаан эхэлснээс хойш ажлын 2 өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. /6-р зүйлийн 6.12-р хэсэг/

УИХ-ын тухай хуулийн 6.9.1-д заасан үндэслэлээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх танилцуулгыг Улсын ерөнхий прокурор зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хийнэ.

Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороодын болон Улсын Их Хурлын гишүүний Халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар шийдвэрлэхээр УИХ-ын тухай хуулийн 6-р зүйлийн 6.13-р хэсэгт хуульчилжээ.

Байнгын хорооны болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан дээр гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэхэд гишүүд асуулт тавьж хариулт авах, үг хэлж байр сууриа илэрхийлэх эрхтэй. /6-р зүйлийн 6.16-р хэсэг/

Хэрэв гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэсэн шийдвэрийг Улсын Их Хурал гаргасан бол баривчлагдсан гишүүнийг нэг цагийн дотор суллах үүрэгтэй. /6-р зүйлийн 6.14/

Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг УИХ гаргасан бол түүнийг үндэслэн нийтлэг журмаар мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагааг явуулж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Харин УИХ-ын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилаагүй, бусад үндэслэлээр хэргийг шалгаж эрүүгийн хэрэг үүсгэсэн бол УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг зөрчихгүйгээр мөрдөн шалгах ажиллагааг явуулж нотлох баримтыг цуглуулж эрүүгийн хариуцлагад татах, хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг УИХ-ын тухай хуульд заасан дээр дурьдсан журмын дагуу шийдвэрлүүлж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох

⁸⁴ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Анхны хэвлэл. УБ. 2007 он. 461 дэх тал



нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан бол УИХ-ын тухай хуулийн 6-р зүйлийн 6.6 дахь хэсэгт заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрх нь тухайн хуулийн 6.3-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болдог.

УИХ-ын тухай хуулийн 34-р зүйлийн 34.3-д УИХ-ын гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүйгээр заасан нь түүний халдашгүй байдлын онцлог болно.

Манай улсад парламентад ёсыг жинхэнэ утгаар хөгжүүлснээс хойших 25 жилийн түүхэнд УИХ-ын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой цөөнгүй тохиолдлууд /кейс/ гарч байснаас 1999 онд алдарт Казиногийн гэх хэрэгт УИХ-ын нэр бүхий гурван гишүүн холбогдож, УИХ гишүүнийх нь бүрэн эрхийг түдгэлдүүлснээр эрүүгийн хариуцлага хүлээж ял эдэлсэн, Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж 1994 онд УИХ-ын гишүүнээр ажиллаж байхдаа Улсын нууц задруулсан хэрэгт буруутгагдан, ТЕГ-аас шалгах хүсэлт ирүүлэхэд сайн дураараа гишүүнийхээ бүрэн эрхээсээ татгалзах хүсэлт гарган, хэргээ шалгуулан хэрэг нь хэрэгсэхгүй болж байсан, УИХ-ын гишүүн Д.Дондогийг түүний 2008 онд үйлдсэн бусдын их хэмжээний эд хөрөнгийг залилан мэхэлсэн хэрэгт холбогдуулан шалгаж, 2011 онд Нийслэлийн Прокурорын газар, УПЕГ-аас хоёр удаа гишүүнийх нь бүрэн эрхийг түдгэлзүүлэх хүсэлтийг УИХ-д ирүүлсэн боловч Халдашгүй байдлын дэд хороо бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн, 2012 онд түүний гишүүний бүрэн эрх дуусгавар болсон, УИХ-ын сонгуульд тэрээр дахин сонсогдож чадаагүй учраас хэргийг сэргээн шалгаж 2013 онд шүүхээр ял шийтгүүлсэн зэргийг дурьдаж болно.

Харин нийгэмд дуулиан үүсгээд байгаа УИХ-ын гишүүн Д.Гантулгын үйлдсэн гэх хүчингийн хэргийн тухайд уг хэргийг БЗД-ийн Цагдаагийн 1-р хэлтэс шалгаж Баянзүрх дүүргийн Прокурорын газраас уг хэргийг хэрэгсэхгүй болгосон, 2017 оны 8 сард УПЕГ-аас уг хэргийг татаж хянаад сэргээж мөрдөн байцаалт явуулж байна.

“Өмгөөлөгчдийн Веритас Партнерс” ХХН-өөс түүнийг 2017 оны 7-р сарын 6-ны өдөр Төрийн ордонд хувийн асуудлаар мэдээлэл хийсэн нь УИХ-ын гишүүний ёс зүйг зөрчсөн гэсэн үндэслэлээр УИХ-ын Ёс зүйн хороонд хандсан, Ёс зүйн хороо УИХ-ын гишүүн Д.Гантулгаас өөрөөс нь бичгээр тайлбар авч уг асуудлыг хэлэлцэн, УИХ-ын гишүүний ёс зүйг зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг, гишүүний тайлбарын хамт хүсэлт гаргасан талд хүргүүлсэн, 2017 оны 9-р сард хохирогчийн өмгөөлөгч Д.Мэргэн түүний гишүүний бүрэн эхийг түдгэлзүүлэхээр ҮХЦ-д хандаад байгаа, одоогоор эцэслэн шийдвэр-лэгдээгүй байна. Үндсэн хуулийн Цэцийн гишүүний халдашгүй байдал.

“Үндсэн хуулийн Цэцийн тухай” хуульд Цэцийн гишүүний халдашгүй байдлыг хуульчилсан нь түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх хууль ёсны баталгааны салшгүй нэг хэсэг мөн.

Цэцийн гишүүний халдашгүй байдлыг уг хуулийн 5-р зүйлд заасан байх ба түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд Цэцийн зөвшөөрөл-гүйгээр баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлага татах, эсхүл шүүхийн журмаар түүнд захиргааны шийтгэл оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.

Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсхийг энэ тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэж шийдвэрлэдэг.

Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

Манай улсад гарсан Цэцийн гишүүний халдашгүй байдалтай холбоотой нэг кейс гарсан нь Цэцийн гишүүн Д.Сугартай холбогдох Цэцийн шийдвэр юм. МИАТ компаний удирдлагуудын нислэгийн тийзны үнэд дайны эрсдэлийн даатгал нэрээр үндэслэлгүйгээр төлбөр нэмж, уг төлбөрийг хувьдаа завшсан, мөнгө угаасан хэрэг, Жаст компаний захирал Ш.Батхүү ӨАБНУ-ын Стандарт банкнаас 103 ая доллар зээлэхдээ Эрдэнэт компаниас баталгаа гаргуулсан



хэрэг, Оффшор бүсэд данс, хөрөнгө эзэмшдэг, хөрөнгө орлогын мэдүүлгээ буруу гаргасан гэх хэрэгт холбогдуулан Цэцийн гишүүн Д.Сугарыг шалгах талаар УЕПГ, АТГ-аас ирүүлсэн хүсэлтийг Үндсэн хуулийн Цэц хэлэлцэн, гишүүнийх нь бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлгүй гэсэн дүгнэлтийг гаргасан нь зарим талаар шүүмжлэл дагуулж байна.

Шүүгчийн халдашгүй байдал.

Шүүгчийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааны нэг нь түүний халдашгүй байдал бөгөөд *“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай”* хуульд дараахь байдлаар хуульчилжээ. Шүүгч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэн, төрийн тусгай албан хаагч бөгөөд түүний бүрэн эрх нь Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдон, шүүгчийн тангараг өргөснөөр эхэлнэ.

“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 17-р зүйлийн 17.1-д хуульчилснаар шүүгчийн бүрэн эрхийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч түдгэлзүүлэх ба ийнхүү түдгэлзүүлэх үндэслэлүүдийн нэг нь эрүүгийн хариуцлагад татагдсан явдал болно.

Шүүхийн хараат бус байх, халдашгүй байх эрхийг хангах зарчим баталгааг уг хуулийн 20-р зүйлд заасан байдаг. Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана.

Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулна.

Шүүгчийн хараат бус байх, халдашгүй байдлыг хангах баталгааны нэг нь Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгайлан зааснаас өөр үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлахыг хориглоно.

Мөн хуулийн 26-р зүйлд зааснаар Шүүгчийн халдашгүй байдалд

1. шүүгчийн амь бие /бие махбодь, амь нас, эрүүл мэнд/,
2. ажлын байр, хувийн болон албаны орон

сууц;

3. эзэмшиж, ашиглаж байгаа хувийн болон албаны тээвэр, холбооны хэрэгсэл;

4. өөрийнх нь мэдэлд байгаа бичиг баримт, ачаа тээш, бусад эд хөрөнгө;

5. захидал харилцааны нууц тус тус хамаардаг.

Шүүгчийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилсан бол энэ тухай Шүүхийн Ерөнхий Зөвлөлд 48 цагийн дотор мэдэгдэх ёстой. /26-р зүйлийн 26.7/

Энэ тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл тав хоногийн дотор Ерөнхийлөгчид гаргана. /26-р зүйлийн 26.8/

Ерөнхийлөгч саналыг хүлээн авч ажлын хоёр өдрийн дотор шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх ёстой. /26-р зүйлийн 26.9/

Хэрэв шүүгчийг гэмт хэрэг үйлдэх явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд хэргийг мөрдөн шалгах, хэргийг нотлох ажиллагааг зохих журмын дагуу явуулсаны /эрүүгийн хариуцлагад татагдсаны/ дараа шүүгчийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх хүсэлтийг *“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай”* хуулийн 17-р зүйлийн 17.1-д заасны дагуу ШЕЗөвлөлд хүргүүлнэ.

Хэрэв ШЕЗөвлөл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх хангалттай үндэслэлтэй гэж үзвэл саналаа Ерөнхийлөгчийн Тамгын газар хүргүүлэх уг саналыг үндэслэн түүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ. Энэ тохиолдолд л шүүгчид нийтлэг журмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.

Шүүгчийн халдашгүй байдлын нэг онцлог нь шүүгчийн албан тушаал хашиж байхдаа шүүх таслах үйл ажиллагааны эсрэг болон албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүгчээр ажиллаж байх хугацаанд нь нотлогдож тогтоогдоогүй, эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол түүний бүрэн эрх дууссаны дараа уг хэрэгт нь хуулийн хариуцлага хүлээлгэж болохгүй байхаар заасан явдал билээ.

Шүүгч эрх мэдлээ урвуулан ашигласан, илт хууль бус таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, шүүхийн бусад акт гаргасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор нотлогдоогүй бол бүрэн эрх нь дуусгавар болсны дараа шүүн таслах ажил эрхэлж байх үедээ илэрхийлсэн санал, гаргасан шийдвэрийнх нь төлөө



түүнийг ямар нэгэн хариуцлагад татахыг хориглоно. /26-р зүйлийн 26.3 хэсэг/

2.ЭЭЗүй дэх халдашгүй байдлын хоёрдахь ангилал бол түүнийг хуульчлагдсан эрх зүйн зохицуулалтаар нь

а/ Олон улсын хэм хэмжээнд заасан халдашгүй байдал,

б/ Үндэсний буюу дотоодын хууль тогтоомжид заасан халдашгүй байдал гэж ангилах явдал юм. Дээр дурьдсан дипломат /консулын/ ажилтны болон олон улсын хамгаалалтанд байдаг хүмүүсийн халдашгүй байдал нь уг ангиллын нэгдэх төрөлд, Ерөнхийлөгчийн, УИХ-ын гишүүний, Үндсэн Хуулийн Цэцийн гишүүний, Шүүгчийн халдашгүй байдал нь дотоодын хууль тогтоомжид хуульчлагдсан халдашгүй байдалд хамаарна.

3. ЭЭЗүй дэх халдашгүй байдлын гурав дахь ангилал нь ЭЭЗүй дэх халдашгүй байдлыг үйлчлэх хэмжээ хязгаараар нь:

а/ үнэмлэхүй халдашгүй байдал,

б/ ердийн /харьцангуй/ халдашгүй байдал гэж 2 төрөлд авч үзсэн ангилал болно.^[85]

Үнэмлэхүй халдашгүй байдал гэдэг нь халдашгүй байдал бүхий этгээд үйлдсэн хэргийн төлөө бүрэн эрхээ хэрэгжүүлж байхдаа болон бүрэн эрх нь дуусгавар болсны дараа ч эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх онцгой эрх, дархлаа юм. Харин ердийн халдашгүй байдал нь дээр авч үзсэн халдашгүй дархан эрх эдэлдэг албан тушаалтнууд Парламентаас бүрэн эрхийг нь түдгэлзүүлснээс бусад тохиолдолд халдашгүй эрх ямба эдэлдэг, харин бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд нийтлэг журмаар эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл байдал мөн. Бидний дээр дурьдсан Чех улсын Үндсэн хуулийн 65-р зүйлд Ерөнхийлөгч үйлдсэн ямар ч хэргийн төлөө албан тушаалаа хашиж байхдаа болон бүрэн эрхээ хэрэгжүүлж дууссаны дараа ч эрүүгийн хариуцлага хүлээхгүй онцгой халдашгүй эрхийг эдлэхээр хуульчилсан нь үнэмлэхүй халдашгүй байдлын жишээ болно.

4. ЭЭЗүй дэх халдашгүй байдлыг хамаарч үйлчлэх гэмт хэргийн онцлогоос хамаарч:

а/ бүх гэмт хэрэгт хамаарах халдашгүй байдал,

б/ зарим төрлийн гэмт хэрэгт хамаарах халдашгүй байдал гэж ангилж болно. Манай үндэсний хууль тогтоомжид хуульчлагдсан

⁸⁵ А.Г.Кибильник. Иммуниет как основание освобождения от уголовной ответственности. //https://www.lawmix.ru/comm/6744

халдашгүй байдлыг судлан үзэхэд халдашгүй байдал бүхий этгээдүүдийн хувьд Парламентын шийдвэрээр бүрэн эрхийг түдгэлзүүлээгүй бол албан тушаал хашиж байхдаа үйлдсэн хэрэгт гэмт хэргийн ангилал, төрөл хамаарахгүйгээр бол халдашгүй байдал эдлэхээр заасан нь онцлог юм.

Харин дээр дурьдсан Францын улсын хувьд Ерөнхийлөгчид зөвхөн төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол парламентын шийдвэрээр бүрэн эрхийг /халдашгүй байдлыг/ нь түдгэлзүүлэн, тусгай шүүхэд шилжүүлж эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг нь энэ ангилалын 2 дахь төрөлд хамаарна.

Дүгнэлт

1.ЭЭЗүй дэх халдашгүй байдал гэдэг нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжид тусгайлан заасан, эрүүгийн хууль хамаарч үйлчлэхгүй эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг журам үйлчлэхгүй байх, тодорхой эрх бүхий хүмүүст хамаарах онцгой нөхцөл, онцлог эрх зүйн байдал мөн.

2.ЭЭЗүй дэх халдашгүй байдал нь хууль зүйн агуулгаараа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, төрөл бус тодорхой хүмүүст эрүүгийн хууль үйлчлэхгүй, эсвэл эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг журам үйлчлэхгүй байх онцгой нөхцөл байдал байдгаараа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөс ялгагдана.

3.ЭЭЗүй дэх халдашгүй байдал нь олон улсын эрх зүй, үндэсний эрх зүйн бусад салбарт хуульчлагдсан бусад халдашгүй байдлуудаас халдашгүй дархан эрх эдэлдэг хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх эсвэл тусгай процедур, журмаар халдашгүй байдал, бүрэн эрхийг түдгэлзүүлсний дараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл байдлуудыг өөртөө агуулдаг, түүнийг тодорхойлж судалдаг, хуульчилдагаараа онцлогтой.

4.ЭЭЗүйд халдашгүй байдлыг онолын хувьд ийм эрх эдлэх субъект, түүний хуульчлагдсан байдал, эрх зүйн хэмжээ, хамаарах хүрээ, хэмжээ хязгаар зэрэг хэд хэдэн үндэслэлээр ангилж болох ба энэ нь уг институтын ойлголт, мөн чанар, онцлогийг таньж мэдэх боломжийг олгоод зогсохгүй, Эрүүгийн хуульд илүү оновчтой хуульчлахад ач холбогдолтой юм.

5.Халдашгүй эрх эдэлдэг хүмүүсийн бүрэн эрх /халдашгүй байдал/, түүнийг түдгэлзүүлэх, хариуцлага хүлээлгэх асуудлыг нийтлэг байдлаар холбогдох хууль



тогтоомжид заасан боловч, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, үйлдсэн хэргийг нь мөрдөн шалгах ажиллагааны талаар хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлсан зохицуулалтыг хуульчилж өгөөгүй байна.

Санал

1. Манай орны тухайд халдашгүй байдлын асуудлыг ЭЭЗүй төдийгүй эрх зүйн ерөнхий онолын түвшинд болон бусад салбар эрх зүйн хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр илүү нарийвчлан судлах, магистр, докторын судалгааны ажил явуулах,

2. Халдашгүй байдлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, материаллаг болон процессын хуульд илүү нарийвчлан хуульчлах замаар үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн уялдаа холбоог хангах,

3. 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд халдашгүй эрх эдэлдэг хүмүүсийн үйлдсэн хэрэгт явуулах мөрдөн шалгах ажиллагааг тусгай ажиллагааны журмаар явуулах, ийм зохицуулалтыг тусгай бүлэг нэмж хуульчлах,

4. Харьцуулсан эрх зүйн хүрээнд олон улсын хэм хэмжээ, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлах зэрэг болно.



ХОРИХ ЯЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАСАЖ ТООЦОХОД МАТЕМАТИК СТАТИСТИКИЙН АРГАЧЛАЛ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Б.Мөнхдорж

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, докторант, цагдаагийн хошууч

Товч агуулга: Монгол Улсын шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн. Шинээр баталсан Эрүүгийн хуулийн 1.9-д “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ” гэж заасан. Энэ заалтын дагуу ялтнуудын ялыг дүйцүүлэн хасах ажил хийгдсэн байна.

Хуучин Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулж, ял эдэлж буй ялтнуудын ялын хэмжээг шинэ Эрүүгийн хуульд дүйцүүлэн хасах математик статистикийн аргачлал боловсруулсныг практикт хэрэглэсэн байна. Тодруулбал, шинэ Эрүүгийн хууль батлагдан хэрэгжих үед ял эдэлж байсан ялтнуудын ялыг хасахад энэхүү аргачлалыг Улсын Дээд Шүүхээс хэрэглэсэн нь судалгааны ажлын практик ач холбогдлыг илэрхийлнэ.

Түлхүүр үгс: Эрүүгийн хууль, хорих ял, математик, статистик, аргачлал.

1. Удиртгал

Эрүүгийн хууль буцаан хэрэглэх онолын үндэслэл:

Доктор (Sc.D), профессор С.Жанцан “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь нэгэнт батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээг уг хууль хүчин төгөлдөр болохын өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт хэрэглэх үйл ажиллагаа”^[86] гэж тодорхойлжээ. Судлаач Г.Ганболд энэ ойлголтыг “Өмнөх хуучин Эрүүгийн хуулийг /урагшаа/ сэргээн хэрэглэх явдал биш, харин шинээр батлагдан гарсан Эрүүгийн хуулийг түүнийг хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө үйлдэгдсэн зөвхөн тийм тохиолдолд гэмт хэрэгт Эрүүгийн хуульд заасан хөнгөрүүлэх үндэслэлтэй үед хэрэглэх явдлыг хэлнэ” гэж тодорхойлсон байна. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх шаардлага нь Эрүүгийн хууль тогтоомжийг

шинэчлэн болон тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон нөхцөлд, өөрөөр хэлбэл, Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн агуулгатай хэм хэмжээ шинээр тогтоосон тохиолдолд бий болно.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх ойлголтын нэг хэсэг болох “тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялыг хөнгөрүүлсэн хууль гэдэг нь өмнөх Эрүүгийн хуульд тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын төрөл, хэмжээг жинхэнэ Эрүүгийн хуулиар, эсхүл түүний санкцид нэмэлт, өөрчлөлт хийсэн хуулиар хөнгөрүүлсэн байх бүх тохиолдол юм” гэжээ^[87]. Ялын төрөл хэмжээг хөнгөрүүлсэн хууль гэдэгт:

-Өмнөх хуулиар тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын дээд хэмжээг доош нь татсан,

-Тодорхой гэмт хэрэгт оногдуулж байсан ялын доод хэмжээг доош татсан,

-Тодорхой гэмт хэрэгт оногдуулж байсан ялын дээд, доод хэмжээг нэг зэрэг доош татсан,

-Тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан тодорхой төрлийн ялыг хөнгөн ялаар сольсон,

-Тодорхой гэмт хэрэгт оногдуулж байсан хэд хэдэн төрлийн ялуудаас хүнд ялыг нь хүчингүй болгосон,

-Тодорхой гэмт хэрэгт оногдуулахаар заасан нэмэгдэл ялыг хүчингүй болгосон зэрэг тохиолдлуудыг хамааруулжээ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль гэдэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд хүлээлгэх Эрүүгийн хариуцлагыг оногдуулах үндэслэл, нөхцөлийг хөнгөрүүлсэн субъектийн хувьд хэрэг үр дагавар бий болгож байгаа хэм хэмжээ гэж тодорхойлжээ^[88].

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь шинээр батлагдсан хуулийг дагаж мөрдөгдөхөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт шинэ болон урьд үйлчилж байсан хуулиудын аль хөнгөнийг хэрэглэх явдал бөгөөд ex post facto буюу шинэ хуулийг түүнээс өмнөх үйл баримтад хэрэглэх гэсэн зарчмыг удирдлага болгодог байна. Шинэ хуулиар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн бол хуулийг буцаан хэрэглэх

⁸⁷ С.Жанцан, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол”, УБ, 2009, 172-р тал

⁸⁸ С.Жанцан, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол”, УБ, 2009, 172-р тал

⁸⁶ С.Жанцан, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол”, УБ, 2009, 170-р тал

үндэслэл бий болдог. Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон бол шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийг ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлж, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн бол ялыг шинээр тогтоосон хэмжээнд дүйцүүлэн хасах хэлбэрээр хуулийг буцаан хэрэглэнэ гэж тайлбарлажээ^[89].

Эрүүгийн хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга, энэрэнгүй ёсны зарчим бол Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхэд зайлшгүй дагаж мөрдөгдөх ёстой. Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн түгээмэл зарчим болохын хувьд бүх тохиолдолд хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим мөрдөгдөх ёстой. Бүх хүн эрүүгийн хуулийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хүн бүр нэг адил хэргийн төлөө ойролцоо хариуцлага хүлээнэ гэсэн үг юм^[90]. Гэхдээ нэг ижил хэргийн төлөө хүлээлгэх хариуцлагыг тэгшитгэнэ гэсэн үг биш бөгөөд үйлдсэн хэрэг, учирсан хор уршиг нь адил боловч гэмт хэрэг үйлдсэн хүн бүрийн хувийн байдал, хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан ялыг ялгавартай оногдуулах нь тэгш эрхийн зарчим хэрэгжж байгаагийн нотолгоо гэгддэг. Нөгөө талаас шударга ёс, энэрэнгүй ёсны зарчим эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхэд хэрэгждэг. Эрүүгийн хуулийн буцаан хэрэглэхэд эдгээр зарчмуудыг чанд баримтлахын тулд математик статистикийн аргачлалыг хэрэглэх нь зайлшгүй гэж үзсэн.

Монгол Улсын Их Хурлаар 2015 оны 12 дугаар сарын 3-нд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, улмаар УИХ-аар 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр дахин өөрчлөлт оруулан баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ээс мөрдөгдөж эхэлсэн. Шинэчлэгдэн батлагдсан Эрүүгийн хуулиар ялын бодлогыг зөөлрүүлсэн, ялын бодлогыг уян хатан болгосон, ялтнуудын эрх зүйн байдлыг дээрдүүлэх бодлого баримтлагдсан байдаг^[91]. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэхээс илүү урьдчилан сэргийлэх, тухайн хүнийг нийгэмшүүлэх, энэрэнгүй ёсны зарчмыг сайн шингээсэн, хүнийг хамгаалах хууль болсон гэж судлаачид хэлжээ^[92].

Шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн 1.9^[93]-ийн 1-д “үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ”, 3-д “шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна” гэж заасан.

Эдгээр хуулийн заалтыг үндэслэн ялтнуудын ялыг шинэ Эрүүгийн хуульд дүйцүүлэн хасах, ялаас чөлөөлөх ажиллагаа хийгдсэн байна. Ингэж ялтнуудын ялыг дүйцүүлэн хасахад математик статистикийн аргачлалыг хэрэглэх нь бусдад ялгамжтай бус, шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоолсны үндсэн дээр шүүх шийдвэрээ гаргах нь шударга ёсонд нийцнэ гэж үзсэн. Энэхүү аргачлалыг боловсруулж, практикт хэрэглэх боломжийг буй болгосон талаар эрдэм шинжилгээний илтгэл хэлбэрээр судалгааны үр дүнг нийтэд толилуулж байна.

2. Судалгааны арга зүй

Монгол Улсын шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж байна. Хуучин Эрүүгийн хуулиар хорих ял авч, ялаас эдэлж буй ялтнуудын ялыг шинэ Эрүүгийн хуульд нийцүүлэн тэдний ялаас хасаж, чөлөөлөх ажиллагаанд анх удаа математик статистикийн хэрэглэх ашиглах талаар судалгааны ажил хийсэн.

Энэхүү аргачлалыг шинэ Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ялтнуудын хорих ялыг дүйцүүлэн хасах, чөлөөлөхөд хэрэглэжээ.

Учир нь Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан “2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас аймаг, нийслэлийн шүүхүүдэд хорих ялыг хэрхэн дүйцүүлэн хасах, чөлөөлөх талаар зөвлөмжийн хамт энэхүү аргачлалыг хүргүүлсэн байна.

Түүнчлэн, ялтнуудын ялыг дүйцүүлэн хасахад УДШ-ээс “ялын дундаж индексийг ашиглах, эсхүл ялын интервалаар хуульд нийцүүлэн хасах” зэрэг олон

⁸⁹ УДШ-ээс нийт шүүгч нарт хүргүүлсэн зөвлөмж. 2017.07-р сард

⁹⁰ С.Жанцан, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол”, УБ, 2009, 33-р тал

⁹¹ <http://medee.mn/main.php?eid=92525>

⁹² <http://www.today.mn/p/31426>

⁹³ 1.9 дүгээр зүйл.Хууль буцаан хэрэглэх



аргыг харьцуулан судалж, үзсэн байх ба эдгээр аргаас уг математик статистикийн аргачлалыг шударга ёсны зарчимд нийцнэ хэмээн сонгож хэрэглэжээ. Гэхдээ энэ аргачлал математик тооцоолол талаасаа боломж, үндэслэлтэй боловч түүнийг хуульд нийцүүлэн, амьдрал практикт бодитой ашиглах нь шүүх, шүүгчид хамаарах асуудал мөн.

Математик статистикийн аргачлалаар ялыг дүйцүүлэн хасахдаа жилээр тооцох бөгөөд сар, хоногоор тооцох тохиолдолд нэг жилийг 365 хоногт шилжүүлээд тооцох боломжтой.

АРГАЧЛАЛЫН ҮНДСЭН ТОМЬЁО:

X_1 –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	Y_1 –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
X_2 –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	Y_2 –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ
$\Delta X = X_2 - X_1$ –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын интервал	$\Delta Y = Y_2 - Y_1$ –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын интервал

Дээрх хувьсагчаар илэрхийлсэн үзүүлэлтүүдийг ашиглан хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын нэгж хэмжээнд харгалзах шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын хэмжээг илэрхийлэх коэффициентийг гаргана. Өөрөөр хэлбэл, Хорих ял дүйцүүлэх коэффициент:

$$K = \Delta Y / \Delta X = (Y_2 - Y_1) / (X_2 - X_1) \text{ /Томьёо.1/}$$

X^* –Тухайн ялтанд хуучин Эрүүгийн хуулиар оногдуулсан хорих ял

Y^* –Шинэ Эрүүгийн хуулиар буурах хорих ял. Өөрөөр хэлбэл хуучин Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулж, одоо хорих ял эдэлж буй ялтны ялын хэмжээ шинэ Эрүүгийн хуулиар хэрхэн буурах вэ гэсэн бидний тооцоолохыг хүсэж судалгааны үр дүн.

Тэгвэл шинэ Эрүүгийн хуулиар ялтны хорих ялын хэмжээ хэрхэн буурахыг томьёо.2-ыг ашиглан бодно.

$$Y^* = Y_1 + K * (X^* - X_1) = Y_1 + (Y_2 - Y_1) / (X_2 - X_1) * (X^* - X_1) \text{ /Томьёо.2/}$$

Судалгааны явцад хуучин, шинэ Эрүүгийн хуулиар хорих ялын доод, дээд хэмжээ өөрчлөгдсөн байгаа учраас дараах 4 тохиолдолд томьёо.2-ыг ашиглан ялын хэмжээг бууруулна.

Харин Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дордуулахгүй ба

харин дээрдүүлэх байдлаар үзүүлэлтийг ашиглана.

Нэмж тодотгол хийхэд УДШ-ээс “Хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал”-ыг нийт шүүгч нарт зориулан боловсруулж хүргүүлжээ. Уг аргачлалын төгсөлд “Ялыг дүйцүүлэн хасах тухай” захирамж гаргахад дээрх томьёо.2-ыг ашиглахыг тайлбарлан оруулсан байна.

УДШ-ээс “Хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал”-ын хэсгээс.....

.....Шинэ Эрүүгийн хуулиар дүйцсэн ялын хэмжээг тодорхойлохдоо /Ядүйц/ эхлээд ял дүйцүүлэх коэффициентийг /Кдүйц/ олно. Энэ нь шинэ Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг дэх дээд, доод ялын хэмжээний зөрүүг /ШЯдээд-ШЯдоод/ өмнөх Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг дэх дээд, доод ялын хэмжээний зөрүүд /ХЯдээд-ХЯдоод/ харьцуулсан харьцаа /хуваасан/ байна. Уг коэффициентийг /Кдүйц/ өмнөх хуулиар оногдуулсан ял /Яөмнөх/, ялын доод хэмжээ /ХЯдоод/ хоёрын зөрүүгээр үржүүлж шинэ ялын доод хэмжээн дээр /ШЯдоод/ нэмнэ. Өөрөөр хэлбэл:

$$\text{Ядүйц} = \text{Кдүйц} * (\text{Яөмнөх} - \text{ХЯдоод}) + \text{ШЯдоод}$$

$$\text{Кдүйц} = (\text{ШЯдээд} - \text{ШЯдоод}) / (\text{ХЯдээд} - \text{ХЯдоод}) \dots$$

АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭХ ХУВИЛБАРУУД:

Дээрх үндсэн томьёо.1, 2-г ялын дээд, доод хэмжээний өөрчлөлтөөс хамааран дараах 4 хувилбараар ялыг дүйцүүлэн хасаж тооцно. Үүнд:

Кейс-1:

Өгөгдөл:

5 жил –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	2 жил –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
10 жил –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	8 жил –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ?

$X^* = 6$ жил бол $Y^* = 2 + (8 - 2) / (10 - 5) * (6 - 5) = 3.2$ жил(хуучин ЭХ-иар 6 жилийн ял авсан ялтны ял 3.2 жил болж буурах үр дүн гарч байна)

$X^* = 5$ жил бол $Y^* = 2 + (8 - 2) / (10 - 5) * (5 - 5) = 2$ жил(хуучин ЭХ-иар 5 жилийн ял



авсан ялтны ял 2 жил болж буурах үр дүн гарч байна, өөрөөр хэлбэл хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээ шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээтэй адилхан болж буурна)

$X^{**}=10$ жил бол $Y^{**}=2+(8-2)/(10-5)*(10-5)=8$ жил (хуучин ЭХ-иар 10 жилийн ял авсан ялтны ял 8 жил болж буурах үр дүн гарч байна)

$X^{**}=7.5$ жил бол $Y^{**}=2+(8-2)/(10-5)*(7.5-5)=5$ жил (хуучин ЭХ-иар 7 жил 6 сарын жилийн ял авсан ялтны ял 5 жил болж буурах үр дүн гарч байна)

Кейс-2:

Өгөгдөл:

5 жил –Хуучин
Эрүүгийн хуулийн
хорих ялын доод
хэмжээ

2 жил–Шинэ
Эрүүгийн хуулийн
хорих ялын доод
хэмжээ

10 жил–Хуучин
Эрүүгийн хуулийн
хорих ялын дээд
хэмжээ

14 жил–Шинэ
Эрүүгийн хуулийн
хорих ялын дээд
хэмжээ

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ? Энэ тохиолдолд ЭХ-ийг буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх учраас шинэ ЭХ-ийн ялын дээд хэмжээг хуучин ЭХ-ийн ялын дээд хэмжээгээр тооцож бодно.

$X^{**}=6$ жил бол $Y^{**}=2+(10-2)/(10-5)*(6-5)=3.6$ жил

$X^{**}=5$ жил бол $Y^{**}=2+(10-2)/(10-5)*(5-5)=2$ жил

$X^{**}=10$ жил бол $Y^{**}=2+(10-2)/(10-5)*(10-5)=10$ жил

$X^{**}=7.5$ жил бол $Y^{**}=2+(10-2)/(10-5)*(7.5-5)=6$ жил

Кейс-3:

Өгөгдөл:

5 жил–Хуучин
Эрүүгийн хуулийн
хорих ялын доод
хэмжээ

6 жил–Шинэ
Эрүүгийн хуулийн
хорих ялын доод
хэмжээ

10 жил–Хуучин
Эрүүгийн хуулийн
хорих ялын дээд
хэмжээ

8 жил–Шинэ
Эрүүгийн хуулийн
хорих ялын дээд
хэмжээ

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ? ЭХ-ийн буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх учраас шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээг хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээгээр тооцож бодно.

$X^{**}=7$ жил бол $Y^{**}=5+(8-5)/(10-5)*(7-5)=6.2$ жил

$X^{**}=5$ жил бол $Y^{**}=5+(8-5)/(10-5)*(5-5)=5$ жил

$X^{**}=10$ жил бол $Y^{**}=5+(8-5)/(10-5)*(10-5)=8$ жил

$X^{**}=7.5$ жил бол $Y^{**}=5+(8-5)/(10-5)*(7.5-5)=6.5$ жил

Кейс-4:

Өгөгдөл:

5 жил–Хуучин
Эрүүгийн хуулийн
хорих ялын доод
хэмжээ

2 жил–Шинэ
Эрүүгийн хуулийн
хорих ялын доод
хэмжээ

10 жил–Хуучин
Эрүүгийн хуулийн
хорих ялын дээд
хэмжээ

8 жил–Шинэ
Эрүүгийн хуулийн
хорих ялын дээд
хэмжээ

Хуучин Эрүүгийн хуулийн 55¹ дүгээр зүйлд^[94] зааснаар хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулсан тохиолдолд шинэ Эрүүгийн хуулиар ялтны ялын хэмжээ хэрхэн буурах вэ?

Хуучин Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээнээс бага ял оногдуулсан тохиолдолд хуучин, шинэ Эрүүгийн хуулийн ялын өөрчлөлтийн коэффициентийг ашиглан шинэ Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг олж тооцож бодно. Мөн тооцоолол хийхдээ хуучин Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг түүнээс багаар оногдуулсан ялын хэмжээгээр авна.

$$Y^{**}=(X^{**}Y_1)/X_1 + (Y_2-Y_1)/(X_2-X_1)*(X^{**}-X_1) / \text{Томьёо.3/}$$

$(X^{**}Y_1)/X_1$ –хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээнээс бага ял оногдуулсан нь шинэ Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг бууруулах коэффициент

$X^{**}=3$ жил бол $Y^{**}=(3*2)/5+(8-2)/(10-5)*(3-3)=1.2$ жил

$X^{**}=4$ жил бол $Y^{**}=(4*2)/5+(8-2)/(10-5)*(4-4)=1.6$ жил

Хуучин Эрүүгийн хуульд зааснаар хорих

⁹⁴ 55¹ дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах.

55¹. 1.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна. [Энэ зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)



ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулсан тохиолдолд хуучин, шинэ Эрүүгийн хуулийн ялын өөрчлөлтийн коэффициентийг ашиглан шинэ Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг тооцоолон олж кейс-4 дэх томъёогоор тооцож бодно. Мөн тооцоолол хийхдээ хуучин Эрүүгийн хуулийн ялын доод хэмжээг түүнээс багаар оногдуулсан ялын хэмжээгээр авна.

Жишээ нь: Хуучин Эрүүгийн хуулиар 5-10 жилийн хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөнгөрүүлэн 4 жилийн ял оноосон тохиолдолд тухайн гэмт хэргийн шинж нь шинэ Эрүүгийн хуульд дүйцүүлэн тооцоход ялын интервал нь 2-8 жил болсон байвал ялыг дүйцүүлэн хасаж 1.6 жил болно гэж математик статистикийн загварчлал хийгдэж байгаа юм. Мөн 5 жилийн ял авсан этгээдийн ял 2 жил болж хасагдах тооцоо гарч байгаа. Улсын дээд шүүх, анхан шатны шүүхийн шүүгч нар кейс-4 дэх тохиолдолд ялтны ялыг харилцан адилгүйгээр хасаж байгаа практик байна.

Шүүгч Ч.Хосбаярын зөвлөж хэлснээр хуучин эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулсан тохиолдолд шинэ эрүүгийн хуулийн ялын доод хэмжээнд ялыг дүйцүүлэн бууруулна, учир нь дээрх жишээн дээр 3, 4, 5 жилийн ял оногдуулсан байсан ч шинэ эрүүгийн хуулийн ялын доод хэмжээ болох 2 жилийн ял адилхан болж буурах ёстой гэж байв. Энэ тохиолдолд аргачлалд өөрчлөлт оруулах шаардлага үүснэ. Энэ аргачлалыг боловсруулах ажил анхны оролдлого бөгөөд дараа дараагийн удаа энэ аргачлалыг улам чамбайруулах боловсруулах асуудал цаашид тавигдана.

3. Судалгааны хамрах хүрээ

Хуучин Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулж, ял эдэлж буй ялтнуудын ялын хэмжээг шинэ Эрүүгийн хуульд нийцүүлэн хасахад энэхүү математик статистикийн аргачлалыг хэрэглэх боломжтой.

Үйлдсэн гэмт хэрэг нь шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон тохиолдолд шууд суллагдах ба хорих ял нь өөр төрлийн хөнгөн ял болж өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү аргачлал ашиглагдахгүй.

4. Аргачлалын практик хэрэглээ, үр дүн

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд анхан шатны шүүхүүдэд 25 хорих анги, 14 шийдвэр гүйцэтгэх албанаас 4878 ялтны материалыг шилжүүлж ирүүлжээ. Улсын хэмжээнд

дүүрэг, сум дундын нийт 28 шүүхийн 70 гаруй шүүх бүрэлдэхүүн Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, гэмт хэрэгт тооцогдохгүй болсон үйлдэл, эс үйлдэхүйд ял шийтгүүлсэн этгээдийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээнээс чөлөөлөх, оногдуулсан ял нь тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал дүйцүүлэн хасах асуудлыг 2017 оны 7 дугаар сарын 3-5-ны хооронд шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд 4124 ялтны ялыг 2015 оны хуулийн зохих зүйл хэсэгт оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнд дүйцүүлэн хасч шийдвэрлэж, үүнээс ял нь хөнгөрсөн 1049 ялтныг суллаг, үлдсэн 3075 ялтны ялыг дүйцүүлэн хассан байна^[95]. Эдгээр ялтнуудын ялыг дүйцүүлэн хасах, ялаас чөлөөлөхөд энэхүү аргачлалыг хэрэглэсэн нь түүний практик хэрэглээ, судалгааны үр дүн илэрхийлэгдэж байна.

Шүүх, шүүх бүрэлдэхүүн ашиглахад хялбар болох үүднээс энэхүү аргачлалыг excel програмд хөрвүүлэн зөвлөмжийн хамт Улсын дээд шүүхээс хүргүүлсэн байгаа нь судалгааны ажлын зохих үр дүн гарсан байна.

Түүнчлэн, түүвэр судалгаа хийх, ярилцлага хийх явцад 2017 оны 08 дугаар сард анхан

Хуучин хууль/Шинэ хууль		Хуучин ял		Шинэ ял	
Хуучин хууль/Шинэ хууль	Хуучин ял/Шинэ ял	Хуучин ял	Шинэ ял	Хуучин ял	Шинэ ял
Та доорх заавартай танилца уу					
Хуучин хуулийн дахь хязгаарыг D 14 нүдэнд оруулна					
Хуучин хуулийн доод хязгаарыг E 14 нүдэнд оруулна					
Шинэ хуулийн доод хязгаарыг D 15 нүдэнд оруулна					
Шинэ хуулийн доод хязгаарыг E 15 нүдэнд оруулна					
Ногоон талбар дахь 4 нүдэнд л утга оруулна бусад нүдэнд утга орууластгүй. Хэвэргийн талбараас хуучин хуулиар оноосон ялын дүнгээ тооцож тухайн төрлийн шинэ хуулиар олгогдох ялыг тодорхойлно. Энэ арга нь хуучин болон шинэ хуулийн интервалыг 100 хэсэгт хувааж харгалзуулсан болно. Бүр нэрийг өөрчлөн 500, 1000 хэсэгт хувааж тооцоолох байх болохыг боломжтой.					
Н баганад хуучин хуулийн ялыг жинлээр, К баганад хуучин хуулийн ялыг хоногсоор илэрхийлсэн. К баганад шинэ хуулийн ялыг хоногсоор, L баганад шинэ хуулийн ялыг жинлээр илэрхийлсэн.					
Анкарахаг асуудал: Н болон L багануудад жинлээр илэрхийлсэн байдал нь 10-тэн бутархай тул сав өсдөгт жинлүүлэхэд анкарахагтай хандана уу. Жишээ: Н баганад					
K баганад					

шатны шүүхийн шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч, ялаа дүйцүүлэн хасуулах талаарх 2 гомдол ирүүлснийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх дээр хянан үзжээ. Уг 2 гомдлыг хянан үзээд иргэн Э нь 13 жилийн хорих ялтай байсныг 12 жил 2 сар 13 хоногийн, иргэн Б нь 18 жилийн хорих ялтай байсныг 14 жил 4 сар 26 хоногийн ялтай байхаар тогтоосон анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, ялыг

⁹⁵ <http://www.ikon.mn/n/121x>



дүйцүүлэн хассан нь үндэслэлтэй байгааг дурдаж шийдвэрээ гаргасан байна. Энэ нь ялыг дүйцүүлэн хасах, чөлөөлөхөд уг аргачлалыг хэрэглэсэн байна.

5. Хэлэлцүүлэг/discussion

Хуучин Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлд зааснаас гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулсан^[96] ялын хэмжээг хэрхэн бууруулах талаар аргачлал ийгээгүй бөгөөд шаардлагатай үед кейс-4-ыг ашиглан бодох боломжтой. Энэ үед хуучин эрүүгийн хуулийн ялын доод, дээд интервалыг ерөнхий ангид журамласнаар дахин тооцоолж бодох шаардлага үүснэ.

Харин торгох, баривчлах, хорихоос өөр төрлийн ял авсан ялтнуудыг ялыг дүйцүүлэн бууруулах, чөлөөлөхөд энэхүү аргачлалыг ашиглах нь оновчтой бус байж болзошгүй. Иймд тохирох аргачлалыг судалж, гаргах шаардлага бий болно.

Шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн 1.9-ийн 3-д "шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна" гэж заасан. Мөн Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд "2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэг, заалтад зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна" гэж заасан байна. Ялыг нийцүүлэн хасах, дүйцүүлэн хасах ойлголтыг тайлбарлаж, нэг мөр болгох шаардлага байна.

⁹⁶ 60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулах.

60.1.Шүүх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулахдаа гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ, завдалт төгссөн эсэх, бэлтгэсэн буюу завдсан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэргээ туйлд нь хүргэж чадаагүй нөхцөл байдлыг харгалзана.

60.2.Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний хоёроны нэгээс хэтрэхгүй байна. [Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

60.3.Гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна. [Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

60.4.Онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүй.

Дүгнэлт

Хуучин Эрүүгийн хуулиар ял оногдуулсан ялтны ялыг дүйцүүлэн хасах, эрх зүйн байдлыг дээрдүүлэхэд энэхүү математик статистикийн аргачлалыг хэрэглэснээр ялгамжтай байдлаар ялыг дүйцүүлэх хасах эрсдэлээс хамгаалагдсан гэж үзэж байна. Нөгөө талаас хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга ёсны зарчим бодитой хэрэгжихэд чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Эрүүгийн хуулийн зорилгыг ханган хэрэгжүүлэх, шударга ёсыг тогтоох, хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд математик, статистикийн арга, аргачлалыг хэрэглэх анхны оролдлого хийсэн нь эрдэм шинжилгээ, судалгааны хувьд шинэлэг, мөн хууль, шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд тус дэмтэй ажил болсон.

Санал

Эрүүгийн хууль шинэчлэгдсэн тохиолдолд ялтны хорих ялыг дүйцүүлэн хасахад энэхүү математик статистикийн аргачлалыг бүх шатны шүүхэд нэг мөр ойлгож хэрэглэх, улмаар өршөөл үзүүлэх, уучлал үзүүлэхэд энэ төрлийн аргачлалыг хэрэглэх боломжийг дахин судлах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Талархал: Энэхүү аргачлалыг боловсруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ж.Болдбаатар болон доктор (Ph.D) Ч.Нямсүрэн, Б.Батзориг, Ц.Батсүх, Б.Энхболд, судлаач Г.Эрдэнэбат, Г.Оюунболд, шүүгч Ч.Хосбаяр, Ц.Батцэрэн, Т.Өсөхбаяр, Х.Ганболд нарт талархал илэрхийлье.

Аргачлалын математик статистикийн үндэслэлийг тодорхойлсон эрдэмтний санал, дүгнэлт, шүүмж:

Судлаач Б.Мөнхдоржийн бичсэн "Хорих ялыг хасаж (дүйцүүлэн) тооцоход математик статистикийн аргачлал ашигласан нь" сэдэвт илтгэлд эрүүгийн хуулийн хорих ялыг дүйцүүлэхэд хэрэглэхээр санал болгосон Томьёо.1-ээр илэрхийлэгдэх коэффициент нь математикт нэг хэмжээсийг (масштабыг) нөгөө хэмжээст шилжүүлдэг стандарт томьёо юм. Мөн томьёо 2-д авч үзсэн хуучин



хуулиар тогтоогдсон Х хэмжээний ялтай хүний шинэ хуулиар харгалзах ялын хэмжээ Ү-г тооцоолох санал нь агуулгын хувьд зөв тодорхойлогдсон байна.

Дээрх хоёр томъёог хэрвээ мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн шилжүүлгийг хэрэглээний үнийн индекс, эсвэл ДНБ-ий дефлятороор сонгож зөв илэрхийлсэн тохиолдолд мөнгөн торгуулийн шийтгэлийн хувьд ч хуучин хуулийн торгуулийн ялыг шинэ хуулийн заалтад нийцүүлэн тооцох бололцоотой юм. Ц.Батсүх / Эдийн засгийн ухааны (Ph.D) доктор, математикч/.2017.09.12

Ашигласан материал

- 1.Монгол Улсын Эрүүгийн хууль, 2008 он
- 2.Монгол Улсын Эрүүгийн хууль, 2017 он

3.Базарсад.Я, Энхбат.Р, Магадлалын онол, математик статистикийн гарын авлага, УБ.,
4.Дуламсүрэн.Л, Статистикийн онол, УБ., 1999

5.Жанцан.С, Ихзаяа.П, Мөнхдорж.Б, Гэмт хэргийн статистик, УБ., 2007

6.Жанцан.С, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол” (гэмт хэргийн тухай сургааль), УБ, 2009

7.Жанцан.С, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол”(ялын тухай сургааль), УБ, 2014

8.<http://medee.mn/main.php?eid=92525>

9.<http://www.today.mn/p/31426>

10.<http://medee.mn/main.php?eid=94724>

11.<http://www.ikon.mn/n/121x>



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖИЙН УЛАМЖЛАЛД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Б.Мөнхзаяа

ХСИС-ийн Ахисан шатны боловсролын
сургуулийн ахлах багш, докторант, хошууч

Хураангуй: Энэхүү илтгэлээр Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж буюу эрүүгийн эрх зүйн материаллаг эх сурвалжын уламжлагдан ирсэн байдалд харьцуулсан болон түүхчилсэн судалгааны арга ашиглаж, эх сурвалжид онолын үзэл баримтлал, түүхэн уламжлал, бусад хүчин зүйл хэрхэн нөлөөлж ирсэнийг судлах, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

1. Эрүүгийн эрх зүйн номлол, үзэл баримтлалд хийсэн шинжилгээ

Аливаа төр улсын хууль сахиулах, хууль тогтоох үйл ажиллагаа нь тодорхой, шалгарсан онол, сургаалиудад тулгуурлаж байж тогтвортой, алдаа хийдэлгүй хэрэгжих боломжтой болдог. Түүнчлэн: номлол, тэдгээрийн үзэл баримтлалыг танин мэдсэнээр тухайн улсын төр, эрх зүйн мөн чанар, түүхэн цаг хугацаанд хэрхэн нөлөөлж ирсэн, цаашдын чиг хандлагыг тодорхойлох боломжтой юм. Тухайлбал: эрүүгийн эрх зүйн онол сургаалыг судалснаар тухайн орны эрүүгийн хууль тогтоомжийн зүй тогтол, мөн чанарыг нээн харуулах боломжтой. Жишээлбэл: философич, Ч.Беккаригийн^[97] онол, сургаалын нөлөөллөөр баруун европын орнуудын эрүүгийн хуулийн бүтэц, үзэл санаа, баримтлал, зарчим бий болсон байдаг. Эсвэл онол сургаалийн гажуудал, түүхэн өөрчлөлтөөр шашины зан үйлтэй холбоотой гэмт хэрэг, хүнд ял шийтгэл зэрэг нь үүсэн бий болдог гэж үздэг.

Онол, сургааль, номлолыг судлахдаа өргөн хүрээнд /макро түвшинд/ гэмт явдал, тэдгээрт тохирсон ял шийтгэлийн асуудлыг судлах, харин нарийвчлан /микро түвшинд/ судлахдаа эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний институтын онолын үндсийг судлах нь чухал ач холбогдолтой байдаг^[98].

Энэрэнгүй ёсны зарчмын гол төлөөлөгч болсон Ш.Монтескье, Ч.Беккариа нарын бүтээлд^[99]:

-Цаазаар авах ялын хэрэглээг багасгах /харгис, хэрцгий аргаар гүйцэтгэхийн эсрэг/;

-Гэмт хэрэг ба түүнд оногдуулах ял шийтгэлийг хуульд урьдчилан зааж өгөх;

-Шашин шүтэх, эс шүтэхтэй холбоотой үзэгдлийг гэмт хэрэгт тооцож ял шийтгэхгүй байх;

-Ял шийтгэл тухайн гэмт хэрэгт тохирсон байх номлолууд тусгагдсан нь эх газрын эрх

зүйн тогтолцоотой дийлэнх улс орнуудад тусгалаа олсон байдаг.

Харин эрүүгийн эрх зүйн сонгодог сургаалийн гол төлөөлөгчид болох А.Фейербах, И.Бентам нар "...хуулиас гадуур яллахын эсрэг буюу хууль дээдлэх зарчим^[100], өөрийн үйлдсэн гэмт хэрэгт зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, гэмт хэрэг үйлдсэн бол ял гарцаагүй оногдуулах, эрүүгийн эрх зүйн гол зорилго нь ял оногдуулах..." зэргээр эрүүгийн эрх зүйн гол үзэл баримтлалуудыг тодорхойлж ирсэн.

Профессор С.Жанцан: дээрх сонгодог сургаалийн үзэл, номлолд тулгуурлаж олон орон өөрсдийн эрүүгийн хууль тогтоомжыг боловсруулж, тэр тусмаа Наполеоны 1810 оны эрүүгийн хууль боловсрогдсон байдаг. Энэ бүлийн эрх зүйн тогтолцоо бүрэлдэн хөгжихөд Вольтер, Дидро, Монтескье зэрэг Францын соён гэгээрүүлэгчид, Гегель, Кант зэрэг Германы гүн ухаантнуудын номлол, үзэл санаа чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ бүлийн том төлөөлөл бол 1810 оны Францын Эрүүгийн хууль^[101], XIX зууны үеийн Германы Эрүүгийн хууль тогтоомж юм^[102] гэж тэмдэглэсэн байна.

Харин ОХУ-ын профессор Н.Е.Крылов "...Наполеоны 1810 оны эрүүгийн хууль эрүүгийн эрх зүйн сонгодог, жишиг хууль байсан төдийгүй Францын колони байсан ази, европ, африк, латин америкийн олон оронд загвар хууль болсон..."^[103] гэж тэмдэглэсэн нь тухайн онол сургаал, хууль тогтоомжийн ач холбогдлыг эрүүгийн эрх зүй судлаач эрдэмтэд нэг түвшинд хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлсэн байна.

Хүн судлал ба социологийн онолын гол төлөөлөгч болсон Ч. Ломброзов, Э. Ферри нарын онол сургаалиар "... ял зорилго зөвхөн шийтгэх биш нийгмийг гэмт этгээдүүдээс хамгаалах, ял шийтгэл оногдуулахдаа гэмт хэрэг үйлдсэн хүний онцлогоос хамаарч тооцох боломжтой байх, болгоомжгүй гэмт хэрэг үйлдэх, онц аюултай гэмт хэрэгтэн, онц аюултай гэмт хэрэг, рецидив гэмт хэрэгтэн, ял шийтгэл эдлүүлэхдээ хүмүүжүүлэх зэрэг зорилготой байх..."^[104] зэрэг үзэл санааг дэлгэрүүлсэн

¹⁰⁰ nullumcrimen, nulla poena sine lege

¹⁰¹ Энэ хууль нь Франц улсад 1994 он хүртэл хүчин төгөлдөр үйлчилжээ.

¹⁰² С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /гэмт хэргийн тухай сургаал/ I боть, 2009 он

¹⁰³ Крылова Н. Е. Основы черты нового Уголовного кодекса а Франции. М., 1996. 7 дахь тал.

¹⁰⁴ Дусаев Р. Н. Эволюция уголовного права стран Западной Европы и США. Петрозаводск, 1999.

⁹⁷ «Гэмт хэрэг ба ял шийтгэлийн тухай» бүтээл.

⁹⁸ Жишээлбэл: гэмт хэргийн субъектын онол, Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол.г.м

⁹⁹ А.В.Наумова «Основные концепции современного уголовного права». М., 1998



нь тухайн үедээ эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн байна. Энэхүү үзэл санааны нөлөөллөөр 1885 онд Францад дахин давтан /засрашгүй гэмт хэрэгтэн/ гэмт хэрэгтэнд бүх насаар нь хорих ял оногдуулах, гэмт хэргийн “онц аюултай” гэсэн ангилалыг Герман, АНУ-ын муж улсууд холбогдох хууль тогтоомжид тусгах, Англи улсад байнгын гэмт хэрэгтэн гэсэн тодорхойлолт нь 1991 он хүртэл хууль тогтоомжид нь тусгагдсаар иржээ.

Дээрх онолын үзэл баримтлалд тулгуурлагдаж боловсруулагдсан эрүүгийн хууль тогтоомж зарим улсад хэрхэн өөрчлөгдөж, шинэчлэгдэж ирснийг Хүснэгт 1-д харуулсан.

Хүснэгт 1. Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудын эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлт явуулж ирсэн байдал.

Улсын нэр	Эрүүгийн хууль батлагдсан онууд											
Монгол	1926	1929	1934	1942	1961	1974	1987	1993		2002	2015	
ОХУ	1922			1941	1960		1985	1991	1996			
БНХАУ	1912 ²	1928 ³	1935 ⁴		1951 ⁵	1974			1997			
ХБНГУ /1871/					1968	1975	1986	1998				
Дани /1886/			1933		1954							
Голланд	1919 ⁶	1928 ⁷	1935 ⁸		1950 ⁹		1980 ¹⁰	1993 ¹¹				
Швейцар /1886/		1928	1937	1942	1950	1971	1980 ¹²	1998 ¹³				

Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудын эрүүгийн эрх зүйн эх сурвалж 10 жилийн давтамжтай өөрчлөгдөж байна. Гэхдээ өндөр хөгжилтэй улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж харьцангуй тогтвортой үйлчилж байгаа нь харагдаж байна. Түүнчлэн

дээрх эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад эрүүгийн эрх зүйн онол сургаалиуд улс орон тус бүрийн онцлогоос шалтгаалж харьцангуй өөр өөр нөлөөлөлтэй байж болно. Тухайлбал: Швейцарын эрүүгийн хууль урьдчилан сэргийлэх, тайлбарлах хэлбэр голлосон бол Франц улсад сургалт, эрдэм шинжилгээний байгууллага эрүүгийн хуулийг хэрхэн практикт хэрэглэх талаар тайлбарладаг. Харин тулгуур онол, үзэл баримтлал нь макро түвшинд ижил байна. Эрүүгийн эрх зүйн эх сурвалжид онол, үзэл баримтлал нөлөөлж ирсэн нь судалгаанд хамрагдсан орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан гэж дүгнэж байна.

2. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн эх сурвалжын түүхэн уламжлалд хийсэн судалгаа

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн уламжлалыг эрдэмтэн судлаачид авч үзэхдээ 1921-оноос эрх зүйн хөгжилд шинэ хувьсал хийж ирсэн гэж тэмдэглэсэн байдаг. 1921 оны 11 дүгээр сарын 1-нд Ардын Засгийн газар ба Богд хааны хооронд эрх хэмжээг зааглан тогтоосон “Тангарагын гэрээ” хэмээгдсэн түүхэн баримт бичиг гаргаснаар Ардын Засгийн Газрын мэдэлд Засгийн эрх бүрэн төвлөрчээ. Энэхүү гэрээг судлаачид Үндсэн хуулийн эрх зүйн гэрээ байсан гэж үздэг. Уг гэрээнд “Энэхүү дүрмийг Монгол ард улсын төр бат, шашин дэлгэрч дотооддоо эвтэй гадаадад сүртэй олон түмэн жаргалтай байхыг эрхэмлэн зохиосон тул Богд хаан, Засгийн газар хоёр энэхүү дүрмийг эвдэлгүй ёсчлон явуулахыг ариун тангараг болгон батлав” гэж заасан байдаг. Мөн Эрүүгийн эрх зүйн шинжтэй хуульчилсан актууд нийгмийн харилцааг зохицуулж байсан. Жнь: 1921 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Ардын Засгийн газрын хурлын 9 дүгээр тогтоолд “Эх орноосоо урвах гэмт хэрэгт алах, цөлөх, дөнгөлөх ялыг өөрчилж алах ялыг 10 жил хорих, аймаг алгасуулан цөлөх ялыг 3 жил хорих, зэргэлдээ аймагт цөлөх ялыг 1 жил хорих ял болгон өөрчилж хоригдлын ял эдлэх хугацаанд хөдөлмөр эрхлүүлэхээр” болгожээ. БНМАУ-ын хоёрдугаар их хурал 1925 оны 11 дүгээр сард хуралдаж эрүүгийн эрх зүйн үндсэн зорилго, зарчмуудыг тодорхойлсон.

Монгол Улсын анхны Эрүүгийн хууль нь “Шүүх цаазны бичиг” гэдэг нэртэйгээр ерөнхий ангийг нь Засгийн Газрын 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр хурлаар, тусгай ангийг нь 1926 оны 11 дүгээр сарын



11-ны өдрийн улсын гуравдугаар их хурлаар тус тус батлан гарсан. Уг хууль ерөнхий анги 7 бүлэг 40 зүйл, тусгай анги 24 бүлэг 187 зүйлтэйгээр батлагдаж байсан^[105]. 1926 оны Шүүх цаазын бичиг төрөлжсөн Эрүүгийн хууль байгаагүй гэж үздэг бөгөөд “Улс төрийн явдалд холбогдох хэргийг таслан шийтгэх газрын түр дагаж явах дүрэм” үйлчилж эрүүгийн нэг эх сурвалж болж байсан гэж үздэг бөгөөд доктор /Sc.D/, профессор Г.Совд түүнийг хувьсгалт Эрүүгийн эрхийн дотоод томоохон нэг салбарын /төрийн эсрэг гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульчилсан/ хэм хэмжээг анх нэгтгэн тогтоосон хууль байсан гэж үздэг.

1929 оны Шүүх цаазын бичиг нь цоо шинэ бие даасан хууль биш бөгөөд 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ийн шинэчилсэн найруулсан хэлбэр гэж доктор Д.Адъяабазар тэмдэглэсэн байна. Харин 1929 оны Шүүх цаазын бичиг нь тухайн үед цорын ганц эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон хууль байсан. Тухайн үеийн нийгмийн байгуулал өөрчлөгдөж байсантай холбоотойгоор хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж байсан. Тухайлбал: 1929 оны Шүүх цаазны бичигт “Шашин суртлыг улс төрд хортойгоор хэрэглэх ба төр шашны хэргийг тусгаарласан хууль зөрчих нь” хэмээх 30 дугаар бүлгийг 1934 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Ардын сайд нарын зөвлөлийн 4 дүгээр хурлаар “Төр шашны тусгаарласан тухай хууль дүрэм зөрчих нь” гэж өөрчлөн найруулсан. Тус улсын аливаа сургуульд шашны ном заах, шашны явдалд албадан бадарлах, татвар хураах, шинээр дуган сүм барих, 18 нас хүрээгүй хүмүүсийг лам болгох, улсын ба олон нийтийн зэрэг албан ба үйлдвэрийн газруудад шашны ёслол явуулахаар лам нарыг урьж хурал ном үйлдүүлэх явдлыг гэмт хэрэг гэж үзэж ял шийтгэхээр Шүүх цаазын бичгийн 30 дугаар бүлгийн 223, 224, 226, 228 дугаар зүйлд нэмэлт оруулсан байна. Энэ нь шашны үйл ажиллагааг хумьж ард олныг мухар сүсэг бишрэлд автахгүй байх шашны нөлөөлөлөөс салгах бодлого хүчтэй өрнөж байсныг илэрхийлдэг. Лам нарыг үй олноор нь ардын засгийн үйл ажиллагаанд тэрсэлсэн хэмээн хороосон бөгөөд зарим нэг лам нар энгийн хүн буюу /хар/ болсон талаар түүхэн эх сурвалжуудад тэмдэглэсэн байдаг. 1929 оны Шүүх цаазыг бичигт оруулсан нэмэлтүүд нь тухайн үеийн нийгэм, улс төрийн байдал

¹⁰⁵ С. Жанцан Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. 2007 он. 50 дахь тал.

гарсан өөрчлөлт бүрийг тусгасан байх талтай. 1929 оны Шүүх цаазын бичиг нь 1934 онд өөрчлөгдөж хүчингүй болсон бөгөөд үүнийг Монголын эрт эдүгээгийн хууль цаазны түүхэн сэдэв дэвтэрт “...элдэв гэмт хэргүүдийг бүлэг бүрийг зохих зүйлүүдэд хутгалдуулан бичсэн, хувьсгалд тэрсэлсэн гэмт хэргүүдийг хэдэн бүлэг болгон бичсэнээс гадна аж ахуй ба албан тушаал, ялангуяа хурьцлын гэмт хэргүүдийн ялыг хөнгөн заасан зэрэг дутагдлууд гарсан...” гэж бичсэн байна.

1934 оны Шүүх цаазын бичгийн холбогдох бүлэг, зүйлд улс орны гадаад дотоод аюулгүй байдал, нийгэмд бий болсон бодит шаардлагын дагуу 1939 оныг дуустал удаа дараа зохих нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ. Тухайлбал: Сайд нарын зөвлөлийн 1936 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 57 дугаар тогтоолоор, Шүүх цаазны бичгийн 6 дугаар бүлгийн 128 дугаар зүйлд нэмэлт оруулан жирэмсэн эмэгтэйчүүдийн хүүхдийг санаатайгаар устгагчид, авагчид, авахуулагчид болон төрүүлсэн хүүхдээ хаяж орхигчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэх болов. Мөн Сайд нарын зөвлөлийн 1939 оны 2-р сарын 17-ны өдрийн “Феодалын үлдэгдэл ба ялангуяа үндэс угсааны өшөө хонзон хадгалах явдалтай тэмцэх арга хэмжээний тухай” тогтоолын заалтыг биелүүлэх үүднээс 1934 оны шүүх цаазын бичгийн тусгай ангид нэмэлт, өөрчлөлт оруулснаар олон эхнэр авах, эхнэр авахаар эцэг эх болон төрөл садан, бусад этгээдэд бэлэг сүй хүргэх, авах, эмэгтэйчүүдийг гэрлүүлэхээр албадан хавчих, хүслийн эсрэг гэрлүүлэх, дээр дурдсан зорилгоор эмэгтэйчүүдийг хулгайлах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцжээ^[106]. Нийгмийн өөрчлөлт хүчтэй байснаар Шүүх цаазын бичигт нэмэлт өөрчлөлт оруулж гэмт хэргийн тоог өргөжүүлж байсан байна. Энэ нь нийгмийн өөрчлөлт Эрүүгийн хуульд яаж нөлөөлж байгааг харуулж байгаа бөгөөд Эрүүгийн хуулийн эх сурвалжийн нэг төрөлд хуульчлагдсан аргууд хэрхэн байр суурьтай байсан нь судалгаанаас харагдаж байна.

Монгол Улсын нийгмийн амьдралд 1940-өөд оны үед ихээхэн өөрчлөлт гарч мөн оны 6 дугаар сард хуралдсан Улсын 8 дугаар их хурал шинэ Үндсэн хуулийг батлан гаргасан. Шинэ Үндсэн хуулийн дагуу тус улсын бусад хууль дүрмийг шинэчлэн боловсруулах ажил явагдаж Шүүх цаазны бичгийг 1942

¹⁰⁶ Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971. 52-56 дахь тал



оны 1 дүгээр сарын 17-нд Улсын 25 дугаар бага хурлаар Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа “БНМАУ-ын Эрүүгийн хууль” нэртэйгээр батлан гаргажээ. Энэ хуулиар нийгэм, төр, байгууллага, иргэдийн өргөн агуулгатай эрх ашиг, сонирхлыг илүүтэй тусгасан бөгөөд өмнөх хуулиудтай харьцуулбал тогтолцоо, бүтэцийн хувьд илүү боловсронгуй болсон гэж үздэг. Тухайн үеийн нийгмийн өөрчлөлттэй уяалдан зарим төрлийн гэмт хэрэг шинээр нэмэгдэж зарим гэмт хэрэг нийгэмд аюултай шинжээ алдсан, ач холбогдолгүй болсон гэж үзэн Эрүүгийн хуулиас хасагдсан. Эрүүгийн хуульд орсон томоохон өөрчлөлт нь тухайн үеийн төрийн бодлогыг хэрэгжүүлэх, ялангуяа улс хоршоолол, иргэдийн өмчийг хамгаалах, хууль ёсыг бэхжүүлэх, иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй байсан. Жишээлбэл: БНМАУ-ын ардын хувьсгалт төрийг буюу түүний арга хэмжээнүүдийг унагаах, бусниулах, сулруулахыг уриалсан, ухуулга ятгалга явуулах, улс төрийн зорилгоор худал цуурхал дэлгэрүүлэх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцов^[107]. Эрүүгийн хуулиас гадна эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон зарим хууль, тогтоол, зарлиг нэгэн адил үйлчилж байв. Тухайлбал: 1953 оны 8-р сарын 5-нд БНМАУ-ын Их хурлын тэргүүлэгчдээс гаргасан “Алах ялыг өөрчлөх тухай” зарлиг.

Эрүүгийн хуулийг 1961 оны 1 дүгээр сарын 31-нд БНМАУ-ын Ардын их хурлын 2 дугаар чуулганаар баталж, хуучин дагаж мөрдөж байсан 1942 оны Эрүүгийн хуулийг хүчингүй болгон улмаар мөн оны 4 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдсөн юм. Өмнөх Эрүүгийн хуульд хэд хэдэн үндсэн өөрчлөлт хийх шаардлагатай болсон бөгөөд уг хуулиар гэмт хэрэгт тооцогдож байсан зарим нийгмийн үзэгдлийг нийгэмд аюултай шинжээ алдсан гэдэг үндэслэлээр эрүүгийн хуулиас хасч, нийгэмд аюултай зарим үзэгдлийг шинээр гэмт хэрэгт тооцож эрүүгийн хуулинд нэмэлт оруулсан. Тухайлбал: “Төрөөс шашныг тусгаарлах тухай” хууль дүрэм зөрчих, “Ураг төрлийн ба феодалын байгууллын зан суртахууны үлдэгдэл болсон гэмт явдлуудын тухай” гэсэн 1942 оны эрүүгийн хуулийн тухай ангийн 5, 11 дүгээр бүлэг хасагдаж “Социалист өмчийн эсрэг гэмт хэргүүд”, “Социалист аж ахуйн эсрэг гэмт хэргүүд”, “Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт

¹⁰⁷ С.Жанцан Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. 2007 он. 50 дахь тал.

хэргүүд” гэсэн бүлгүүдийг эрүүгийн хуулинд шинээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна^[108]. Монгол Улс Эрүүгийн хуулиас гадна Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон хуульчилсан актуудыг баталдаг гажууд гэмээр практикаас татгалзаж, эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоо нь гагцхүү эрүүгийн хуулиас тогтох Эх газрын эрх зүйн бүлгийн жишигт бүрэн нийцэх болсон гэж доктор Г.Гантөмөр дүгнэсэн юм.

1961 оны Эрүүгийн хууль нь өмнөх хуультай харьцуулбал гэмт хэргүүдийг төрлийн объектоор нь илүү оновчтой системчилсэн ололттой талууд байгаа ч хүнийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, оршин суух газар, эрхлэх ажлаа сонгох, паспортын бүртгэлийг зөрчихийг гэмт хэрэгт тооцож хүний эрхийг хязгаарласан олон тооны хэм хэмжээ хуульд агуулагдаж байсан нь НҮБ-ийн хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаа, олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй илт зөрчилдөхөд хүргэж байв^[109]. Тус Эрүүгийн хууль үйлчилж байсан он жилүүдэд Монгол Улс нилээдгүй тооны олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон. Тухайлбал: Монгол Улс 1961 онд Нэгдсэн үндэсний байгууллагад нэгдэн орсоноор тус хуулийн 221-р зүйлд анх удаа Улаан загалмайн тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулж ашиглах гэмт хэргийг хуульчилсан. Хүснэгт 2-т харуулсан.

1961 оны Эрүүгийн хууль нь төрийн Эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл байсан боловч түүний олон хэм хэмжээ гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тухайн үеийн шаардлагад нийцэхгүй олон эрх ашиг эрүүгийн хуулийн гадуур үлдсэн хийдэл байсан учраас БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1986 оны 12-р сарын 5-ны өдрийн 217 зарлигаар шинэчлэн найруулж баталсан Эрүүгийн хууль үйлчлэх болсон. Энэ хуулийн гол онцлог бол гэмт хэргийн ангилалтыг бий болгож эрүүгийн хариуцлага хүлээлгэх оновчтой шийдэл болсон. Мөн Монгол Улс Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцид нэгдэн орсноор тус Эрүүгийн хуулинд шинэ гэмт хэрэг бий болох нөхцөл бүрэлдэж 269-р зүйлд Агаарын хөлгийг авч зугтаах гэмт

¹⁰⁸ Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил /1-дэвтэр/ УБ., 1998 он 149 дэх тал

¹⁰⁹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал. УБ., 2007. 78 дахь тал



хэрэг хуульчлагдсан байна.

1980-аад оны дунд үеэс Баруун Европын социалист тогтолцоотой зарим улсад Тухайлбал: ОХУ-д өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт, ил тод байдлын үзэл санааны нөлөө манай оронд хүчтэй нэвтэрч улмаар 1990 оны эхээр манай улсын нийгэм улс төр, эдийн засгийн хуучин тогтолцоог үндсээр нь өөрчилсөн ардчилсан хувьсгал ялах нөхцөл болсон^[10]. 1992 онд Үндсэн хууль шинээр батлагдаж тус хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн Эрүүгийн хуульд томоохон өөрчлөлтүүд орсон юм. Эдгээрээс дүгнэн тоймловол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр батлахад дараах нөхцлүүд шууд хамаардаг гэж үзэж байна. Үүнд:

- 1.Нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл байдал, төрийн байгуулал;
 - 2.Эрүүгийн хууль тогтоомжуудыг дэлхий нийтийн хүлээн зөвшөөрч буй зарчмуудад нийцүүлэх;
 - 3.Нийгэмд аюултай үйлдлийг болон ийм үйлдэл гарч болзошгүй гэж үзэж хуульчлах;
 - 4.Гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэмжээ хязгаар;
 - 5.Хүний эрх, эрх чөлөөг Эрүүгийн хуулиар хамгаалах асуудлыг илүү оновчтой болгох;
 - 6.Эрүүгийн хуулийн хэм хэмжээг Үндсэн хууль, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, эрх зүйн бусад баримт бичгүүдэд нийцүүлэх;
 - 7.Гэмт хэрэгт оногдуулах хариуцлага нь гэмт үйлдэлд нь тохирсон байх;
- Эдгээрийг баримтласнаар Эрүүгийн хуулийн чухал зорилт болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх нөхцөл хангагдана гэж үзэж байна.

Хүснэгт 2. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжын уламжлалд хийсэн шинжилгээ

№	Эрүүгийн хуулиуд	Монгол Улс Олон Улсын гэрээнд нэгдэн орсон гэрээнүүд	Уламжлалт гэмт хэрэг. /Хүний амьнас эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэг, дээрмийн гэмт хэрэг/	Нийгмийн өөрчлөлт, Шинжлэх ухаан технологийн нөлөөлөл	Нийт гэмт хэргийн тоо
1.	БНМАУ-ын Шүүх цаазны бичиг 1926 онд батлагдсан.		24, 25, 26, 30-р бүлгийн 32 гэмт хэрэг	Манжийн дарлалаас гарч Ардын Засгийн газрын бодлого хэрэгжиж эхэлсэн. Жнь: өмнө нь хэрэглэж байсан эрүү шүүлтийг хүчингүй болгох	Тусгай анги нь 24 бүлэг 187 зүйлтэй.
2.	БНМАУ-ын Шүүх цаазны бичиг 1929 онд батлагдсан.		22, 23, 30-р бүлгийн 30 гэмт хэрэг Хувьсгалын эсэргүү 12 гэмт хэрэг нэмэгдсэн.	Шашны ном заах, шашны явдалд албадан бадарлах, татвар хураах, шинээр дугана сүм барих зэргийг гэмт хэрэгт тооцохоор нэмэлт оруулсан байна.	Тусгай анги нь 23 бүлэг 186 зүйлтэй.
3.	БНМАУ-ын Шүүх цаазны бичиг 1934 онд батлагдсан. ¹⁴		6, 7-р бүлгийн 27 гэмт хэрэг Мал хулгайлах гэмт хэргийг биеэ даасан гэмт хэрэг болгож тэврийн жолооч дүрэм заавар зөрчих гэмт хэрэгт ял оногдуулахаар заасан. Цэргийн 19 гэмт хэрэг бий болсон.	Цэргийн гэмт хэрэг, эдийн засгийн шинжтэй гэмт хэрэг, жирэмсэн эмэгтэйчүүдийн хүүхдийг санаатайгаар устгагчид, авагчид, авхуулагчдад ял оногдуулахаар тусгай ангид оруулж өгсөн	Тусгай анги нь 9 бүлэг 132 зүйлтэй.

110

С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал. УБ., 2007. 82 дахь тал



4.	БНМАУ - ын 1942 оны Эрүүгийн хууль ¹⁵		7,8-р бүлгийн 45 гэмт хэрэг Ураг төрлийн ба феодалын байгууллагын зан суртахууны үлдэгдэл болсон 6 гэмт хэрэг нэмэгдсэн.	Энэ үед нийгэмд нилээн өөрчлөлт гарсан. Эрүүгийн хууль нэрээр анх удаа батлагджээ.	Тусгай анги 11 бүлэг 170 зүйлтэй.
5.	БНМАУ - ын 1961 оны Эрүүгийн хууль ¹⁶	НҮБ - ын дүрэм ¹⁷	3, 5, 10-р бүлэг 37 гэмт хэрэг Төрөөс шашныг тусгаарлах тухай хууль, дүрэм зөрчих гэмт хэрэг, Ураг төрлийн ба феодалын байгууллагын зан суртахууны үзэгдэл болсон гэмт хэргүүд хасагдсан. Шинээр 23 гэмт хэрэг нэмэгдсэн.	Зарим гэмт хэрэг гэмт хэргийн шинжээ алдаж шинээр Социалист өмчийн эсрэг гэмт хэргүүд, Социалист аж ахуйн эсэрг гэмт хэрэг нэмэгдсэн байна. Улаан загалмайн тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулан ашиглах гэмт хэрэг нэмэгдсэн.	11 бүлэг 176 зүйлтэй.
6.	1964, 1966, 1967, 1974, 1980, 1983 онуудад БНМАУ-ын Эрүүгийн хуулийн зарим зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.	Нийт олон улсын 7 гэрээнд нэгдэж орсон ¹⁸	Социалист өмчийн эд хөрөнгийг хүндрүүлж үзэх, тээврийн хэрэгслийн аваар осолд оногдуулах ялыг хүндрүүлсэн.	Эрүүгийн ялын зарим институтэд ялыг чангалахаар заасан.	
7.	БНМАУ-ын шинэчлэн найруулсан 1987 оны Эрүүгийн хууль ¹⁹	Нийт олон улсын 3 гэрээнд нэгдэж орсон ²⁰	3,4,5-р бүлэг 49 гэмт хэрэг 7,12 бүлэгт 20 гэмт хэрэг нэмэгдсэн.	Байгаль орчин, түүний баялыг хамгаалах журмын эсрэг хөдөлмөрийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг хэмээх 2 бүлэг нэмэгдсэн.	13 бүлэг 240 зүйлтэй
8.	1993, 1996, 1997, 1998, 1999, 2000 онуудад Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.	Нийт олон улсын 5 гэрээнд нэгдэж орсон ²¹	Хуучин 35 гэмт хэргийг хүчингүй болгож шинээр 21 гэмт хэргийг нэмэж оруулсан байна.	Улс төрийн ардчилсан дэглэмтэй хүний эрхийг эрхэмлэн дээдэлсэн төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой эрх зүйт төрийн бодлогыг хэрэгжүүлсэн. Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай хэм хэмжээг оруулсан.	



9.	2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль.	нийт олон улсын 11 гэрээнд нэгдэж орсон ²²	15, 16, 17, 19-р бүлэг 51 гэмт хэрэг 25, 30-р бүлэг шинээр нэмэгдсэн, албан тушаалын гэмт хэрэгт мөнгө угаах гэмт хэрэг нэмэгдсэн.	Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Хүн төрөлхтөний аюулгүй байдал энх тайвны эсрэг гэмт хэрэг	17 бүлэг 226 зүйлтэй.
10.	Эрүүгийн хууль 2015 оны 12 сарын 03-ны өдөр батлагдсан.		49 гэмт хэрэг шинээр нэмэгдсэн.	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, Авлигын гэмт хэрэг, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэргүүд хуульчлагдсан.	30 бүлэгтэй 2017 оны 07 сарын 01-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Дүгнэлт

1.Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэйгээ холбогдуулж 1961 оноос эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл олон улсын гэрээ, конвенцын нөлөөлөлөөр 80 гаруй гэмт хэрэг шинээр нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.

2.Эрүүгийн хуулийн нийт гэмт хэргийн 25 гаруй хувьд олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний нөлөөлөл байна гэж үзэж байна.

3.Нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөлт, шинжлэх ухаан технологийн хөгжилтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн хэм хэмжээнд өөрчлөлт гардаг болох нь судалгаагаар харагдаж байна.

4.Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хууль тогтоомжид нийт гэмт хэргийн 75 хувь нь уламжлагдан ирсэн байна.

Эдгээрээс дүгнээд дараах санал дэвшүүлж байна.

1.Эрүүгийн хууль тогтоомжид судалгаа шинжилгээ хийх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх явцад эрүүгийн эрх зүйн суурь онолыг хөндөхгүй байх.

2.Харин эрүүгийн эрх зүйн институтийн онолыг судлаж, эрх зүйн шинэчлэл, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглах нь үр дүнтэй гэж үзэж байна.

3.Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд Монгол Улсад олон улсын эрүүгийн эрх зүйг хөгжүүлэх, судалгааны чиглэлийг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.



ТОРГОХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ж.Баасанжав

ИЗОУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн хөтөлбөрийн багш, магистр

Түлхүүр үг: Эрүүгийн хууль, торгох ял, шийтгэх тогтоол, эрх зүйн шинэчлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.

Хураангуй: Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу торгох ял оногдуулах үед шүүн таслах ажиллагаан дахь хууль хэрэглээний асуудал, торгох ялын биелэлт, гэмт хэрэг болон гэм буруутай этгээдийн хувийн байдалд тохирсон эрүүгийн хариуцлага оногдуулах нь ялын биелэлттэй хамааралтай тул хууль тогтоомжийн холбогдох заалтыг цаашид боловсронгуй болгох шаардлага үүсч байна.

Торгох ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нэгжтэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ялын цээрлэл нь ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлах замаар түүнд эдийн засгийн дарамт ачаалал таагүй үр дагавараар нөлөөлж эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр мөнгөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр албадан төрийн өмчлөлд шилжүүлж байгаагаар илэрдэг. Торгох ялын хэмжээ 100 нэгжээс 40000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. Торгох ял нь:

Нэг Удаа оногдуулдаг.

Шүүгдэгчийн эдийн засгийн болон эд хөрөнгийн эрх, ашиг сонирхолыг хөнддөг харин бусад эрх, эрх чөлөөнд ямар нэг хязгаарлалт тогтоодоггүй.

Тэнсэж болдоггүй

Шүүх торгох ялыг 3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болдог.

Хэрэв шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоногоор тооцож хорих ялаар солидог зэрэг онцлогтой.

Монгол Улсын хууль цаазын их өв уламжлалд эд хөрөнгийн шинжтэй эрүүгийн хариуцлагын талаар хэрхэн зохицуулсан байдлыг судлаж үзэхэд Их засаг хууль, Их Юань гүрний нэвтэрхий хууль, Монгол Ойрадын хууль, Халх журам, Монгол зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт есөөр торгох, ор босгох, малаар торгох зэрэг

эд хөрөнгийн шинжтэй торгуулийн ялыг оногдуулж байжээ. 1926 оноос Шүүх цаазын бичигт эдийн засгийн хэмжигдэхүүн болох мөнгөн төлбөрийн хэлбэрээр торгуулийн хэмжээг 50-1800 төгрөг, 1942 оны Эрүүгийн хуульд 200-1000 төгрөг, 1986 оны Эрүүгийн хуульд 1500-2250 төгрөг тусгай ангид заасан бол 5000 хүртэл төгрөг, 1993 оны нэмэлт өөрчлөлтөөр 2000-250000 төгрөг тусгай ангид заасан тохиолдолд 500000 төгрөг хүртэл торгох ял оногдуулахаар заасан байна. Харин 2002 оны Эрүүгийн хуулиар торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэгдэх үеийн Засгийн газрын тогтоолоор батлагдсан 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тогтоосон байна. Гэвч 2000 оноос хойш өнөөдрийг хүртэл Засгийн газрын шийдвэрийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 12 удаа шинэчлэгдэн тогтоогдсоны улмаас торгох ялын хэмжээ тухай бүр өөрчлөгддөг байж.

2015 оны Эрүүгийн хуулиар торгох ялыг тооцох нэгжийн хэмжээг 1000 төгрөгөөр хатуу тогтоож, гэмт хэрэг үйлдсэн хүнд 100-40.000 нэгжтэй, хуулийн этгээдэд 10.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн торгууль оногдуулж болохоор хуульчилсан ба цаашид нэгжийн хэмжээг өөрчлөх эрхийг эдийн засгийн байдлыг харгалзан хууль санаачлах эрх бүхий этгээд санаачилсны дагуу хууль тогтоогч буюу Улсын Их хурал эдлэхээр зохицуулалт хийсэн байна.

Ял шийтгэлийн бодлого нь гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй, харин бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, хийдэлгүй байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой байдаг тул ял шийтгэлийн төрлийг өөрчлөх, нэмж хассан нь чухал бус харин ялын дээд, доод хэмжээ, тэдгээрийн тохироо, ялаас чөлөөлөх, хөнгөрүүлж оногдуулах үндэслэл, журам оновчтой байх болон тухайн ялыг хэрэгжүүлэх бүх талын бодит боломж буюу ялын хэрэгжилт, үр нөлөө л хамгийн чухал шалгуур болдог.

Монгол Улсын 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд зааснаар торгох ялыг хуулийн этгээд, гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулахаар заасан байна. Монгол Улсын хувьд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал хуульчлагдсан байдал нь 2002 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар эхэлсэн гэж үзэх




үндэслэлтэй бөгөөд 2002 онд 2 төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага буюу торгох ял оногдуулахаар заажээ.

Хүснэгт 1 / үХүМонгол Улсын анхан шатны эрүүгийн шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг 2011-2017 оны 3 дугаар улирлын байдлаар/

№	Төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017 оны 3 дугаар улирал
	Нийт ял шийтгүүлсэн хүмүүсийн тоо	8210	8324	7943	8178	7696	6566	6302
1	Торгох ял шийтгүүлсэн хүний тоо	271	272	295	285	370	216	956
2	Нийт ялд эзлэх хувь	3.3	3.2	3.7	3.4	4.8	3.2	15.1

Хүснэгт 2 /Торгох ял оногдуулалтын байдал/


2011-2016 оны хооронд 46917 хүн ял шийтгүүлснээс нийт ял шийтгүүлэгчдийн дийлэнх



буюу 75.3 хувь буюу 36110 хүн хорих ялаар, 12.3 хувь буюу 5774 хүн баривчлах ялаар тус тус шийтгүүлсэн нь манай улсын хувьд нийгмээс тусгаарласан, хорих төрлийн ял шийтгэлүүд дийлэнх хувийг эзэлж байгаа нь хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн оногдуулалт хангалтгүй байжээ гэж үзэх үндэслэлтэй байна. Энэ судалгаанаас үзэхэд торгох ял нь үеийн Эрүүгийн хууль тогтоомжинд өөрчлөгдөн зохицуулагдан ирсэн ч шүүхээс торгох ялаар шийтгүүлэгчдийн тоо бусад ялаар шийтгүүлэгчидтэй харьцуулахад ялын зорилгод нийцэхүйц хэмжээнд хүрэхгүй, бусад ял шийтгэлтэй харьцуулахад маш бага хувийг эзэлж байсан байна. Харин 2017 оны 3 дугаар улирлын байдлаар анхан шатны шүүхээр нийт 6302 хүн ял шийтгүүлснээс 63.7 хувь буюу 4016 хүнд хорих ял, 15.2 хувь буюу 956 хүнд торгох ял, 4 хувь буюу 250 хүнд албадан ажил хийлгэх ял, 7.8 хувь буюу 489 хүнд баривчлах ял тус тус оногдуулж, насанд хүрээгүй 129 этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, 9 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хорих ялаар шийтгүүлсэн хүний тоо 4.1 хувиар, торгох ялаар шийтгүүлсэн хүний тоо 6.4 дахин өссөн бол албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоо 12 хувиар, баривчлах ялаар шийтгүүлсэн хүний тоо 13.8 хувиар тус тус буурсан байна. Ял шийтгүүлэгчдийн дунд эзлэх хувиараа албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоо 1.8 хувиар, баривчлах ял шийтгүүлсэн хүний тоо 3.8 хувиар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 15 хувиар тус тус буурсан бол торгох ялаар шийтгүүлсэн хүний тоо 12.1 хувиар өссөн дүнтэй гарсан байна.^[11]

¹¹ Монгол Улсын шүүхийн 2017 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ



Дүгнэлт, санал

Торгох ял нь эрх зүйн зохицуулалтын хувьд эрүүгийн уламжлалт хууль тогтоомжуудад зохицуулагдан өнгөрсөн түүхийн цаг хугацаанд баяжигдан шинэчлэгдэж ирсэн ялын үндсэн төрлийн нэг юм. Торгох ялын цэрлэл нь ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлах замаар түүнд эдийн засгийн дарамт ачаалал, үр дагавараар нөлөөлж эргэж төлөгдөлгүйгээр мөнгөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр албадан төрийн өмчлөлд шилжүүлж байгаагаар илэрдэг. Шүүхийн практикт торгох ялын оногдуулалт бага байгаа гол шалтгаан нь ял шийтгүүлэгчдийн эдийн засгийн байдал, боловсрол, ажил эрхлэлт, төлбөрийн чадвар нөлөөлөхөөс гадна өмнө оногдуулсан торгох ялын биелэлтийн байдал, удаа дараа батлан гаргасан Өршөөл үзүүлэх тухай хуулиуд нөлөөлж байна гэж үзэж байна.

Харин 2015 оны Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулиуд батлагдан гарсантай холбоотойгоор торгох ял оногдуулалтын байдал өсөх хандлагатай байгаа нь 2015 оны хуулиар торгох ялтай холбоотой шинэ зохицуулалтууд үйлчилж эхэлсэн мөн хуулийн этгээдэд торгох ял оногдуулж болох болсонтой холбоотойгоор эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, хяналт тавих, шүүхээр шийдвэрлэх, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч байгаа юм. Иймд

Санал

1. Торгох ялыг 3 жил хүртэлх хугацаанд хэсэгчлэн төлж болохоор заасан нь өмнөх

Эрүүгийн хуультай харьцуулахад ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлсэн боловч уг хугацааг тогтоохдоо ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзах учраас мөрдөн байцаалтын шатанд эдгээр асуудлыг заавал тогтоох арга ажиллагааг тусгайлан зааж өгөх,

2. Торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол төлөөгүй үлдсэн ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоноогоор тооцож хорих ялаар солино гэж заасан нь эдлээгүй ялыг дүйцүүлэхээр байгаа бөгөөд биелэгдээгүй торгох ялын хэмжээнээс хамаарч Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг тухайн зүйлд заасан хорих ялын доод хэмжээ буюу 6 сараас доогуур хорих ял оногдуулах боломжтой байх тул энэ тохиолдолд хорихоос өөр төрлийн буюу нийтэд тустай ажил хийлгэх ялаар солих талаар зохицуулах

3. Эрүүгийн хуулиар торгох ялыг 3 жил хүртэлх хугацаанд хэсэгчлэн төлөх боломжийг шүүхээс тогтоож өгөхөөр зохицуулсан ч шүүхээс тогтоосон хугацаа дуусах хүртэл огт төлөлт хийхгүй байгаа тохиолдолд торгох ялыг биелүүлээгүй гэж үзэх эсэх талаар тодорхой зохицуулаагүй байна. Өөрөөр хэлбэл шүүхээс тогтоосон хугацаа дууссаны дараа торгох ял биелэгдсэн эсэхийг тооцож үзэх, эсхүл тухайн хугацааны дотор огт төлөлт хийхгүй байгаа буюу хэсэгчлэн төлөхгүй байгаа тохиолдолд торгох ялыг биелүүлээгүй гэж үзэн хорих ялаар солих боломжтой эсэх нь тодорхойгүй байх тул энэ талаар зохицуулалт оруулах

4. Хуулийн этгээдэд оногдуулсан торгох



ялыг хэсэгчлэн төлүүлэхээр хугацаа тогтоох талаар хуульд заагаагүй бөгөөд торгох ялыг биелүүлээгүй тохиолдолд түүнийг хорих ялаар солих журмыг хэрэглэх боломжгүй байх тул эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Ном зүй

- 1.Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- 2.Эрүүгийн хууль, 2002 он
- 3.Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2017 он
- 4.Зөрлийн тухай хууль, 2016 он
- 5.С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009 он
- 6.С.Нарангэрэл. Эрүүгийн эрх зүйн гарын авлага. УБ., 2007 он
- 7.Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ., 2004 он
- 8.Б.Галдаа. Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл. УБ., 2012 он
- 9.С.Жанцан . Ялын тухай сургаал 2 боть УБ 2014 он, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүйн онол

В.Вэб сайтууд:

- 1.Judge.mn /Монголын шүүгчдийн холбооны албан ёсны сайт/
- 2.Jud institute.mn /Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Судалгаа мэдээллийн хүрээлэнгийн албан ёсны сайт
- 3.Shuukh.mn /Бүх шатны шүүхийн шийдвэр тогтоолын байрших сайт /
4. bkhs-criminalcourt.gov.mn



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС ГАВ ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Албаны тусгай бэлтгэлийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгслийн төрөлд хамаарах гавыг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, хэрэглэх арга аргачлал, анхаарвал зохих асуудлын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Үндэслэл, хэрэглэх, арга, аргачлал, гав

Abstract: This research deals with studying the rules and regulations on the ways, methods and concerning issues of using handcuff, a type of special equipment, in police service for fighting against crimes, maintaining public order and providing public security.

Key words; background, use, ways, methods, handcuff

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэхдээ бусдын хөдөлгөөнийг хорих, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, эсэрүүцэл довтолгооныг таслан зогсоох зорилгоор нэг бүрийн тусгай хэрэгслийн төрөл болох гавыг холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэл, аргачлалын дагуу албаны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Цагдаагийн алба хаагч энэ хууль заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.^[112]

Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд тэдгээрийг хууль тогтоомжид заасны

дагуу хэрэглэнэ.^[113] гэж тус тус тусгайлан зааж өгсөн байна.

“Монгол хэлний товч тайлбар толь бичиг”^[114]-т гав гэдэг үгийн утгыг: Урьдын цагт ялт хүний хоёр гарын бугуйгаар холбож агдлах төмөр хэрэглэл, гарт нь гав торгож, хүзүүнд нь дөнгө өмсгө ...гэж тайлбарлажээ.

Өнөөдөр цагдаагийн албанд дараах төрлийн гавыг цагдаагийн төрөл мэргэжлийн алба нь өөрийн үйл ажиллагааны онцлог нөхцөл байдлаас шалтгаалж ашиглаж байна. Үүнд:

- Гарны гав /бугуй/
- Хөлийн гав / хөлийн нарийн шилбээр эсхүл өвдөгний дээгүүр тушах /
- Хурууны гав /эрхий хуруу/
- Нэг удаагийн гав
- Гарны гав /бугуй/
- Хурууны гав /эрхий хуруу/

Цагдаагийн алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа гавыг хэрэглэх тохиолдол түгээмэл байдаг бөгөөд түүнийг хэрэглэх тал дээр тодорхой аргачлал болон дадал, үр чадварыг тухайн алба хаагч нь эзэмшсэн байвал зохино.

Өөрөөр хэлбэл нэг талаас холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэл журам, аргачлалыг зөв баримтлан ажиллах нөгөө талаас гавыг хэрэглэх үр чадвар, дадлыг эзэмших зорилгоор тусгайлсан сургалт дадлагыг хийсэн байх шаардлагатай юм.

Цагдаагийн албанд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хэрэглэх ажиллагаа нь тухайн этгээдийн үйл ажиллагааг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй үед албадлагын тусгай шинж чанартай онцгой арга хэмжээ юм.

Иймд алба хаагчаас албадлагын арга хэмжээг зөв зохистой хуулийн хүрээнд хэрэглэх, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүй байхаас урьдчилан сэргийлэх, эрхээ хэтрүүлэн хэрэглэхгүй байх зорилтыг хангах үндсэн зарчмыг баримтлан ажиллах талаар дотоодын эрх зүйн актанд тусгайлан зааж өгсөн байна.

Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор бусад эрх зүйн дэд актуудад шинэчлэл хийгдсэн. Энэхүү

¹¹³ Цагдаагийн албаны тухай хуулийн 6-р бүлгийн 60-р зүйлийн 60.1 дэх хэсэг

¹¹⁴ Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь., УБ хот., 1966 он., 136 дахь тал

¹¹² Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 47-р зүйлийн 47.1 дэх хэсэг



ажлын хүрээнд цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар шинэлэгдэн батлагдсан байна.

Тухайлбал: Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг, хэрэглэх зааврыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.^[115] гэжээ.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаал^[116]-ыг цагдаагийн байгууллага, алба хаагч нь алба, үйл ажиллагаандаа шаардлагатай нөхцөл байдал бий болсон үед баримтлан мөрдлөг болгон ажиллаж байна.

“Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-т алба хаагч нь гавыг хэрхэн яаж, ямар арга хэлбэрийг сонгож хэрэглэх, ямар зүйл дээр анхаарч ажиллах гэх зэрэг алба хаагчийн үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлж зааглаж өгсөн заалт хэсгийг тусгайлан оруулсан байна.

Тухайлбал: Гавны бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг шалгах ажлын хүрээнд доорхи заалтыг баримтлан гүйцэтгэхээр тусгагдсан байна. Үүнд:

- 2 цагираг, бугуйвч чөлөөтэй эргэж байгаа эсэх

- Цагираг, бугуйвчийн зуух төхөөрөмж бүрэн бүтэн байгаа эсэх

- Түлхүүрийг хийж, цагийн зүүний эсрэг болон цагийн зүүний дагуу эргүүлж, цоожлогч бүрэн бүтэн байгаа эсэх зэргийг тус тус шалгаж үзнэ гэжээ.^[117]

Өөрөөр хэлбэл тухайн этгээдэд хэрэглэх гав нь дээр дурдсан шалгуурыг хангасан эвдрэл, гэмтэл, гацаагүй хэвийн ажиллагаатай байхыг үндсэн шаардлага болгож анхааруулсан байна.

Цагдаагийн алба хаагч нь ямар төрлийн гавыг ашиглаж байгаагаас хамаарч тухайн гавыг дараах аргаар хэрэглэсэн байвал зохистой юм^[118]. Үүнд:

- Хурууны гавыг эрхий хурууны 1-р үений хойд хэсгээр, хоёр эрхий хурууг хооронд нь буюу 2 хүний эрхий хурууг хооронд холбож

¹¹⁵ Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 47-р зүйлийн 47.4 дэх хэсэг

¹¹⁶ ХЗДХС, УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдөр баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

¹¹⁷ “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.5 дахь заалт

¹¹⁸ Чулуун.Ш., “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”, УБ хот., 2015 он., 144 дэх тал

биений урд нь ба ард нь гавлаж болно.

- Гарны гавыг 2 гарын бугуйн хэсгээр хооронд нь буюу өөр хүнтэй гавлаж болно. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх үед гарыг нь өөртэйгөө холбон гавлаж болох бөгөөд тээвэрлэх үед гар буюу хөлийг нь авто машины суудал, тэвш, бусад эд зүйлтэй холбон гавлаж болно.

- Хөлний гавыг хөлний нарийн шилбээр хөлийг хооронд нь буюу 2 хүний хөлийг холбон гавлаж болно. Мөн үл хөдлөх зүйлээс холбон гавлаж болно.

Хэдийгээр яг ийм зүйлд хүнийг гавлаж болно, болохгүй гэж тодорхой зааж өгөх нь хүндрэлтэй боловч таны хүнлэг зан чанар, хууль, журамд нийцүүлэн орчноо зөв мэдрэн юунаас, ямар хугацаанд гавлах вэ гэдгээ зөв мэдрэмжтэй сонгох шаардлагатай болдог.

Хамгийн гол нь нэгэнт гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргасан, орчин тойрондоо буюу нийгэмд аюултай, эсвэл оргон зайлах үндэслэлтэй байвал та гав хэрэглэх хэрэгтэй.

Тэгэхдээ аль болох ойр ойрхон шалгаж, гар нь түлэгдэх, хайрагдах, холгох, шигдэж орох зэргийг урьдчилан тооцсон байх хэрэгтэй. Зарим тохиолдолд цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн байж болох сэжигтэй этгээдийг төрийн байгууллагад хүргэх явцдаа удаан хугацаанд, чанга гавласнаас болоод хүний гар хөхөрч гэмтэх явдал гардаг.

Мөн гавтай хүнийг түр хугацаагаар орхихдоо хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахааргүйгээр үл хөдлөх зүйлээс гавлаж болно. Ингэхдээ алба хаагч нь тухайн этгээдийн үйл хөдлөл, ажиллагаанд хяналт тавьсан байх шаардлагатай юм.

Цагдаагийн алба хаагч нь дотоодын эрх зүйн актанд заасан бүх төрлийн гавыг хэрэглэхдээ өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, холбогдох хууль болон зааврыг баримталж ажиллах, эрхээ хэтрүүлэхгүй байх зорилгоор дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж мөрдөж ажиллавал зохино.^[119] Тухайлбал:

- Хүйтний улиралд хуруу болон гарны гавыг хэрэглэхдээ хүний биеийн ил хэсэг хайрагдахаас болгоомжлох /Ханцуй болон бээлийний гадна талаар жийрэглэсэн байдлаар хэрэглэх/

- Гав хүний биед шигдэж орох, чангарах зэргийг анзаарч хянаж байх /Хэдийгээр таны гав бүрэн бүтэн ажиллагаатай боловч

¹¹⁹ Чулуун.Ш., “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”, УБ хот., 2015 он., 146-147 дахь тал



гавласан хүнээ хяналтгүй, шалгах ажиллагааг удаан хугацаанд хийгээгүй, мөн тухайн өрөө тасалгааны температур, байгаль цаг агаарын байдал гэх зэрэг нөхцлийг тооцож үзэх /

- Гав хэрэглэхдээ заавал түгжиж хэрэглэх / Тухайн этгээдийн бугуйнд гавыг тохируулах, зориулалтын түлхүүрээр түгжих, түгжсэний дараа түлхүүрийг салган авч гавны цагираг, бугуйвч дээр дарж шалгах/

- Хүнийг тээврийн хэрэгсэл дотор холбож гавлахдаа донсолгоонд татагдаж гэмтэхээс сэргийлэх /Холбож гавлах хэсэг, орчин нөхцлөө зөв тооцох/

- Сэжигтэн буюу яллагдагчийг гавлаад дагуулж явахдаа урд нь ба чанх ард нь явж болохгүй зөвхөн баруун зүүн хажууд нь эсвэл баруун хойно нь буюу зүүн хойно нь явах. Аль болохоор аль нэг гараас нь барьж зугатаах болон бүдэрч унахаас хамгаалж явах /Нэг талаас алба хаагч өөрийн аюулгүй байдлаа хангах нөгөө талаас тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндийг учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх/

- Гавтай этгээд өөрөө гаваа чангалж судаснуудыг боож үхжүүлдэг тул анхаарч байх гэх мэт /Гав хэрэглэсэн тохиолдолд алба хаагчийн хяналтанд байх шаардлагатай/

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн хэмжээнд алба хаагчдын дунд “Цагдаагийн байгууллагын техник, тусгай хэрэгслийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал” судалгааны ажлыг хийсэн бөгөөд алба хаагчдыг нэг бүрийн тусгай хэрэгслээр хэрхэн хангагдсан талаар судалгаа хийсэн байна. Тус судалгаанд 4065 алба хаагч оролцож өөрийн санал хүсэлтээ хуваалцсан байна.

Нэг бүрийн тусгай хэрэгслийн төрөл болох гавны хангалт, ашиглалтын талаар алба хаагчдаас судалгаа хийхэд доорхи хариултыг өгсөн байна.^[120]

1. Байгаа, ашигладаг- 2304 хүн 56,7%
2. Байгаа боловч хэрэглэдэггүй- 296 хүн 7,3%
1. Элэгдэж муудсан, эвдэрсэн- 163 хүн 4%
2. Алдаж гэсэн- 12 хүн 0,3%
3. Огт байхгүй- 669 хүн 16,5%
4. Шаардлага хангадаггүй- 58 хүн 1,4%
5. Өөрөө олж авсан- 125 хүн 3,1%
6. Хангалт аваагүй- 242 хүн 6%
7. Хэрэглэх шаардлагагүй-196 хүн 4,8%

Жагсаал цуглаан, жагсаал цуглааныг
¹²⁰ “Цагдаагийн байгууллагын техник, тусгай хэрэгслийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал” судалгааны ажлын тайлан 2012 он

албадан тараах, нийтийг хамарсан арга хэмжээ, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагааны үед гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг баривчлан саатуулах, хууль тогтоомж зөрчиж хууль бус үйл ажиллагаанд оролцсон аливаа хүний хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор нэг удаагийн тусгай зориулалтын хуванцар пластмасан эдлэлээр хийгдсэн гавыг хэрэглэх нь илүү тохиромжтой үр дүнтэй, эерэг арга хэмжээ болох юм.

Учир нь тухайн нөхцөлд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдаг тул олон хүний хөдөлгөөнийг түргэн шуурхай хугацаанд хязгаарлах, мөн тухайн этгээдэд уг гавыг хэрэглэх нь аюулгүй байдлыг найдвартай хангах бололцоог бий болгож өгдгөөрөө чухал ач холбогдолтой юм.

Өөрөөр хэлбэл тухайн этгээдэд тус гавыг хэрэглэснээр бие, эрхтэнд ямар нэг гэмтэл учруулахгүй байх, сөрөг үр дагавар гарахгүй байх нөхцлийг бүрдүүлж өгдөг байна.

Мөн алба хаагчийн албан тушаал, ажил үүргийн онцлогоос хамааралтайгаар гавны эдэлгээний хугацааг ялгамжтай байдлаар тогтоож өгөх шаардлагатай байна.

Учир нь манай улс дотооддоо тусгай хэрэгслийг үйлдвэрлэдэггүй гадаад улсаас импортоор оруулж ирдэг. Ингэхдээ гол төлөв манай урд хөрш болох БНХАУ-аас тусгай хэрэгслийг ялангуяа алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа гав, бороохойг оруулж ирэн төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хангалтаар тараан өгч байна.

Алба хаагчдад тавьж олгосон гавны материал нь чанарын шаардлага хангахгүйгээс гавны араа шүд амархан элэгдэж гацах, эвдрэх, түлхүүр нь хугарах, толгой нь элэгдэх гэх зэрэг нийтлэг зөрчил гарч байна.

Эвдрэл, гэмтэл гацаатай гавыг алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ хэрэглэснээс хүний бие, эрхтэнд гэмтэл учруулах ингэснээр гэмт хэрэг, зөрчилд холбогдон хариуцлагад татагдах нөхцөл бий болох боломжийг бүрдүүлж байна.

Иймд цагдаагийн албаны тухай хуульд заасан үндсэн чиг үүргийг шууд гүйцэтгэх алба хаагчдын гавны бүрэн бүтэн байдал, ашиглалтын үйл ажиллагаанд эрх бүхий шууд захирах албан тушаалтан үзлэг шалгалтыг тухай бүр хийж үүний үндсэн дээр холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.



Нөгөө талаас алба хаагчдад энэ чиглэлийн албаны сургалтыг эрх бүхий байгууллага, нэгж, албан тушаалтан тогтсон хугацаанд үр дүнтэй зохион байгуулж явуулан онолын зохих мэдлэг болон хэрэглэх ур чадвар, дадал эзэмшүүлэх боломжийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндсэн чиг үүргийг шууд гүйцэтгэж буй алба хаагч нарт гавны хангалтыг тухай бүр хийх, тавьж олгож буй гавны чанар, стандарт, эдэлгээний хугацаан дээр цаашид анхаарч ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Санал

- Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдад тавьж олгосон гавны тооцоо, судалгаа, бүртгэлийг нэгтгэн гаргаж энэ чиглэлийн ажил хариуцсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан нэгдсэн хангалтыг хийж алба хаагчийн ажил үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх

- Алба хаагчдад харъяа нэгж, салбарын сургалт хариуцсан албан тушаалтан сургалтыг тухай бүр үр дүнтэй зохион байгуулах, ингэснээр алба хаагчийн тусгай хэрэгсэл хэрэглэх ур чадвар сайжрах

- Гавны эдэлгээний хугацааг алба хаагчийн эрхэлж байгаа албан тушаал, ажил үүргийн онцлогоос хамаарч ялгамжтай байдлаар тогтоож өгөх

- Гавны материаллын чанарт онцгой анхаарах, олон улсын жишиг стандартад нийцсэн шаардлага хангасан гавыг албаны үйл ажиллагаанд ашиглах

Ном зүй

1. Цагдаагийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/ 2017.02.09.

2. ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдөр баталсан А-224/А-102 тоот тушаал “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

3. Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь бичиг., УБ хот., 1966 он

4. Чулуун.Ш., “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”., УБ хот., 2015 он

5. Цагдаагийн байгууллагын техник, тусгай хэрэгслийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал” судалгааны ажлын тайлан УБ хот 2012 он

6. Аминд халгүй зэвсэг-2010 сургалт / Зэвсэгт хүчний жанжин штаб, АНУ-ын тэнгисийн явган цэргийн сургагч багш нарын хамтарсан/



ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХИЙГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТОЙМ

Г.Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЭТ-ийн ахлах багш, цагдаагийн хошууч

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1948 оны 12 дугаар сарын 10-нд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлан гаргаснаар дэлхийн улсууд нийгэм, эдийн засгийн ямар байгуулалтайгаас шалтгаалахгүй хүний эрхийг хангаж хамгаалах салбарт хамтран ажиллах боломжийг нээсэн олон улсын харилцааны онцгой үйл явц болсон байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал бол олон улсын харилцаанд бүх нийтээрээ сахин биелүүлэх хүний үндсэн эрх, эрх чөлөөний хүрээг дэлхийд анх удаа тодорхойлсон олон улсын эрх зүйн хэм хэмжээ билээ.

Улс үндэстний тусгаар тогтнолоо олж авсан, өөрийн орны баялаг, нөөц, бололцоогоо чөлөөтэй ашиглах эрхтэй байх, хүн бүрийг тэгш эрхээр хангах, харилцан ашигтай гадаад харилцааны орчныг бүрдүүлсэн байх, хууль эрх зүйн иж бүрэн тогтолцоо бүрдүүлэх асуудлууд нь цогц байдлаар шийдвэрлэгдсэн үед хүний эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бий болсон гэж үзэж болох бөгөөд тэрхүү эрхийг хэрэгжүүлэхийн тулд бүрэлдэн тогтсон нөхцлүүдийг ашиглах талаар юуны өмнө иргэдийн санаачлага, эрхээ хамгаалахын төлөө тэмцэх үйл ажиллагаа чухал ач холбогдолтой. Үүний тулд иргэдийн эрх зүйн ухамсар боловсролыг дээшлүүлдэг тогтолцоо чухал.

Нөгөө талд төр, засгийн зүгээс хүний эрхийг хангах материаллаг болон эрх зүйн баталгааг боловсронгуй болгох, төрөөс иргэдийн өмнө хүлээх хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, тасралтгүй сайжруулах шаардлагатай.

Үүний тулд хүний эрхийг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хүний эрхийг хангахад чиглүүлэх ялангуяа цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааг хүний эрхийг хангахад чиглүүлэх, хүний эрхэнд суурилсан хууль сахиулах үйл ажиллагаа явуулах, хүний эрхийн зарчмуудыг хангаж ажиллах эрх зүйн

орчин, нөхцлийг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Хүний эрхийг хангах нэг батлагаа нь цагдаагийн байгууллага, алба хаагчдын өөрсдийнх нь эрхийг хангаад зогсохгүй, иргэн байгууллага бусдын эрх ашиг сонирхолыг хамгаалах үзүүлэлтийг тэдний ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах явдал юм.

Хүний эрхийн зарчмын талаар “Хүний эрхийн олон улсын биллээр хамгаалагдсан эрх” Хүний эрхийн олон улсын билл болох дараах дөрвөн бичиг баримтад тусгасан байдаг^[121].

Иргэний Улс төрийн эрхийн тухай олон улсын протукол болон нэмэлт протукол, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн олон улсын протукол болон нэмэлт протоколд заасан эрхээ эдлэх нь түүнийг харьяалдаг улс тухайн олон улсын баримт бичгийг соёрхон баталсан, эдгээр бичиг баримтанд ажил хөдөлмөр эрхэлж буй хүн дор дурьдсан эрхийг эдлэнэ гэж заасан байна. Үүнд:

- Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, аль ч улсад оршин суух эрх;

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх хэвлэн нийтлэх эрх чөлөө;

- Эвлэлдэн нэгдэх;

- Хоол хүнс хувцас, орон байрыг оролцуулан амьдралын хүрэлцээтэй түвшинд аж амьдрах;

- Бие бялдарын болон оюуны эрүүл мэндээ хамгаалуулах дээд зэргийн байх;

- Сурч боловсрох эрх;

- Хөдөлмөрийн шударга аятай нөхцөлд ажиллах эрх;

- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага үйл ажиллагаанд оролцох эрх;

- Амралт эдлэх зав чөлөөтэй байх^[122] эрхүүдийг тус тус заасан байна.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлд хүний эрхийн талаар тусгаж өгсөн байдаг бөгөөд тэдгээр эрхүүд нь цагдаагийн алба хаагчдад хамаатай.

Мөн Цагдаагийн албаны тухай хуульд дээр дурьдсан хүний эрхийн зарчим болон Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүний эрхийн заалтууд туссан байдлыг судлан авч үзвэл.

Цагдаагийн албаны тухай хуулийн

¹²¹ Х.Виктор Кондэ.Хүний эрхийн Олон улсын нэр томъёоны гарын авлага,УБ хот 2016 он.184 дэхь тал

¹²² Х.Виктор Кондэ.Хүний эрхийн Олон улсын нэр томъёоны гарын авлага,УБ хот 2016 он.185 дэхь тал



5 дугаар зүйлийн 5.1-д заасан дараах заримд Хүний эрхийн талаар тусгаж өгсөн тухайлбал: “Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх” зарчмыг баримтална. Хэмээн заасан бөгөөд энэхүү зарчимд дурьдсан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчим ард иргэдийн эрх, эрх чөлөөний тухай асуудлыг голлон анхаарч үзсэн бөгөөд цагдаагийн алба хаагчдийн эрх эрх чөлөөний тухай асуудлыг орхигдуулсан нь цагдаагийн албаны тухай хуульд заасан Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлаар тодорхойлогдоно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 3-р зүйлд Цагдаагийн алба хаагчтай хамаарал бүхий этгээд гэдгийг “Цагдаагийн алба хаагчийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн болон дагавар, үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач, эзэг, ойлгоно” хэмээн тайлбарласан ба уг хуулийн 85-р зүйлийн 85.6-д “Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг цагдаагийн байгууллага хариуцна” хэмээн заасан алба хаагчдийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгаанд хамрах хүрээг өргөтгөн зааж өгсөн нь алба хаагчдийн төдийгүй тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хангах шинэлэг заалт болжээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р зүйлд “Цагдаагийн алба хаагч дээд шатны цагдаагийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, үндэслэлээ тайлбарлах эрхтэй”, “Цагдаагийн байгууллага, алба хаагчаар хуульд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно” хэмээн заасан нь алба хаагчаар хуульд заагаагүй үүрэг гүйцэтгүүлэх, хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх баталгааг зааж өгсөн нь Монгол Улсын Үндсэн Хуульд заасан “Халдашгүй чөлөөтэй байх” (Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн,

түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална) гэсэн хүний эрхийг хангах баталгаа болсон юм.

Цагдаагийн албанд анх томилогдож буй алба хаагчдыг Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаагийн тангараг өргүүлдэг бөгөөд уг тангарагын үгийг уг хуулийн 9-р зүйлд “Монгол Улсын иргэн би цагдаагийн албанд ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, алба хаагчийн ёс зүй, сахилга, албаны нууцыг чанд сахин, чин шударгаар ажиллаж, шаардлага гарвал амь биеэ үл хайрлан зүтгэхээ батлан тангараглая. Би энэ тангаргаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ” гэж тангараг өргөнө хэмээн заасан бөгөөд уг тангарагт “амь биеэ үл хайрлан зүтгэнэ” гэж заасан нь Монгол Улсын үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Амьд явах эрхтэй” гэсэн заалттай харшилдаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 66-р зүйлд Цагдаагийн албанд тавигдах шаардлага гэсэн зүйлд Цагдаагийн алба хаагчдийн боловсролын түвшинг харгалзан албан тушаалд томилох, дэвшүүлэн томилох талаар заалт бий. Үүнд “Цагдаагийн байгууллага цагдаагийн алба хаагч бүрд мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ”, “Цагдаагийн албан тушаалд тавигдах тусгайлан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, цагдаагийн албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ”, “Цагдаагийн байгууллагын тодорхой албан тушаалд анхлан томилох, алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилохдоо алба хаагчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, гаргасан амжилт, хувийн болон мэргэжлийн ёс зүйг үндэслэл болгож, албан тушаал эрхлэх шат дарааллаар томилох зарчмыг баримтална” гэж заасан нь сайшаалтай боловч цагдаагийн алба хаагчид тэр бүр боловсролын түвшингээ дээшлүүлэх магистр, докторын сургалтанд сургалтанд хамрагдах боломж хомс гагцхүү албаны мэргэшүүлэх ба давтан сургалтанд хамрагдах боломжтой байдаг нь дээрх хуулийн заалтын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.



Мөн Олон улсын эрх зүйн баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хязгаарласан дараах заалтууд байна. Үүнд: Цагдаагийн албаны тухай хуулийн “Алба хаагчийн эрх үүрэг” гэсэн 68-р зүйлийн 68.7-д “Хуульд заасан тохиолдолд удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихгүй байх үүрэгтэй; Цагдаагийн албаны тухай хуулийн 69.1.8. Нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх”, “Цагдаагийн албаны тухай хуулийн 84.5-д Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно” гэсэн заалтууд нь Иргэний Улс төрийн эрхийн тухай олон улсын протокол болон нэмэлт протокол, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн олон улсын протокол болон Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлд заасан Чөлөөтэй зорчих, оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, Эвлэлдэн нэгдэх гэсэн хүний эрхийн заалттай зөрчилдөж байгаа юм.

Цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх чиг үүргийг ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор тогтоох бөгөөд уг тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллагын дарга батлаж, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу үнэлж, дүгнэнэ гэж цагдаагийн албаны тухай хуульд заасан бөгөөд Төрийн албаны тухай хуульд зааснаар үнэлэж дүгнэхдээ үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж байгаа бөгөөд үр дүнгийн гэрээний үзүүлэлт нь Цагдаагийн алба хаагчдийн ажил дүгнэх үзүүлэлтээс өөр үзүүлэлтээр дүгнэж байгаа нь учир дутагдалтай.

Учир нь Цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээний үр дүнг харгалзан цагдаагийн алба хаагчийг зохих шатны сургалтад хамруулах, цалингийн нэмэгдлийг тогтоох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ хэмээн Цагдаагийн албаны тухай хуулийн 74-р зүйлд заажээ.

Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааны талаар Олон улсын эрх зүйн

баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүний эрхтэй нийцсэн дараах заалтууд хуульчлагджээ. Үүнд:

Цагдаагийн албаны тухай хуулийн 86.1-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно”, 86-р зүйлийн 86.3.1-д “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор” 86.8-д Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Мөн хуулийн 87 дугаар зүйлд заасан Эдийн засгийн баталгаа гэсэн зүйлд Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно, Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно, Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно.

Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно гэж заасан нь алба хаагчдийн зарим эдийн засгийн баталгааг хангаж өгсөн заалт болжээ.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 90-р зүйлийн 90.1-д Цагдаагийн алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн үндсэн амралт олгож, биеэр эдлүүлнэ.

90.2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

90.3. Ажлын зайлшгүй шаардлагаар

нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр хоногт цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгоно. Гэсэн заалт нь ээлжийн амралтаа эдлэж чадаагүй алба хаагчийн цалинг олгохоор заасан нь цагдаагийн алба хаагчдийн эдийн засгийн баталгааг хангах бас нэгэн заалт болсон ч зарим тохиолдолд уг хуулийн заалт биелэгдэхгүй байх явдал гарсаар байгааг бидний авсан судалгаанаас харж болно.


Судлаач бид Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах зорилгоор практикт ажиллаж буй цагдаагийн 311 алба хаагчаас анкет асуулгаар судалгаа авч дүн шинжилгээ хийв. Судалгаа авахдаа түүврийн аргыг ашиглан ажлын ачаалал, нутаг дэвсгэрийн онцлог шинжийг харгалзан Баянзүрх дүүргийн Цагдаагийн 1-р хэлтсийн 48 алба хаагч, Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1-р хэлтсийн 41 алба хаагч болон хөдөө орон нутагт ажиллаж буй 87 алба хаагч, бусад дүүргийн 135 алба хаагч нийт 311 алба хаагчаас анкет асуулга авч дүгнэв.

Судалгаанд оролцсон алба хаагчдыг ажилласан жилээр нь авч үзвэл 47% нь 6-10 жил, 25% нь 21 жилээс дээш цагдаагийн байгууллагад тогтвор суурьшилтай удаан жил ажилласан нь харагдаж байна. Алба хаагчдын насны байдлыг авч үзвэл 19 буюу 6 хувь нь 18-25 настай, 213 буюу 70 хувь нь 26-32 настай, 57 буюу 19 хувь нь 33-39 настай, 13 буюу 4 хувь нь 40-48 настай, 17 буюу 4 хувь нь 40-48 настай, 3 буюу 1 хувь нь 48-52 насны алба хаагчдыг судалгаанд хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 267 буюу 86 хувь нь эрэгтэй, 44 буюу 14 хувь нь эмэгтэй алба хаагчид байна. Алба хаагчдын 153 буюу 47 хувь нь өөрийн ажлаа сараар дүгнүүлдэг гэж хариулсан бөгөөд алба хаагчдын ажлыг улирал, хагас жил, бүтэн жилээр дүгнэдэг гэсэн хариулт 4-өөс 5 хувийг эзлэж байгаа нь алба хаагчдын ажлыг нээлттэй ил тод дүгнэдэггүйтэй холбоотой гэж үзэж болохоор байна. Мөн судалгаанд оролцогчдын 31 хувь нь дээрх бүх хугацаанд тайлан гарган өгч өөрийн ажлаа дүгнүүлж байсан нь харагдаж байгаа бөгөөд дунджаар судалгаанд оролцогчдын 43 буюу 14 хувь өөрийн ажлаа ил тод нээлттэй дүгнүүлээгүй нь ажиглагдаж байна.


График№1.Алба хаагчид үйл ажиллагаагаа

тайлагнаж буй хугацаа



Судалгаанд оролцогчдын 177 буюу 57 хувь нь өөрийн ажлаа сар бүр тайлагнаж бичгээр тайлангаа гаргаж өгдөг нь тухайн алба хаагчдын ажлыг сар бүр дүгнэх боломж бүрдэж байгаа бөгөөд сар, улирал, хагас жил, бүтэн жил гэх мэт тогтоосон хугацаанд алба хаагчид тайлангаа бичиж өгснөөр өөрийн ажлаа дүгнүүлдэг байна. Мөн амаар тайлан мэдээгээ өгдөг нь ажлыг бодиттой бус дүгнэх, удирдлагын субъектив хандлагыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг хүчин зүйлийг нэмэгдүүлдэг болох нь судалгаагаар харагдаж байна.

График№2.Алба хаагчид өөрийн хийсэн ажлаа бодиттой дүгнүүлж чаддаг эсэх



Судалгаанд оролцогчдын 55 хувь буюу 171 алба хаагч нь одоогийн ажил дүгнэх үзүүлэлтээр өөрийн ажлаа сар бүр 40-өөс 70 хувьтай дүгнүүлдэг гэж хариулсан нь одоогийн ажил дүгнэх үзүүлэлтэд алба хаагчдын хийж гүйцэтгэх ажлыг бүрэн хамаарсан ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэгт нь тохирсон ажил дүгнэх үзүүлэлтүүдийг тусгаж өгөх шаардлагатай болсон нь харагдаж байгаа бөгөөд нөгөө талаар өнөөгийн байдлаар алба хаагчдын хийж гүйцэтгэсэн ажлын 40-70 хувийг хамарсан ажил дүгнэх шалгуур үзүүлэлтээр тэдний ажлыг дүгнэж байна гэж үзэж дүгнэж болохоор байна.

Хэрэв бодитой дүгнүүлж чаддаггүй гэж үзвэл ямар шалтгаан байгааг дурьдана уу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын



35 буюу 108 алба хаагч нь ажлын чанарыг тооцдоггүй гэж хариулсан нь алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулж буй ажил арга хэмжээ нь чанаргүй нөгөө талаар алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд хийж гүйцэтгэх ажлыг дутуу тусгаж зарим үзүүлэлтийг ажлын гол чанар үр дүнгээр бус хэлбэр хөөсөн, тоон үзүүлэлт шалгууруудыг тусгасан болохыг нотлоно.


Мөн судалгаанд оролцогчдын 18 хувь буюу 55 алба хаагч нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэйгээ нийцдэггүй гэж хариулсан нь ажил дүгнэх үзүүлэлт боловсруулахдаа ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй нь уялдуулаагүй ихэнх тохиолдолд ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүргээс илүү ажил үүрэг гүйцэтгүүлдэг зарим тохиолдолд гүйцэтгэсэн ажил арга хэмжээ нь тухайн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгагдаагүй байна. Түүнээс гадна алба хаагчдын гол ажлыг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгаагүй, өөр гэнэтийн ажил гардагаас өөрийн ажлаа бодитой дүгнүүлж чаддаггүй гэсэн шалтгаанууд ажил дүгнэх үзүүлэлтийг засаж сайжруулах, ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажил үүрэгтэй нь нийцүүлэх шаардлагатай болсныг харуулж байна. Мөн тасаг нэгжийн төлөвлөгөөг оновчтой төлөвлөөгүйгээс алба хаагч өөрийн ажлаа бүрэн гүйцэтгэж чаддаггүй өөр алба хаагчийн эсвэл тухайн тасаг хэсгийн төлөвлөгөөнд тусгасан өөрийн ажлын байрны тодорхойлолтод тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэх шалтгаан болсоор байна.

Судалгаанд оролцогчдын 50 хувь буюу 156 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлт нь тухайн алба хаагчдын ажлыг дунд зэрэг хамаардаг гэж үзсэн нь алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг өөрчлөн алба хаагчдын дүгнэгдэхгүй орхигдоод буй ажлыг уг үзүүлэлтэд оруулахын сацуу ажлын байрны тодорхойлолт чиг үүрэгт нэмэлт өөрчлөлт оруулж алба хаагчдын ажлыг бүрэн хамааруулах арга хэмжээг авах шаардлагатайг харуулж байна.

Түүнээс гадна судалгаанд оролцогчдын 7 хувь буюу 22 алба хаагч нь дундаас бага, 18 хувь буюу 55 алба хаагч нь бүрэн хамаарч чаддаггүй гэж үзсэн нь алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусгасан үйл ажиллагаа нь огт нийцэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна. Нөгөө талаар удирдах албан тушаалтны зүгээс алба хаагчдын гүйцэтгэх ёстой чиг үүрэгт хяналт тавьж гүйцэтгэл үр дүнг тооцож байх нь бусад алба хаагчдаас ажлын хариуцлага алдах, ажлаа таслах, ажлаа хийдүүлэх, өөрийн ажлаа бусдаар гүйцэтгүүлэх зэрэгт хяналт тавьснаар судалгаагаар илэрсэн сөрөг тоо чанарыг бууруулах боломжтой байж болох юм.

Судалгаанд оролцогчдын 46 хувь буюу 143 алба хаагч одоогийн ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэх шаардлагатай, 12 хувь нь буюу 38 алба хаагч одоогийн ажил дүгнэх үзүүлэлтээс зарим үзүүлэлтийг хасах шаардлагатай, 27 хувь буюу 83 алба хаагч одоогийн ажил дүгнэх үзүүлэлтэд зарим үзүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн нь алба хаагчдын ажлыг бодитой дүгнэхгүй байх, алба хаагчдын хийсэн ажлыг бүрэн хамаарч чадахгүй байгааг харуулж байна. Нөгөө талаар алба хаагчдын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт яг таг 100% оновчтой байх боломжгүй гэхдээ аль болох оновчтой байхад ойртуулах шаардлагатай ингэхийн тулд салаа утгагүй байх, гүйцэтгэлийн шууд хамаарал зохистой байх, гүйцэтгэлийг хангалттай үнэлэх үндэслэл бүхий шалгууруудыг тогтоох нь шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох алхам болно.

График№3. Алба хаагчдын хүний эрхийн талаарх ойлголт




Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 139 буюу 44 хувь нь хүний эрхийн талаар хангалттай, 123 буюу 39.5 хувь нь хүний эрхийн талаарх ойлголт дутмаг, 31 буюу 9 хувь нь хүний эрхийн талаарх ойлголт хангалтгүй, 8 буюу 2 хувь нь хүний эрхийн талаар мэдэхгүй эзээн хариулсан нь цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байгаа бөгөөд ажил дүгнэх үзүүлэлтэд алба хаагчдын эрх болон иргэдийн эрхийг хангах зарчим, шалгуур үзүүлэлт одоогийн ажил дүгнэх үзүүлэлтэд хомс тусгагдсан болохыг дээрх үзүүлэлт харуулж байна.

Мөн алба хаагчдын 89 хувь буюу 267 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн ба судалгаанд оролцогчдын 11 буюу 33 алба хаагч нь хүний эрхийн зарчимд нийцэх шаардлагагүй гэж үзжээ. Судалгаанд хамрагдсан алба хаагчдын хүний эрхийн талаарх ойлголт хангалттай бус байгаа ч ажил дүгнэх үзүүлэлтэд хүний эрхийн зарчмыг тусгаж өгөх зайлшгүй шаардлага байна гэж судалгаанд оролцогчид үзсэн байна.

Судалгаанд оролцогчдын 17 хувь буюу 52 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцдэг, 41 хувь буюу 127 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд дунд зэрэг нийцдэг, 6 хувь буюу 18 алба хаагч ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд дундаас бага түвшинд нийцдэг, 36 хувь нь буюу 11 алба хаагч хүний эрхийн зарчимд огт нийцдэггүй гэж хариулжээ. Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцдэггүй гэсэн дүгнэлтэнд хүрч болох бөгөөд ажил дүгнэх үзүүлэлтэд хүний эрхийг хангасан заалт тусгаж өгөх, ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн олон улсын баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн Хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлага тулгарч байна.

График№4. Алба хаагчдын хөндөгдөж буй эрх ашиг



Судалгаанд оролцогчдын 19 хувь нь буюу 58 алба хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үг хэлэх хэвлэн нийтлэх эрх чөлөө зөрчигдөж байна гэж үзсэн ба энэ нь Цагдаагийн албаны тухай хууль, алба хаагчдын ёс зүйн дүрэмд заасан аливаа байгууллага хувь хүний нууцыг задруулахгүй байх, алба хаагч нийгмийн аливаа үзэгдэл үйл явдалд өөрийн хувь хүний санаа бодлоо илэрхийлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана, аливаа хэрэг маргаантай холбоотой асуудлаар өөрийн санаа бодлоо илэрхийлж болохгүй бөгөөд Цагдаагийн төв байгууллагын даргын батласан журмын дагуу хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран



ажиллах алба хаагч албан ёсны мэдээлэл хийнэ гэсэн тогтсон журам үйлчилдэгтэй холбоогүй байж болох бөгөөд тэдний санаа бодлыг сонсож эрх ашгийг нь хамгаалах үйл ажиллагаа хангалттай бус байгаатай холбоотой байж болох юм.

Мөн судалгаанд оролцогчдын багагүй хувь нь алба хаагч эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрх зөрчигдөж байна гэж үзсэн бөгөөд энэ нь шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 69-р зүйлийн 69.1.8 дахь хэсэгт заасан Нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, үлс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг хориглоно мөн хуулийн 69.1.10.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилогдсон ажилд очихгүй байх, ажил хаях, албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцохыг хориглоно гэсэн заалт үйлчилдэгтэй холбоотой.

Алба хаагчдын ажлын ачаалал, алба хаагчдын орон тооны дутагдалтай байдлаас шалтгаалан алба хаагчдын сурч боловсрох эрх зөрчигдсөөр байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 9 хувь нь буюу 28 алба хаагч сурч боловсрох эрх зөрчигдөж байна гэж үзжээ.

Нэг цагдаагийн газар хэлтэс ажиллаж буй алба хаагчдын 60-аас 65 хувийг Нийтийн хэв журам сахиулах болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй эргүүлийн цагдаа, харуулын цагдаа, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хорооны цагдаа, жолооч цагдаа, машинт эргүүлийн офицер, замын хөдөлгөөн зохицуулагч цагдаа зэрэг албан тушаал эзлэж байгаа бөгөөд дээр дурьдсан алба хаагчдын ажлын чиг үүрэг онцлог нь гудамж талбай, зам харгуй, албаны тээврийн хэрэгсэл дотор албан үүрэг гүйцэтгэдэг нь хөдөлмөрийн аятай тухай нөхцлөөр хангуулах эрх зөрчигдөх үндэс болж байна.

Судалгаанд оролцогчдын 10 буюу 31 алба хаагч хоол хүнс амьдралын хүрэлцээтэй түвшинд ажиллаж амьдрах эрх нь зөрчигдөж байгаа тухайгаа судалгааны явцад илэрхийлсэн бөгөөд нийт төрийн алба хаагчдын багагүй хувь орон сууцны, цалингийн болон өөр бусад зээлтэй байдаг нь амьдралын хүрэлцээтэй түвшинд

амьдрах эрх зөрчигдөхөд хүрч байна. Нөгөө талаар үнэ өсөх болон бусад эдийн засгийн бодлого үйл ажиллагаанаас шалтгаалж алба хаагчдын цалин нэмэхгүй байх, үнэ өсөх бүрт түүнд тохируулж цалин хөлс олгохгүй байгаа зэрэг нь нөлөөлөх боломжтой.

Түүнээс гадна судалгаанд оролцогчдын 6 буюу 18 алба хаагч ээлжийн амралт эдлэх эрх зөрчигдөж байна гэж үзсэн бөгөөд энэ нь алба хаагчдыг 1 сараас дээш хугацааны сургалтанд хамруулахдаа тэдний ээлжийн амралтыг захиргааны санаачлагаар ээлжийн амралт олгож тухайн жилдээ ээлжийн амралт эдлэх боломжийг хааж байгаагаа нь фокус бүлгийн ярилцлагад дурьдсан байдаг.

Судалгаанд оролцогчдын 12 хувь буюу 37 алба хаагч оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх зөрчигдөж байгаа тухай санал асуулгаар илэрхийлсэн бөгөөд энэ алба хаагчийг өөрийн ажилд шилжүүлэн томилох, сэлгэн ажилуулах, албан тушаал бууруулах, албан тушаал ахиулахдаа алба хаагчдын хүсэл зоригийг үл харгалзан төв орон нутгийн цагдаагийн газар хэлтэст томилдогтой холбоотой бөгөөд алба хаагчдыг төв орон нутагт томилох ажиллуулахдаа тэдний оршин суух эрх чөлөөг хүндэтгэн тэдний санал хүсэлтийг авч томилох шаардагатай байгаа.

Судалгаанд оролцогчдаас таны ажлыг дүгнэхдээ дор дурьдсан зарчмуудаас алийг нь баримталдаг вэ? гэсэн асуултанд алба хаагчдын гүйцэтгэсэн ажил, ажлын тоо, чанар нь эцсийн үр дүнтэй уялдаж алба хаагчдыг урамшуулах, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой гэж судалгаанд оролцогчдын 18 хувь буюу 55 алба хаагч үзсэн ба ажил дүгнэх үзүүлэлт эцсийн үр дүнтэй холбоотой байх, алба хаагчдыг урамшуулах хөгжүүлэхэд чиглэсэн байлгахын тулд чанарын ямар үзүүлэлтийг сонгон авч тусгах, ажлын чанарыг хэрхэн үнэлэх, ажлын эцсийн үр дүнг ямар хэлбэрээр тооцох зэрэг асуудлыг нарийн судлаж тогтоох хэрэгтэй^[123]. Нөгөө талаар ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих дээрх зарчмуудыг тусгахгүй байх нь хүний эрхийг зөрчих үндэс болоод зогсохгүй ажил дүгнэхтэй холбоотой сөрөг үр дагавар байнга гарсаар байх болно.

График№5. Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт

¹²³. Ажлын чанар гэдэг нь нийгмийн хөгжил, хүмүүсийн амьдралын хэрэгцээг тодорхой хэмжээгээр хангах, материалын болон оюун санааны баялгийг аль болох бага зардлаар бий болгоход оруулсан бодит хувь нэмэр, түүнд чиглэсэн зорилтот үйл ажиллагааны цогцолбор.



Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь алба хаагчдын өөрсдийнх нь эрхийг хангаад зогсохгүй цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа нь иргэдийг эрхийг хангахад чиглэгдэх ёстой байдаг талаар Хүний эрхийн конвенци, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссын Хүний эрхийг хангах практик хэмээх бүтээлд Хүний эрхийг хангах цагдаагийн практик үйл ажиллагаа, АНУ-ын Кимбала хотын цагдаагийн даргын ажил дүгнэх үзүүлэлт, АНУ-ын Хьюстон хотын цагдаагийн газрын цагдаагийн судалгааны төвийн гаргасан орон нутгийн цагдаагийн стратегийг хэрэгжүүлэхэд алба хаагчдын ажлыг дүгнэх үзүүлэлт хэмээх судалгааны бүтээлүүдэд тусгасан байдаг.

Баруун европын зарим улс орны цагдаагийн байгууллагын ажлыг иргэдийн эрхийг хэрхэн хангаж байгаагаар нь дүгнэж байгаа бөгөөд дээрх үзүүлэлтүүдийг алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгаж өгсөн байна.

Алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэх нь хүний эрхийг хангаж буй байдлын илрэл бөгөөд үүнийг санал асуулгаар тодруулсан байдлыг хүснэгтээр харуулъя. Үүнд:

Хүснэгт№1. Алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд тусгавал зохих үзүүлэлт хүснэгтээр

№	Хувилбар	Тоо	Хувь
а/. Гэмт хэргийг бууруулсан хувь		34	10.9
б/. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь		106	35
в/. Иргэдтэй зөв харилцдаг		46	15
г/. Мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэдэг		8	0.2
д/. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг		42	13.5
е/. Тулгарсан асуудлыг эв зүйгээр шийддэг		15	0.4
ё/. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал, түүний үр дүн		38	12.2
з/. Хохирогчдын эрхийг хангах арга хэмжээ авсан байдал		4	1.2
ж/. Хүний эрхийг зөрчлийг зохих байгууллагад мэдүүлсэн тоо		0	0
и/. Өөрийн санаачлагаар гүйцэтгэсэн ажил		30	9.4
й/. Объект субъектын судалгаа явуулсан байдал		12	0.3
к/. Эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтоосон байдал		59	19
л/. Дээрх бүгд тусгагдаагүй		40	12.8
м/. Дээрх бүгд тусгагдсан		42	13.5

Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлэхийн



тулд дээр дурьдсан үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах нь зүйтэй энэхүү үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан байдлыг дэлгэрүүлэн үзвэл НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссын Хүний эрхийг хангах практик хэмээх бүтээлд Хүний эрхийг хангах цагдаагийн практик хэмээх бүтээлд онц ноцтой гэмт хэрэг гаралтын бууралт, гэмт хэрэг илрүүлэлтийн түвшин, урьдчилан сэргийлэх арга хэмжээ байдал авсан үр дүн, хууль сахиулах ажлын бүтээмж, ялгаварлан гадуурхахгүй байх, мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэх, гэмт этгээдийг баривчилсан байдал, харилцааны соёл эзэмшсэн байдал, асуудлыг эв зүйгээр шийдвэрлэсэн байдал, биеийн хүч галт зэвсгийн зохистой хэрэглээг хангасан байдал, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байдал зэргийг хүний эрхийг хангах үйл ажиллагаа мөн гээд эдгээр үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан байна.

Түүнээс гадна Кимбала хотын цагдаагийн даргын ажил дүгнэх үзүүлэлт, АНУ-ын Хьюстон хотын цагдаагийн газрын Цагдаагийн судалгааны төвийн гаргасан орон нутгийн цагдаагийн стратегийг хэрэгжүүлэхэд алба хаагчдын ажлыг дүгнэх үзүүлэлт хэмээх судалгааны бүтээлүүдэд тус тус бичигдсэн байна.

Мөн Филиппиний Үндэсний цагдаа мөн дээрх зарчимтай ижил төстэй үзүүлэлтийг өөрсдийн боловсруулсан гарын авлагад "Хууль сахиулагчдын баримтлах олон улсын хүний эрхийн стандарт" гэсэн хэсэгт дараах үзүүлэлтүүдийг талаар дурдсан байна. Үүнд:

1. Эрх тэгш хамгаалалт үзүүлэх;
2. Бусдыг хүндэтгэн ажиллах;
3. Хүч хэрэглэх;
4. Тайван жагсаал, цуглааныг зохицуулах;
5. Аминд үл хүрэх зэвсэг хүч хэрэгсэл ашиглах;
6. Хууль ёсны дагуу гэмт хэрэгтнийг баривчлах;
7. Хоригдогчдын эрхийг хамгаалах;
8. Хоригдогчдод хүнлэг ёсоор хандах;
9. Шударга бус тушаалыг биелүүлэхээс татгалзах;
10. Хүний эрхийг үл хүндэтгэсэн зөрчлийг мэдүүлэх гэх мэт үзүүлэлт багтаасан байна.

Харин бидний авсан санал асуулгаар судалгаанд оролцогчдын 34 буюу 10.9 хувь нь гэмт хэргийг бууруулсан хувийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах нь зүйтэй гэж санал өгсөн нь оновчтой байна учир нь

хөдөө орон нутаг ялангуяа суманд ажиллаж байгаа алба хаагчдын ажлыг дүгнэхдээ гэмт хэргийг бууруулсан хувийг авч үздэггүй шалгасан хэргийн тоон үзүүлэлтийг авч үздэг, судалгаанд оролцогчдын 106 буюу 35 хувь нь илрүүлсэн гэмт хэргийн үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах гэж санал өгсөн бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны алба хаагчдаас бусад алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд гэмт хэргийг илүүлсэн хувь хэмжээг дүгнэх үзүүлэлт тусгагдаагүй байна.

Судалгаанд оролцогчдын 46 буюу 15 хувь нь иргэдтэй зөв харилцдаг, 15 буюу 0.4 хувь нь тулгарсан асуудлыг эв зүйгээр шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлтийг нэмж тусгах хэрэгтэй гэж үзсэн ба энэхүү үзүүлэлтийг нэмснээрээ алба хаагчдаас иргэдтэй харилцахдаа алдаа гаргахаас сэргийлэх, иргэдтэй харилцахдаа харицлааны зөрчил гаргах явдлаас сэргийлэх үзүүлэлт болдог бөгөөд энэ нь ёс зүйтэй цагдааг төлөвшүүлэх хөгшүүрэг болох юм.

Судалгаанд оролцогчдын 8 буюу 0.2 хувь нь мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэдэг, 42 буюу 13.5 хувь нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг гэсэн үзүүлэлтийг нэмэгдүүлэх гэж санал өгсөн нь цагдаагийн алба хаагчид хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэх, аливаа хэрэг маргаанд субъектив хандлагаар хандах, ашиг сонирхлын зөрчил үүсэх, эрүү шүүлт тулгах зэрэг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох урьдчилан сэргийлэх зорилготой шалгуур үзүүлэлтийг нэмж тусгах шаардлагатай гэж үзсэн нь оновчтой.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулсан байдал, түүний үр дүнг ажил дүгнэх үзүүлэлтэд нэмж тусгах гэж судалгаанд оролцогчдын 38 буюу 12 хувь үзжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг оновчгүй зохион байгуулах нь гэмт хэргийн гаралт ихсэх, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхийн тулд цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө зарцуулах, гэмт хэргийн илрүүлэлтийн түвшинд ахиц гарахгүй байх сөрөг хүчин зүйлүүд нэмэгдэх шалтгаан болно.

Энэхүү үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгаснаар цагдаагийн байгууллага алба хаагчдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөө дээшилж, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхэд шаардагдах цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүн хүчийг хэмнэх



ач холбогдолтой.

Судалгаанд оролцогчдын 4 буюу 1.2 хувь нь хохирогчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авсан бол ажил дүгнэх үзүүлэлтэд нэмж тусгах гэж үзсэн ба энэхүү үзүүлэлтийг тусгаснаар эрх ашиг нь зөрчигдсөн хохирогчийн эрхийг хамгаалах чухал үзүүлэлт бөгөөд хохирогчдын эрхийг хамгаалах болон хүний эрхийг хангах гол хүчин зүйл болно.

Судалгаанд оролцогчдын 12 буюу 0.3 хувь нь объектын судалгаа явуулах, мөн оролцогчдын 59 буюу 19 хувь нь эрэн сурвалжлагдаж буй хүн эд зүйлийг олж тогтоосон үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд нэмж тусгах санал өгсөн нь хариуцсан нутаг дэвсгэрийнхээ эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, түүнийг хянах, гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгаа бүртгэл хийж тэдгээрийг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ашиглах, улмаар гэмт хэрэг зөрчлийн улмаас алдагдсан хүн, эд зүйлийг эрэн сурвалжилж олж тогтоон цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх үзүүлэлт болно.

Судалгаанд оролцогчдын 40 буюу 12 хувь нь дээр дурьдсан үзүүлэлтүүд ажил дүгнэх үзүүлэлтэд огт тусгагдаагүй талаар саналаа илэрхийлсэн бөгөөд дээр дурьдсан үзүүлэлтүүдийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгаснаар цагдаагийн байгууллага алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрхийг хангах үндэс болох юм. Мөн судалгаанд оролцогчид “Хүний эрхийн зөрчлийг зохих байгууллагад мэдүүлсэн байдал” гэсэн үзүүлэлтийг ажил дүгнэх үзүүлэлтэд тусгах талаар огт санал өгөөгүй нь цагдаагийн алба хаагчид хүний эрхийг хангах талаар ямар нэгэн арга хэмжээ авахдаа хойрго ханддаг болох нь харагдаж байгаа бөгөөд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа бүхэлдээ хүний эрхийг хангахад чиглэгдсэн хүний эрхэнд суурилсан хууль сахиулах үйл ажиллагаа үгүйлэгдэж байна.

Мөн судалгаанд оролцогчид алба хаагчдын эрхийг хязгаарлах хүчин зүйл юу вэ? гэсэн асуултанд цагдаагийн албаны онцлог 199 буюу 64 хувь, 40 буюу 13 хувь нь байгууллагын эрх ашгийн үүднээс алба хаагчдын эрхийг хязгаарлах, зарим эрх зөрчих явдал гардаг гэж үзсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 65 буюу 21 хувь удирдах албан тушаалтны шахалт шаардлагаар өөрийн зарим эрхийг хязгаарлаж байна гэж үзжээ.

Иймд цагдаагийн байгууллагын албаны онцлог ажлын шаардлагаар алба хаагчдын эрхийг зөрчих, хязгаарлах явдлыг зогсоох шаардлагатай.

Хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үүрэг гүйцэтгэхэд хүний эрхтэй зөрчилддөг үү? Гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 195 буюу 63 хувь нь зарим хууль тогтоомж зөрчилддөг, 68 буюу 22 хувь нь зөрчилддөг, 46 буюу 15 хувь зөрчилддөггүй гэж үзжээ.

Зарим тохиолдолд цагдаагийн алба хаагчид хууль тогтоомж дүрэм журмын дагуу ажил үүрэг гүйцэтгэсэн нь хүний эрхийг зөрчих тохиолдол практикт цөөнгүй тохиолддог.

Энэ тухай судалгаанд оролцогчид: Байгууллагын дотоод дүрэм журам, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хууль хоорондоо зөрчилддөг, торгуулийн орлого норм хэмжээг тогтоон алба хаагчдыг уг норм хэмжээг гүйцэтгэхийг шаарддаг, зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн яллагдагчийн баривчлах явцад тэдний эрхийг зөрчих шаардлага гардаг, Гэмт хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиуд нь хоорондоо зөрчилддөг гэж үзжээ.

Дүгнэлт

Ажил дүгнэх үзүүлэлт нь цагдаагийн алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтонд заасан чиг үүрэгт нийцдэггүй, зарим ажил үүргийг ажил дүгнэх үзүүлэлтэд орхигдуулсан, зарим шалгуур үзүүлэлт нь тохиромжгүй, өөр өөр албан тушаалд ажиллаж буй алба хаагчдыг нэг үзүүлэлтээр дүгнэдэг, алба хаагчдын ажлыг бодиттой дүгнэдэггүй, ажлын үр дүнг тооцдоггүй, удирдлагын субьектив хандлага нөлөөлдөг, сарын ажил дүгнэх үзүүлэлт нь жилийн ажлыг дүгнэх үндэс болдоггүй зэрэг зөрчилдөөнтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд ажил дүгнэх үзүүлэлтийг сайжруулж, Хүний эрхийн түгээмэл тунхаг, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенци, Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүний эрх эрх чөлөөтэй уялдуулах шаардлагатай байна гэж товч дүгнэж болно.

Санал

Судлаач бид дээрх бүхнээс үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

•Гэмт хэрэг илрүүлсэн хувь, гэмт хэргийг бууруулсан хувь, иргэдтэй зөв харилцдаг, мөрдөн байцаалтыг шударга гүйцэтгэдэг, ёс



зүйн зөрчил гаргаагүй ажилласан, тулгарсан асуудлыг эв зүйгээр шийдвэрлэдэг, хуулийн дагуу ажилладаг, илүү цагаар ажилласан гэх мэт зарим шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэх;

- Зөрчил илрүүлэх, торгуулийн норм хэмжээ тогтоох, хутга мэс хураах, гэмт хэргийн талаар илтгэх хуудас бичиж өгөх гэх мэт зарим үзүүлэлтийг хасах;

- Ажил дүгнэх үзүүлэлтийг хүний эрхийн зарчимд нийцүүлж Internal Police Science Association (IPSA), UN Human Right High Commission, зэрэг олон улсын байгууллагаас гаргасан “World internal security police index”, “The assessing the performance index”—ийн дагуу боловсруулах;

- Гадаадын зарим орны Цагдаагийн байгууллага алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийг тогтоох үе шат, дүрэм журам, журмалсан үйл ажиллагааны тоо, хэмжээ хязгаар арга туршлагыг судалж нэвтрүүлэн өөрийн орны цагдаагийн байгууллага, алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг боловсронгуй болгох;

- Алба хаагчдын гүйцэтгэсэн ажлын тоо, чанар нь эцсийн үр дүнтэй уялдаж алба хаагчдыг урамшуулах, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байх зарчмыг Цагдаагийн албаны тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллганы журамд тусгаж өгөх гэх мэт.



МОНГОЛЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Ш.Тунгалаг

Хууль сахиулахын их сургуулийн магистрант,
ЦЕГ-ын Гадаадын харилцааны албаны ажилтан

Хураангуй:

Цагдаагийн байгууллагаас гадаад хамтын ажиллагааны хүрээнд алба хаагчдыг гадаадын улс орнуудад зохион байгуулагдах сургалт семинар бусад арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулж ирсэн. Энэ ажлын хүрээнд ямар сэдэв чиглэл зонхилдог, хичнээн, ямар түвшний алба хаагчид хамрагддаг болохыг түүхчлэх, харьцуулах аргыг ашиглан судалж тогтооход чиглэгдэнэ.

Судалгааны үндсэн дээр цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний санал боловсруулах явдал юм.

Түлхүүр үг:Гадаад томилолт, сэдэв чиглэл, алба хаагч

Удиртгал

Аливаа байгууллагын оршин тогтнох гол үндэс нь байгууллагын удирдлага менежмент, зөв бодлого чиглэл, чадварлаг боловсон хүчин, төсөв хөрөнгө байдаг. Харилцан хамаарал бүхий энэхүү хүчин зүйлүүдийн нэг болох чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, тэднийг сургаж бэлтгэх асуудлыг байгууллага бүр өөр өөрийн нөөц, боломжид тулгуурлан зохион байгуулж байдаг. Цагдаагийн байгууллагаас алба хаагчдын мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр гадаадын цагдаагийн байгууллага, олон улсын байгууллагатай хэрхэн хамтран ажиллаж, ямар сэдэв чиглэлийн сургалтад ямар түвшний алба хаагчдыг хамааруулдаг болохыг судалж тогтоох нь цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход тодорхой үр дүнгээ өгөх юм. Иймээс энэ асуудлыг судалгааны тодорхой арга аргачлалыг ашиглан шинжлэх ухаан, хууль зүйн үндэслэлтэй санал дүгнэлт боловсруулах цаашлаад Цагдаагийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх нэг төрлийн арга замыг тодорхойлохыг зорьсон болно.

1. Цагдаагийн байгууллагын гадаад харилцааны түүхэн хөгжил

Цагдаагийн байгууллага буюу хуучнаар Цагдан сэргийлэх байгууллага 1932 оноос Дотоодыг хамгаалах яам, 1936 оноос Дотоод явдлын яам, 1956 оноос Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяанд тус тус ажиллаж байхдаа гадаадын улс орны цагдан сэргийлэх байгууллагуудтай яамдын түвшинд харьцаж, хамтран ажиллаж байжээ.

Тухайн цаг үед ЗХУ-тай голчлон харилцаж, ялангуяа 1930-аад оны дунд үеэс ЗХУ-ын цагдан сэргийлэх байгууллагын салбар чиглэлийн удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг олноор урьж авчран, заавар зөвлөгөө авч, ажилтнуудыг сургаж бэлтгэх, мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ажлыг түлхүү зохион байгуулж, ДЯЯ-ны сайдын 1936 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 11 тоот тушаалаар ЗХУ-ын Цагдан сэргийлэх байгууллагаас уригдаж ирсэн Петр Мошкинийг Цагдан сэргийлэх газрын сургагчаар, 1940 оны эхээр ЗХУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын мэргэжилтэн Н.Анцыфуровыг УЦСЕГ-ын зөвлөхөөр, Н.Вочеровыг гүйцэтгэх хэлтсийн сургагчаар, Н.Риховыг паспортын хэлтсийн сургагчаар, Н.Воронковыг уурын тэрэгний хэлтсийн сургагчаар, Н.Гришенийг Дорнод аймгийн цагдан сэргийлэхийн сургагчаар, Т.Точоновыг Сэлэнгэ аймгийн цагдан сэргийлэхийн сургагчаар, Н.Меденийг боловсронгуй төлөөлөгчөөр^[124] үүнээс өмнө буюу ДХГ-ын даргын 1932 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 66 тоот тушаалаар Улсыг аюулаас хамгаалах байгууллагад ажиллаж байсан боловсронгуй төлөөлөгч Феодоровыг^[125] цагдан сэргийлэхийн сургагчаар тус тус томилж байсныг гадаад харилцааны ажлын эхлэл гэж үзэж болох юм.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны улам өргөжин хөгжиж цагдан сэргийлэхийн ажилтнуудыг ЗХУ-д сургаж бэлтгэх ажлыг 1950-иад оны дунд үеэс эрчимтэй зохион байгуулж, 1954 оноос 25 хүнийг 2 жилийн курст, улмаар 1956 оноос Цагдан сэргийлэхийн дээд сургуульд 4, дунд сургуульд 25 хүнийг сургаснаар цаашид жил бүр хүн явуулан сургах боломж нөхцлийг нээж^[126], гадаад орны буюу ЗХУ-ын цагдан сэргийлэх байгууллагын арга туршлагыг

¹²⁴ Думбурай А. 1999, "Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил", УБ, 126, 146 дахь тал

¹²⁵ Тагнуулын ерөнхий газрын архив, УЦСЕГ-ын хөмрөгийн удирдлагын байнга хадгалах баримтын данс, С1-ХН7, Д1, 6 дахь тал

¹²⁶ Думбурай А. 1999, "Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил 1", УБ, 176 дахь тал



газар дээр очиж судлах, танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, мэргэшсэн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх болжээ.

Гадны мэргэжилтнүүдийг урьж авчрах, алба хаагчдыг гадаадад туршлага судлуулах, гадаадад зохион байгуулагдах арга хэмжээнд алба хаагчдыг оролцуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажил бэхжиж улмаар Цагдаагийн байгууллага гадаад харилцаа хариуцсан нэгжтэй болж үйл ажиллагааны хувьд агуулга, цар хүрээ улам баяжиж, гадаадын цагдаагийн байгууллага, олон улсын байгууллагатай дараах байдлаар харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- гэрээ хэлэлцээр, протокол, санамж бичиг байгуулах буюу эрх зүйн орчин бүрдүүлэх, судлах

- удирдлагын түвшний айлчлалыг зохион байгуулах, гадаадын цагдаагийн байгууллагын удирдлага, бүрэлдэхүүнийг хүлээн авах

- олон улсын хурал зөвлөгөөн, сургалт семинарыг дотооддоо зохион байгуулах

- гадаад улсад зохион байгуулагдах сургалт, хурал зөвлөгөөн бусад арга хэмжээнд алба хаагчдыг оролцуулах, бэлтгэл ажлыг хангах

- цагдаагийн байгууллага, нэгж албадын удирдлага, алба хаагчидтай хийх гадаадын цагдаагийн байгууллага, олон улсын байгууллагын удирдах албан тушаалтан, ажилтнуудын уулзалт зохион байгуулах

- цагдаагийн алба хаагчдын гадаадад зохион байгуулагдах сургалтанд хамруулах, туршлага судлуулах

- гадаадын цагдаагийн байгууллагын мэргэжилтэн, багш нарыг урьж авчрах, хамтарсан сургалт зохион байгуулах

- төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, туршлага судлах зэрэг өргөн цар хүрээг хамарсан үйл ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллагын гадаад харилцааны өнөөгийн байдал

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой чиг үүргээс гадна Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн ЦЕГ-ын даргын чиг үүргийн 21.1.7 “цагдаагийн байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах”^[127], Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/55^[128] тоот тушаалаар батлагдсан ЦЕГ-ын

¹²⁷ Цагдаагийн албаны тухай хууль төрийн мэдээлэл 2017, №5-нийтлэгдсэн

¹²⁸ ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн 2013-2015 оны архивын материал, “Хууль зүйн сайдын тушаал, хамтарсан

нэгж, албадын бүтэц, чиг үүргийн “3.3.26-д Гадаад харилцааны ажил хариуцсан нэгж нь гадаад орны цагдаагийн байгууллага, олон улсын бусад байгууллагаатай харилцах, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг боловсруулах, шинээр гадаад улс орнуудтай харилцаа тогтоох асуудлыг судалж, санал боловсруулах, шийдвэрлүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах”, мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гадаадын байгууллага, иргэнтэй харилцах журам^[129] / код131/ юм.

Чиг үүрэгт тусгагдсан ажлуудад дээр дурдсан бүхий л үйл ажиллагаанууд хамаарах бөгөөд гадаад арга хэмжээнд өнөөгийн байдлаар хамгийн их цаг хугацаа шаардагддаг, гадаад хамтын ажиллагааны илрэл болсон арга хэмжээний нэг нь гадаад томилолт буюу алба хаагчдыг гадаадын улс оронд зохион байгуулагдах сургалт семинар, хурал зөвлөгөөнд оролцуулах ажил байдаг. Иймээс судалгааны ажлыг энэ чиглэлд хандуулж, Цагдаагийн байгууллагаас сүүлийн жилүүдэд ямар чиглэлд, хичнээн алба хаагчийг, ямар хугацаагаар гадаад арга хэмжээнд хамруулсан болох, үр дүн нь ямар байгааг тодорхойлохыг зорилго.


Цагдаагийн байгууллагаас гадаад харилцааны чиглэлээр сүүлийн 10 жилд буюу 2007-2016 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын нийт 631 гадаад томилолтын тушаалыг боловсруулж батлуулснаас 245 буюу 38,8% нь сургалт семинар, 126 буюу 19,9% нь хурал зөвлөгөөн, 90 буюу 14,2% нь айлчлал, айлчлалын бүрэлдэхүүн, 170 буюу 26,9% нь бусад арга хэмжээний тушаал байна.

тушаалууд”

¹²⁹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам 2016.



Гадаад томилолтын тушаалын ангиллыг



графикаар харуулбал:

Үүнээс харахад нийт тушаалын 1/3 хувийг гадаад улсад зохион байгуулах сургалт семинарт алба хаагчийг хамруулах ажил эзэлсэн байх ба хурал зөвлөгөөн хэдийгээр бага хувьтай харагдаж байгаа мэт боловч, энэхүү хоёр арга хэмжээний онцлог давуу тал нь алба хаагчдад гадаадад мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, гадаад орны туршлага судлах боломжийг аль аль нь олгодог оршдог.

Ингэснээр 2007-2016 онд нийт 1776 алба хаагч гадаадад томилолтоор ажиллуулснаас сургалт семинар, хурал зөвлөгөөнд нийт 1132 алба хаагчийг оролцуулж, гадаадын цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх арга туршлагатай танилцах, харилцан туршлага солилцох, сэдвийн хүрээнд орчин үеийн чиг хандлага, ололт амжилтыг сонсож мэдэх боломжийг бүрдүүлж ажиллажээ гэж дүгнэж болох байна.

Гадаад томилолтын 26,9%-ийг бусад арга хэмжээ эзэлсэн байх ба үүнд цагдаагийн тусгай техник хэргэслийн үзэсгэлэнд оролцох, гэрээ хэлэлцээр байгуулах, урлаг соёл, спортын арга хэмжээнд оролцох, бараа материал худалдан авах, хэрэг шалгахар явсан томилолтуудыг хамааруулсан.

Дээрх тоо баримтаас үүдээд ямар сэдэв чиглэлээр, ямар түвшний алба хаагчид гадаадын хичнээн улсад арга хэмжээнд хамрагдсан бол гэсэн асуулт гарч ирсэн тул

үүнийг мөн дараах байдлаар судалж үзсэн болно.

2007-2016 онд гадаадад сургалтанд хамрагдсан байдлыг сэдвээр нь ангилж үзэхэд

- үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх
- кибер гэмт хэрэг, мэдээлэл технологи
- эдийн засгийн гэмт хэрэг, авилга, санхүү, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх
- удирдлага менежмент, хууль эрх зүй
- мэргэжлийн сургалт

зэрэг сэдвүүд зонхилох хэсгийг эзэлсэн тул тоо судалгааг үүний дагуу гаргасан. Мэргэжлийн сургалт гэдэгт албаны нохой, тусгай бэлтгэл тактик, гүйцэтгэх ажил, электрон тагнуул, тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх зэрэг тухайн чиглэлийн мэргэшсэн алба хаагчдад зориулсан сургалтуудыг, харин бусад сургалтад НҮБ-ын иргэний цэргийн ажилтны, гадаад хэлний, интерполын, гэр бүлийн хүчирхийллийн, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам хамгаалах чиглэлийг тус тус хамааруулжээ.



Гадаад сургалтанд 2007-2016 онд хамрагдсан сэдвийг графикаар харуулбал:





График мэдээллээс харахад дээрх хугацаанд нийт 245 сургалт гадаадад зохион байгуулагдсанаас 23,2% нь тус тус үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болон удирдлага менежмент, хууль эрх зүйн, 14,3% нь мэргэжлийн, 8,9%-ийг аюулгүй байдлын, үлдсэн 30,4 хувийг кибер, мэдээллийн технологи, эдийн засаг, санхүү, авилга, мөнгө угаах болон сургалтууд тус тус эзэлжээ

Сургалтын сэдвийн тухайд зохион байгуулагч улс болон байгууллагын онцлог, дэлхий нийтийн гэмт хэргийн чиг хандлага, цаг үеийн нөхцөл байдалтай уялдаж жил бүл харилцан адилгүй байдаг ч сүүлийн жилүүдэд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг (үүнд: хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах, терроризм г.м)-тэй тэмцэх, байгууллага, үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын чиглэлээр алба хаагчдыг сургалтад илүүтэй хамруулсан буюу нийт сургалтын 46,4%-ийг эзэлсэн нь нэг талаас зохион байгуулагч тал эдгээр чиглэлд илүү олон санал, хүсэлт ирүүлснийг илтгэж байна. Нөгөө талаас манай байгууллагын хувьд ч бусад улсын нэгэн адил үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, удирдлага менежмент, эрх зүйн боловсролын чиглэлээр алба хаагчдыг сургаж бэлтгэх, гадаадын туршлагыг судлах,

дэлхийн нийтийн чиг хандлагатай танилцах шаардлага, эрэлт хэрэгцээ байсныг харуулж байна.

Судалгааны бас нэг хэсэг нь гадаад томиллолт, сургалт семинарт хамрагдах бие бүрэлдэхүүний байдалд чиглэгдсэн бөгөөд 2007-2016 онд нийт 1776 алба хаагч гадаадад томиллолтоор явснаас 835 буюу 47% нь дунд шатны, 787 буюу 44,3% нь удирдах шатны, 153 буюу 8,6% нь бага бүрэлдэхүүн байжээ. Бие бүрэлдэхүүний гадаад арга хэмжээнд хамрагдсан байдлыг графикаар харуулбал:



Дунд шатны болон удирдах шатны бие бүрэлдэхүүний тухайд дээр дурдагдсан сэдэв чиглэлд сургалт семинар, хуралд зөвлөгөөнд хамрагдсан бол бага бүрэлдэхүүний тухайд урлаг, спорт, хамтарсан бэлтгэл сургалтын



чиглэлээр гадаад арга хэмжээнд хамрагдсан байна.

2007-2016 онд жил бүр харилцан адилгүй байх боловч дийлэнхдээ 25-30 гаруй улсад зохион байгуулагдсан арга хэмжээнд цагдаагийн алба хаагчдыг хамруулсан байх бөгөөд үүнээс ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, БНТУ, АНУ, БНСВУ, Тайланд, Япон, Канад зэрэг улс орнууд голчилжээ. Эдгээр улс орнууд нь төсөв санхүүгийн хувьд боломжтой, гэмт хэрэгтэй тэмцэх арга туршлага сайтай, хууль эрх зүйн орчин хөгжсөн улс орнууд юм.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл Цагдаагийн байгууллагаас гадаад арга хэмжээ буюу гадаад томилолтын дийлэнх хэсгийг сургалт семинар, хурал зөвлөгөөнд алба хаагчдыг оролцуулах ажил эзэлдэг байх ба үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг буюу хүн худалдаалах, терроризм, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, удирдлага менежмент, хууль эрх зүйн орчинг сайжруулах сэдэв чиглэлд дунд болон удирдах шатны алба хаагчдыг ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ зэрэг гадаадын улс орнуудад түлхүү хамруулжээ. Дурдагдаж буй сэдэв чиглэл нь яалтгүй ч үгүй дэлхий нийтийн өнөөгийн анхаарлын төвд байдаг асуудал учраас манайх ч мөн үүнийг дагажээ гэж үзэж болох ба хамрагдаж буй бие бүрэлдэхүүний тухайд сэдэв, чиглэлийг хариуцдаг алба хаагчид нь удирдах болон дунд шатны алба хаагчид байдагтай холбоотой. Цаашид ч дээрх сэдэв чиглэлийг үргэлжлүүлэн хөгжүүлж, зохион байгуулагч талын болоод Цагдаагийн байгууллагын төсөв хөрөнгө, нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд тулгуурлан илүү олон алба хаагчийг хамруулах нь зайлшгүй хийгдэх ажлуудын нэг.

Гадаадын улс оронд зохион байгуулагдаж буй сургалт семинар, хурал зөвлөгөөнд эрэлт хэрэгцээгээ үндэслэн зохих түвшний алба хаагчдыг хамруулсныг цаг үеийн шаардлагыг ханган, боломж нөхцлийг бүрдүүлэн ажиллажээ гэж дүгнэж болохоор байна.

Нөгөөтэйгүүр Цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг^[130] бүхий албад, алба хаагчид, мөн түүнчлэн удирдах шатны бие бүрэлдэхүүн удирдлага менежментийн сургалтад оролцуулсан нь дээрх хуульд заасан Цагдаагийн байгууллагын бусад чиглэлүүд-

олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах зэрэг алба, ажилтнуудыг гадаад арга хэмжээнд хамруулах, энэ чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх эрэлт хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж байна.

Иймээс цаашид олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах болон бусад чиглэлээр алба хаагчдыг гадаад арга хэмжээнд хамруулах талаар гадаадын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах ажлыг эрчимжүүлж, хөгжүүлэхийн тулд дараах ажлуудыг хийх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

-тухайн салбар чиглэлд алба хаагчдыг гадаад арга хэмжээнд хамруулах саналыг холбогдох нэгжүүд боловсруулж, удирдлагад танилцуулж чиглэл авах

-түүнийг нь үндэслэн гадаад харилцааны асуудал хариуцсан нэгж, гадаадын цагдаагийн байгууллагатай харилцах, хамтран ажиллах, санал хүргүүлэх явдал юм.

Ингэснээр энэ асуудлыг шийдвэрлэх бага ч болов боломж бүрдэх бөгөөд үүнээс гадна зөвхөн гадаадад сургах биш гадаадын мэргэжилтнийг урьж авчрах олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам хамгаалах болон бусад чиглэлээр алба хаагчдыг дотооддоо сургаж бэлтгэх, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх боломжтой юм.

Ном зүй

- 1.Цагдаагийн албаны тухай хууль, 2017
- 2.Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, шийдвэрүүд
- 3.ЦЕГ-ын даргын тушаал шийдвэрүүд
- 4.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
- 5.Думбурай А.1999, “Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт”, УБ,
- 6.Тагнуулын ерөнхий газрын архивын хавтаст материал
- 7.ЦЕГ-ын архив,
- 8.Гадаад харилцааны хэлтсийн тайлан

¹³⁰ Цагдаагийн албаны тухай хууль



ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХҮҮХДИЙН ӨМЧЛӨХ ЭРХИЙН БАТАЛГААГ ХАНГАХ НЬ

PROVIDING THE OWNERSHIP RIGHT OF CHILDREN

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах
орны Өвөр Монголын их сургуулийн

докторант **Р.Батням**

Batnyam R. Ph.D candidate of Inner
Mongolia University Inner Mongolia
Autonomous Region of China

Монгол Улсад ардчилал ялснаас хойш эдүгээ хорь гаруй жилийн нүүрийг үзээд байгаа билээ. Энэ хугацаанд манай нийгмийн амьдралын бүхий л салбарт ихээхэн өөрчлөлт гарсан. 1992 онд шинэ ҮНДСЭН ХУУЛЬ баталснаас хойш эрх зүйн салбарыг хамарсан үндсэн өөрчлөлт нь шинэчлэлт гарч улс орныг маань урагш хөгжин дэвшихэд нилээд хэмжээгээр нөлөөлж байгаа юм. Үүний дотор хүүхдийн эрхийг хамгаалах тухай асуудлууд өргөн хүрээтэй тавигдах боллоо.

1989 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталж, 1990 онд Монгол Улс нэгдэн орсон “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-д “...18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон байдаг. Энэ конвенцид хүүхдийн эрхийг маш өргөн агуулгаар тусгаж, хамгаалан баталгаажуулсан. Хүүхдийн эрхийн энэ өргөн хүрээтэй асуудлууд дотроос зөвхөн хүүхдийн өмчлөх эрхийн тухай асуудлыг хөндөн ярих гэж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын иргэний хуульд зааснаар 14 хүртэлх насны хүүхэд иргэний эрх зүйн зарим, 14-18 хүртэлх насны хүүхэд иргэний эрхийн хэсэгчилсэн чадамжтай байдаг. Өөрөөр хэлбэл, хүүхэд иргэний эрх зүйн зарим харилцаанд оролцож тодорхой эрх эдэлж, хуульд заасан тохиолдолд зарим үүрэг хүлээдэг. Үүнээс үндэслэн хүүхэд өмчлөгч субъект байж болох уу? гэдэг асуудал гарна.

1952 онд баталсан БНМАУ-ын Иргэний хуулийн 42 дугаар зүйлд мал аж ахуй буюу хөдөө аж ахуйн доторхи хөдөлмөрийн ашиглалтанд байгаа бэлчээр хадлангийн ба

тариалангийн эдэлбэрүүд газрыг нийтээр ашиглах эрх, түүнчлэн мөн гэр болон бусад барилгууд мал, хөдөө аж ахуйн багж хэрэгсэл, хоол тэжээлийн зүйлс гэр орны хэрэглэлүүд ба бусад эд хошлуудыг уул аж ахуйн бүх гишүүд нь нас, эрэгтэй эмэгтэйг нь харгалзахгүйгээр нийтээр өмчлөх эрхтэй болно...” гэж заасан нь хүүхэд өмчлөгч насанд хүрэгчдийн нэгэн адил субъект болж байжээ.

1994 оны шинэчлэн найруулсан Иргэний хуулийн 95 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Гэрлэгчдийн хуваарьт эд хөрөнгөнөөс бусад эд хөрөнгө гэр бүлийн гишүүдийн дундаа хамтан өмчлөх өмчлөлд байна...” гээд мөн зүйлийн хоёр дахь хэсэгт: “...Гэр бүлийн эд хөрөнгийг гэрлэгчид болон гэр бүлийн бусад гишүүд дундаа хамтран өмчлөх эрхтэй...” гээд мөн хуулийн 250 дугаар зүйлд “... хөлслөгчтэй хамт аж төрж байгаа нөхөр болон эхнэр, хүүхэд эцэг эхийг түүний гэр бүлийн гишүүн гэж үзнэ...” хэмээн заасан нь хүүхдийг хамтран өмчлөх дундын өмчийн субъект болохыг тодорхойлж байсан. Харин 1999 оны Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулиар “гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүнийг ойлгоно гэсний дагуу 2002 оны иргэний хуулиар гэр бүлийн гишүүдийн хуваарьт эд хөрөнгийн тухай нарийвчлан зохицуулж өгснөөр хүүхэд хуваарьт эд хөрөнгөтэй болох нөхцлийг бүрдүүлж өгсөн юм.

Гэвч 1994 оны Иргэний хуулийн 95 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “...Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн нь дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах захиран зарцуулах адил тэгш эрх эдэлнэ. Гэрлэгчид гэр бүлийн бусад гишүүн нь уг эрхээ хэрэгжүүлэхдээ гэр бүлийн насанд хүрсэн гишүүнтэй тохиролцох ба үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулахдаа тэдгээрийн зөвшөөрлийг бичгээр авна. Энэ шаардлагыг биелүүээгүй хэлцэл хүчин төгөлдөр бус байна...” гэсэн заалтыг 2002 оны Иргэний хуулийн 128.2 дугаар зүйлээр “...Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг



авна..." 128.3-т "...Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 128.2-т заасны дагуу зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна..." гэж заасан нь 1994 оны хуулийн үзэл баримтлалыг тэр чигээр нь тусгасан байна.

Иймд дээрх хуулийн заалтын дагуу хүүхэд үйлдлийнхээ учир холбогдлыг тэр бүр бүрэн дүүрэн ухаарах чадваргүй учираас тэдгээрийн хувьд өмчлөлийн зүйлээ захиран зарцуулах эрх нь хязгаарлагдмал байдаг хэдий ч гэр бүлийн эд хөрөнгийн хувьд эдлэх эрх, ашиг сонирхол нь гэр бүлийн насанд хүрсэн гишүүний үйлдэлээр зөрчигдөж болохыг үгүйсгэхгүй. Жишээ нь: Хан-Уул дүүргийн дугаар хорооны иргэн А эхнэрээ нас барсны дараа өөрийн насанд хүрээгүй 8-14 насны 3 хүүхдийг гэрээсээ хөөж гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө болох хашаа байшингаа зарж мөнгийг нь хувьдаа ашиглажээ.

Энэ тохиолдолд иргэн А насанд хүрээгүй хүүхдийн зөвшөөрлийг заавал авах шаардлагагүй түүний гэр бүлд өөр насанд хүрсэн байхгүй учир өөрөө дангаараа дундын эд хөрөнгөө мэдэн захиран зарцуулна.

Өөрөөр хэлбэл, нэг талаас хүүхэд эд хөрөнгө дундаа хамтран өмчлөгч субъект мөн болохыг хуулиар хүлээн зөвшөөрсөн боловч өмчлөлийн зүйлийг захиран зарцуулахад оролцдоггүй. Ингэснээр хүүхдийн эд хөрөнгийн эрх, ашиг сонирхол хохирч байна.

Хэдийгээр эцэг, эх хүүхдийнхээ хууль ёсны төлөөлөгч болохын хувьд тэдний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй боловч амьдралд зарим эцэг, эх нийгмийн өмнө хүлээсэн үүргээсээ ухарч бяцхан ирээдийн эрх ашгийг хохироход хүрдэг тохиолдол цөөнгүй.

Ийм нөхцөлд хүүхдийн эрхийг хамгаалах өөр субъект байх шаардлагатай бөгөөд хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд хяналт тавьж, тэднийг төлөөлөн эрх ашгийг нь хамгаалах нэн тэргүүний шаардлага юм.

1963 онд БНМАУ-ын Иргэний хуульд зааснаар хүүхэд гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмчийн субъект болдоггүй байна.

Хүүхэд гэр бүлийн дундын хөрөнгийг бүрдүүлэхэд тэр бүр оролцдоггүй. Харин эцэг эх нь үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргийнхээ дагуу хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх амьжиргааны эх үүсвэрээр хангах, 18 нас хүртэл нь аж ахуйн ухаалаг эрэлт хэрэгцээг нь хангах үүрэгтэй. Энэ тухай Гэр бүлийн хуулийн 55 дугаар зүйлд: "... Насанд хүрээгүй

буюу насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадвараа алдаж тэжээн тэтгэх өөр хүнгүй байгаа хүүхдээ эцэг, эх нь тэжээн тэтгэх үүрэгтэй....." гэж заажээ. Иймээс хүүхэд эцэг эхээрээ тэжээн тэтгүүлж байгаа утгаараа гэр бүлийн эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж, үр шимийг нь хүртэж байх нь зүйд нийцнэ.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар насанд хүрээгүй иргэн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах; өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх зэргээр захиран зарцуулах эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжтой.

Үүнээс үзэхэд, насанд хүрээгүй хүмүүс хуваарьт эд хөрөнгөтэй байж болох мэт боловч хуваарьт эд хөрөнгө нь гагцхүү дээр заасан хэдхэн төрлөөр хязгаарлагдах ёсгүй юм.

Мөн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд өмчтэй байж болно гэсэн нь бас хүүхэд хуваарьт эд хөрөнгөтэй байж болох боломжийг хуульчилсан боловч эдийн засгийн суурь харилцааг зохицуулж байгаа Монгол Улсын хуульд энэ асуудал нарийн зохицуулалтгүй орхигджээ.

Монгол Улсын Иргэний хуульд гэрлэгчидийн хуваарьт эд хөрөнгийн тухай зохицуулсан болохоос бус хүүхдийн хуваарьт эд хөрөнгийн тухай тусгайлан тусгаагүй байдаг.

Энэ хуулиар бага насны болон насанд хүрээгүй хүмүүс өөрсдийн хөдөлмөрийн үр дүн болон гоц авъяас чадвараараа төрөл бүрийн уралдаан тэмцээнд оролцон өндөр шагнал хүртэх, бэлэглэл өв залгамжлалын журмаар хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө олж авсан бол тэдгээрийн эд хөрөнгө нь гэр бүлийн эд хөрөнгө болдог билээ.

Дээрх үндэслэлээр олж авсан бүх эд хөрөнгийг хүүхдийн хуваарьт эд хөрөнгөд хамруулж уг эд хөрөнгийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь уг хүүхдийн эрх ашигт нийцүүлж эрхлэн явуулах нь зөв болов уу?

Зах зээл өндөр хөгжсөн зарим улс оронд, тухайлбал, Германд хүүхдийн хуваарьт эд хөрөнгийн эрхийг хуулиндаа нарийвчлан зохицуулж баталгаажуулжээ. Хэрэв эцэг, эх нь хүүхдийнхээ хуваарьт эд хөрөнгийг түүний



эрх ашигт нийцүүлэх зорилгоор ашиглан, захиран зарцуулсан гэж үзвэл эрх бүхий этгээдийн /Хүүхдийн эрхийг хамгаалах байгуулага төрөл төрөгсөд/ нэхэмжлэлээр шүүх тухайн хүүхдийн эд хөрөнгийн эрхийг сэргээж эцэг эхийнх нь хувьд хүүхдээ төлөөлөх болон түүний эд хөрөнгийг эрхлэн хөтлөх эрхийг нь хязгаарлаж эрх бүхий өөр этгээдийг томилдог.

Хүүхдийн хуваарьт эд хөрөнгө нь түүний ирээдүйд эзлэх байр суурь, амьдралын хэрэгцээг хангах баталгаа нь болох учираас хүүхдийн эрх ашгийг ийнхүү төрөөс хуульчилан баталгаажуулж, хамгаалан зохицуулдаг байна. Мөн манай улсын анхны иргэний хуулинд хүүхдийг асран хамгаалах этгээдийг томилох тухай, түүнчлэн хүүхдийн эд хөрөнгийг эрхлэн гүйцэтгэхэд нь тодорхой хязгаарлалт хийж өгчээ. Жишээ нь: Анхны иргэний хуулийн 4 дүгээр зүйлд 18 нас хүрээгүй хүүхдийг асрамжлан хамгаалваас зохих этгээдүүдийн харьяалалд хамруулсанаар энэ хуулийн 24 дүгээр зүйлд "...Асрамжлан хамгаалах хүмүүсээс тэрхүү хамгаалж буй бүхий хөрөнгөнөөс төлөөлөн бусад дор бэлэглэх зэргээр сүйтгэж үл болно....." гэсэн заалт мөн хүүхдэд мөн хамаарч байгаа юм.

Мөн хуулийн 25 дугаар зүйлд "Аливаа асрамжлан хамгаалах хэргийг гүйцэтгүүлэхээр томилогдсон хүмүүс тэрхүү хэргийн байдалын тухайг улирал бүрийн эцэс дор эрх биш тодорхой данс үйлдэж зохих газар мэдүүлэн хянуулваас зохино." гэсэн нь хүүхдийн эд хөрөнгийг манай улсын анхны Иргэний хууль маань хамгаалж ирсэн нь одоогийн Иргэний хуулиас оновчтой зохицуулалттай байжээ.

Түүнчлэн, дээрх зүйлүүдэд заасан зохицуулалтуудыг зөрчсөн, эсвэл уг эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээдүүдийг шүүн таслах газар нь тодорхой хэмжээний цээрлэл үзүүлэх буюу хүүхдийг хохиролгүй болгох хүртэл зохицуулалт хийж байжээ.

Гэтэл одоо манай улсад эдгээр зохицуулалт хангалтгүй учир хүүхдийн эрх ашигийг төрөөс хамгаалдаг, мөн түүний эд хөрөнгийг нь бүртгэн, эзэмшил, ашиглал эрхлэн хөтлөхөд нь хяналт тавьдаг этгээд бий болоогүйгээс хүүхдийн эрх ашиг хохирсоор байна.

Ийм хяналт тавьдаг эрх бүхий этгээдийг томилж, тэдгээрийн үйл ажиллагаа холбогдох харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Үүнтэй

холбогдуулан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч болох эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагааг хянах этгээдийн эрх зүйн байдлыг Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд тусгах;

2.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн хуваарьт эд хөрөнгийг хүүхдийн эрх ашгийн төлөө худалдах, барьцаалах, арилжих зэргээр бусдын өмчлөлд бүр мөсөн шилжүүлэхээр захиран зарцуулах зайлшгүй шаардлагатай бол Хүүхдийн эрхийг хамгаалах байгуулага буюу шүүхийн зөвшөөрөлтэйгээр тэдгээр байгууллагын хяналтын дор гүйцэтгэж байхаар Иргэний хуульд тусгах;

3.Эрх бүхий байгууллага, шүүхийн зөвшөөрөлгүй бусдын өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг хүүхдийн эрх ашгийн үүднээс олж авсан этгээдээс биет байдлаар нь буцаан гаргуулах, боломжгүй бол буруутай эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигчээр нөхөн төлүүлэх энэ тохиолдод гуравдагч этгээдээр учирсан хохирлыг мөн буруутай эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцахаар Иргэний хуульд тусгах-зэрэг болно.

Ном зүй

- 1.Монгол Улсын Үндсэн хууль 1992
- 2.БНМАУ-ын Иргэний хууль 1925
- 3.БНМАУ-ын Иргэний хууль 1952
- 4.БНМАУ-ын Иргэний хууль 1963
- 5.БНМАУ-ын Гэр бүлийн тухай хууль 1973
- 6.Монгол Улсын Иргэний хууль 1994
- 7.Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль 1999
- 8.Монгол Улсын иргэний хууль 2002
- 9.Германы иргэний хууль 1991
- 10.Е.А.Суханова "Гражданское право" 1994
- 11.Д.Наранчимэг. "Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцаа-орчин үеийн хандлага". УБ., 1996
- 12.Д.Наранчимэг. "Иргэний эрх зүйн үндсэн асуудал". УБ., 1998
- 13.Т.Мөнхжаргал. "Иргэний эрх зүй / ерөнхий, тусгай анги/". УБ.,1998

